





Монголбанкны ерөнхийлөгч Очирбатын ЧУЛУУНБАТ

## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮГ

Эрхэмсэг ноёд хатагтай нараа,

Монголбанкны үйл ажиллагааны 2002 оны жилийн тайланг эрхэм уншигч танд толилуулахад таатай байна.

Мөнгө санхүүгийн бодлогын хэрэгжилтийн хувьд 2002 он нь томоохон алхам хийсэн үр дүнтэй жил байлаа. Инфляци анх удаагаа жилийн 1.6 хувьтай гарсан нь Монгол улс шилжилтээ эхэлсэн 1991 оноос хойшхи хамгийн бага түвшинд хүрсэн үзүүлэлт юм. Төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байж Монгол Улсын гадаад валютын нөөц 284.5 сая ам.доллар буюу импортын 22.4 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд хүрсэн нь урьд өмнө байгаагүй өндөр хэмжээ юм.

Иргэд, бизнес эрхлэгчдээс үндэсний мөнгөн тэмдэгт Монгол төгрөг, Монголын банк санхүүгийн салбарт өндөр итгэл найдвар хүлээлгэсэн нь нийт хадгаламж, харилцахын хэмжээ эрс өсөхөд, банкнаас гадуурхи мөнгөний нийт мөнгөнд эзлэх хувь хэмжээ багасахад нөлөөлөв. Банкууд зээлийн чанараа сайжруулах, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, зах зээлийн өрсөлдөөнд амжилт олох замаар энэ итгэлийг бататгах боллоо. Банк бус санхүүгийн байгууллагуудын хувьд ч санхүүгийн зуучлалын гүнзгийрэлд өөрийн гэсэн байр сууриа эзэлж дорвитой хувь нэмрийг оруулж байна.

Актив болон зээлийн хэмжээгээр улсдаа хамгийн томд орох Худалдаа Хөгжлийн банк гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдад амжилттай хувьчлагдсан нь Монголын банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн 2002 оны хамгийн том үйл явдал болсон гэж Монголбанк үзэж байна.

Хөдөө орон нутаг дахь банкны салбарын тоо нэмэгдэж, хамрах хүрээгээ өргөжүүлсэн бөгөөд гол ачааллыг үүрч байгаа ХААН банкны үйл ажиллагаа улам тогтвожин сайжирч байна. Хадгаламжийн банкны ажилд ч мэдэгдэхүйц ахиц дэвшил гарлаа.

Банк санхүүгийн салбарын хувьд ахиц дэвшил их байгаа хэдий ч бодлогын болон бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж шийдэх олон асуудал биднийг хүлээж байна. Эдийн засгийн тогтвожилтыг гүнзгийрүүлэн баталгаажуулах, зээлийн хүртээмжийг өргөжүүлэн санхүүгийн зуучлалд иргэд, бизнес эрхлэгчдийг өргөнөөр татан оролцуулах, хүүгийн өндөр түвшинг аажмаар буулгах, хөдөөд санхүү банкны үйлчилгээг ойртуулах, урт болон дунд хугацааны зээл олгох, банкуудаас санхүүгийн шинэ бүтээгдэхүүний үйлчилгээ нэвтрүүлэх ажиллагааг эрх зүйн зохицуулалтын үүднээс дэмжих зэрэг асуудлуудыг шийдэхэд Монголбанк өөрийн хүчин чармайлтыг гарган ажиллах болно.

Гүнээ хүндэтгэсэн,

Очирбатын Чулуунбат  
Монголбанкны Ерөнхийлөгч

Улаанбаатар хот, 2003 он



<b>1. ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ</b>	<b>8</b>
<b>2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ</b>	<b>24</b>
<b>3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ</b>	<b>52</b>
<b>4. БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ</b>	<b>66</b>
<b>5. ТӨВ БАНКНЫ УЙЛ АЖИЛЛАГАА</b>	<b>80</b>
<b>6. БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ</b>	<b>112</b>
<b>7. МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ</b>	<b>116</b>
<b>8. АУДИТОРЫН ТАЙЛАН</b>	<b>122</b>
<b>9. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД</b>	<b>152</b>



## **1. ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ**

<b>1.1.</b>	<b>Эдийн засгийн чиг хандлага болон бодлогын асуудлууд</b>	<b>8</b>
<b>1.2.</b>	<b>Дэлхийн зах зээлийн ханш, хүү</b>	<b>18</b>
<b>1.3.</b>	<b>Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ</b>	<b>20</b>

## 1. ДЭЛХИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

### 1.1. Эдийн засгийн чиг хандлага болон бодлогын асуудлууд

Дэлхийн эдийн засгийн өсөлт хөгжил АНУ, Европын холбоо, Япон зэрэг улсуудаас хамаардаг. Дээрх улс орнуудын худалдаа, аж үйлдвэрлэл 2001 оны сүүлээс (2001 оны эцэс, 2002 оны I улирал) дахин өсч, нийт эдийн засгийн байдал нь сэргэж эхэлсэн ч цаашид үргэлжлэх эсэх нь тодорхой бус байна. Тухайлбал, дэлхийн эдийн засагт нөлөө бүхий АНУ-ын мөнгөний ханш суларснаас үнэт цаасны индексүүд огцом унаж, санхүүгийн зах зээл мэдэгдэхүйц хүндрэлд оржээ. Мөн хөгжиж буй орнуудын, ялангуяа Θөмөнг Америк болон Туркийн санхүүжих нөхцөл доройтсон, АНУ, Европын холбооны улсуудын эдийн засгийн үзүүлэлтүүд хүлээгдэж байснаас доогуур гарсан нь дэлхийн эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

Дэлхийн эдийн засгийн сэргэлт цаашидаа үргэлжлэх хандлагатай байгаа ч 2002 оны хоёрдугаар хагас болон 2003 онд өсөлт урьд нь тооцоолсноос доогуур байх төлөвтэй байна. Мөн эдийн засгийн цаашидын төлвийн эрсдэл дийлэнхдээ өсөх хандлагатай байна. Хөгжингүй орнуудын макро эдийн засгийн бодлого нь үнийн өсөлтийн дарамт буурснаар өнөөгийн чиг хандлагаа удаан хугацаагаар хадгалах хэрэгтэй болов. Хэрэв тодорхой үзүүлэлтүүдээс эдийн засгийн сэргэлт удааширсан шинж тэмдэг илэрвэл мөнгөний бодлогыг дахин сулруулах асуудал хэд хэдэн (7 орчим) орнуудад яригдана.

Тайлант оны эхнээс АНУ-ын эдийн засгийн хөгжлийг даган дэлхийн худалдаа, аж үйлдвэрлэлд ахиц гарч сэргэж эхэлсэн нь 9 дүгээр сарын 11-ний өдрийн үйл явдлын дараах үеэс хэрэгжүүлсэн мөнгөний болон төсвийн эрч хүчтэй бодлого мөн түүхий нефтийн үнэ 2001 онд буурсантай холбоотой юм. 2002 оны эхний улиралд Хойд Америк, Ази дахь хөгжиж буй орнуудын эдийн засаг харьцангуй хурдацтай өсч байсан хэдий ч, хоёрдугаар улирлаас Азиас бусад бүсүүдэд суларчээ. Түүний зэрэгцээ хөгжингүй улсуудын хувьд эдийн засгийн цаашидын өсөлтөд нь чухал нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх магадлал хангалтгүй байна. Аж үйлдвэржсэн орнуудад үйлдвэрлэлийн ашгийн мэдээллийг урьдын тооцоолсноос багасгасан, эдийн засгийн цаашидын тогтвортой өсөлтөд эргэлзэх, нягтлан бодох бүртгэл болон аудитын ажилд итгэх итгэл буурсан зэргээс санхүүгийн зах зээлүүд З дугаар сарын сүүлээс мэдэгдэхүйц суларч, хэлбэлзэлтэй хэвээр байна. Зах зээлийн тодорхойгүй байдал, эрсдэлийн өсөлтөөс шалтгаалан Засгийн газрын болон өндөр зэрэглэлийн баталгаа сайтай арилжааны бондын эрэлт нэмэгдсэний зэрэгцээ инфляцийн дарамт бага байгаа нь урт хугацааны зээлийн хүү буурахад нөлөөлжээ.

Валютын зах зээл дээр америк долларын евро болон иентэй харьцах ханш суларсан нь АНУ-д хөрөнгө оруулах сонирхол буурсан, мөн жилээс жилд нэмэгдсээр байгаа тус улсын урсгал дансны алдагдалд гадаадын хөрөнгө оруулагчид санаа зовж эхэлснийг харуулж байна.

## Хүснэгт 1. Дэлхийн эдийн засгийн тойм (жилийн өөрчлөлт, хувиар)

	2000	2001	2002 <sup>1</sup>
Дэлхийн үйлдвэрлэл	4.7	2.2	2.8
Хөгжингүй орнууд	3.8	0.8	1.7
Үйлдвэрлэл хөгжсөн томоохон орнууд	3.4	0.6	1.4
Бусад хөгжингүй орнууд	5.3	1.6	2.6
Европын холбоо	3.5	1.6	1.1
Шинээр аж үйлдвэржсэн Азийн улсууд	8.5	0.8	4.7
Хөгжих буй орнууд	5.7	3.9	4.2
Шилжилтийн эдийн засагтай орнууд	6.6	5.0	3.9
Дэлхийн худалдааны хэмжээ (бараа, үйлчилгээ)	12.6	-0.1	2.1
Импорт			
Хөгжингүй орнууд	11.8	-1.3	1.7
Хөгжих буй орнууд	15.9	1.6	3.8
Шилжилтийн эдийн засагтай орнууд	13.4	11.7	6.9
Экспорт			
Хөгжингүй орнууд	12.0	-1.1	1.2
Хөгжих буй орнууд	15.0	2.6	3.2
Шилжилтийн эдийн засагтай орнууд	14.7	5.9	5.3
Гол нэрийн түүхий эдийн үнэ (америк доллараар)			
Газрын тос болон газрын тосны бүтээгдхүүн	57.0	-14.0	0.5
Шатахууны төрлийн бус түүхий эд	1.8	-5.4	4.2
Хэрэглээний барааны үнэ			
Хөгжингүй орнууд	2.3	2.2	1.4
Хөгжих буй орнууд	6.1	5.7	5.6
Шилжилтийн эдийн засагтай орнууд	20.2	15.9	11.3
Лондонгийн банк хоорондын захын хүү (6 сараар)			
Америк долларын хадгаламж	6.6	3.7	2.1
Японы иенын хадгаламж	0.3	0.2	0.1
Еврогийн хадгаламж	4.6	4.1	3.4

<sup>1</sup> Урьдчилсан тооцоо

Дэлхийн эдийн засгийн сэргэлт АНУ-ын эдийн засгийн байдлаас хүчтэй хамааралтай хэвээр байна. Тэр тусмаа Европын улсууд хараахан бие даан тогтвортой өсөх боломжгүй, Япон улсын дотоод эрэлт банк санхүү болон үйлдвэрүүдийн хүндрэлээс шалтгаалан хязгаарлагдмал байгаа нь АНУ-ын гүйцэтгэх үүргийг чухалчлахад хүргэж байна.

Ойрхи Дорнодын тогтвортой байдал алдагдаж түүхий нефтийн үнэ өсөөд байна. Үнийн өсөлт нь хэр хурдтай, удаан хугацаагаар үргэлжлэхээс шалтгаалан дэлхийн эдийн засгийн өсөлт хөгжилтөд шууд бөгөөд шууд бус замаар ноцтой саад учруулж болох юм.

Хөрөнгийн зах зээл тогтвортгүй байгаа бөгөөд цаашдаа унах магадлалтай байна. 1990-ээд оны хувьцааны үнийн хий хоосон хөөрөгдөл хэвэндээ орсон хэдий ч сүүлийн үед ихээр гарч буй нягтлан бодох бүртгэл, аудитын шударга бус үйл ажиллагааны шуугианы улмаас хөрөнгө оруулагчдын дунд итгэл буурч, үнийг хэт бууруулах хандлага ихсэх төлөвтэй байна. Хөрөнгийн зах зээлийн уналт цаашдаа санхүүгийн байгууллагуудын үйл ажилгаанд бэрхшээл учруулж болзошгүй юм.

## *AНУ*

Тус улсад 1990-ээд онд амжилттай хэрэгжүүлсэн татварын бодлого, сүүлийн жилүүдэд эрчимтэй, зөв хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үр дүнд 2000, 2001 оны эдийн засгийн уналт нь түүхэн дунджаас харьцангуй зөвлөн, богино хугацаанд болж өнгөрлөө. Энэ нь мөн 2001 оны эцэс, 2002 оны эхний хагаст гарсан бүтээмжийн өсөлт, бодит цалингийн өсөлттэй холбоотой байна. Дотоодын хэрэглээ 2 дугаар улирлаас буурч, импорт өссөн нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлтийг удаашруулжээ. Мөн 3 дугаар сарын сүүлээс хөрөнгийн зах зээл суларсан нь эдийн засгийн тогтвортой өсөлттэд сөрөг нөлөө үзүүлэв. Урт хугацааны хүүний түвшин буурсан, америк долларын евро, иентэй харьцуулсан ханш суларсан зэрэг эдийн засагт зерэг нөлөө үзүүлэх хандлагууд гарсан хэдий ч цаашдын өсөлт дотоод эрэлт, хөрөнгө оруулалтын хэмжээнээс шууд хамаарах төлөвтэй байна. Эдийн засгийн өсөлт удааширч байгаа болон үнийн өсөлтийн дарамт доогуур байгаатай холбогдуулан АНУ-ын Төв банк эдийн засгийн өсөлтийг инфляциас чухалчилж үзэн хүүний түвшинг бууруулах алхамыг хийлзээ. Татварын бууралт, 9 дүгээр сарын 11-ний өдрийн үйл явдлаас хойшихи нэмэлт зарлага нь дотоод эрэлтийг хэвэнд нь байлгахад чухал нөлөө үзүүлсэн ч төсвийн тэнцлийг алдагдуулж, төсвийн алдагдал нь ДНБ-ий 1.75 хувьд хүрнэ гэж судлаачид үзэж байна. АНУ-ын төсвийн алдагдал нь бусад аж үйлдвэржсэн улсуудын хэмжээнээс харьцангуй бага ч гэсэн тэтгэврийн насын хүмүүсийн тоо өссөөр байгаа болон дотоодын хуримтлалыг сайжруулах эрмэлзэл их байгаа нөхцөлд улсын төсвийг бизнесийн нэг мөчлөгт багтаан тэнцвэртэй байдлыг эргэн сэргээх нь чухал байна.

## *Европын холбооны улсууд*

Европын холбооны орнуудад эдийн засгийн сэргэлт Хойд Америк, Азийн хөгжиж буй орнуудынхаас харьцангуй удаан явагдаж байна. 2001 оны сүүлээс экспортын өсөлт, импортын бууралтаас шалтгаалан цэвэр экспортын хэмжээ ихэссэн нь эдийн засгийн байдлыг бага зэрэг дээшлүүлэхэд нөлөөлжээ. Харин импортын хэмжээ багассан нь дотоод эрэлтийг сул хэвээр байлгахад хүргэж байна.


Цаашид тус бүс нутгийн эдийн засгийн өсөлттэд нэмэр оруулах хэд хэдэн хүчин зүйл байна. Тухайлбал, орлогын өсөлт, инфляцийн бууралт, хөдөлмөрийн зах зээлийн тогтвортой үйл ажиллагаа зэргээс шалтгаалан хэрэглээ өсөх явдал юм. Мөн АНУ-аас дээгүүр явааар байгаа үйлдвэрлэлийн ашиг цаашидаа өсөх тутам хөрөнгө оруулалт нэмэгдэх төлөвтэй байна.

Евро бүсийн ДНБ 2002 онд 0.9 хувиар, 2003 онд 2.3 хувиар өснө гэсэн тооцоо гарчээ. Харин гадаад эрэлт буурах, эсвэл европийн ханш чангарах тохиолдолд цэвэр экспортын өсөлт сулрах талтай юм. Мөн Европын холбооны орнуудын зах зээл дэх хувьцааны нийт үнэлгээ болон хувьцаа эзэмшигч хувь хүмүүсийн тоо АНУ-ынхаас харьцангуй цөөн хэдий ч 2000 оноос хойш евро бүсийн

Зураг 1. Дэлхийн бодит ДНБ-ий өсөлт



Зураг 2. Дэлхийн инфляци



Зураг 3. Дэлхийн зах зээлийн богино болон урт хугацааны хүү



хөрөнгийн захууд АНУ-ыг бодвол илүү хурдтай уналтад орсон байна. Европын холбооны орнуудын эдийн засгийн харилцан адилгүй бүтцийн хэлбэр, төсвийн байдалтай уялдан эдийн засгийн өсөлт ч өөр өөр байна. Энэ нь түүхий нефтийн үнэ өссөн, олон улсын худалдаа багассан зэрэг дэлхийн хэмжээнд гарсан гэнэтийн өөрчлөлтүүд улс бүрт өөрөөр нөлөөлснөөс болсон байна. Томоохон орнуудаас Герман, Италид дотоод эрэлт сүл байгаа бөгөөд Франц улсын хувьд саяхан хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэлт ажилгүйдлийг багасгаснаар байдал харьцангуй дээр байна. Эдийн засгийн өсөлт сулрах үед инфляци Европын Төв банкнаас тогтоосон 2 хувийн дээд хэмжээтэй ойролцоо буюу арай дээгүүр байсан бөгөөд үйлдвэрлэлийн бүтээмж буурахтай зэрэгцэн цалин өсч, нэгж хөдөлмөрийн үнэ нэмэгдэж байгаа нь анхаарвал зохих асуудал болж байна. Европийн ханш өндөр хэвээр байж, бүтээмж мөчлөгийн дагуу буцан өсч, нефть, хүнсний бүтээгдэхүүний үнийн түр зуурын өсөлт хэвэндээ орсон тохиолдолд инфляци багасч болох юм.

### *Япон*

Сүүлийн арван жилд гарсан 3 дахь буюу хамгийн удаан үргэлжилсэн уналтын улмаас эдийн засгийн үйл ажиллагаа доод цэгтээ тулсан бөгөөд 2002 оны эцэст болон 2003 онд бага зэргийн өсөлт гарах магадлалтай байна. Арван жилийн турш зогсолтод ороод байгаа эрэлтийг хэрхэн хурdasгах нь Япон улсын хувьд хамгийн чухал асуудал болоод байна. Үүнд дан ганц макро эдийн засгийн зохистой бодлого явуулах бус, удаан хугацааны турш бэрхшээл учруулж байгаа эдийн засгийн бүтцийг өөрчлөх талаар шийдвэртэй алхам хийх шаардлагатай юм. Энэ алхамыг юуны түрүүнд мөнгөний эргэлт, хөрөнгө оруулалт болон эдийн засгийн бусад үйл ажиллагаанд саад учруулж байгаа банкны салбарт хийх нь чухал юм. 2002 оны эхний хагаст дотоод эрэлт харьцангуй сүл байсан ч экспорт өсч эдийн засгийн үйл ажиллагаа хурdasч байна. Дефляци жилийн 1 хувьтай байгаа нь бодит өрийн хэмжээг ихэсгэж байна.

Бодит үйлдвэрлэл 2002 онд 0.5 хувиар буурах, харин 2003 онд 1 хувиар өсөх тооцоо гарчээ. Энэ нь иргэдийн хэрэглээ 2002 оны сүүлийн хагаст өсөх, мөн оны эцэст хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх зэргээс шалтгаалан дотоод эрэлт аажмаар өснө гэсэн хандлага дээр тулгуурласан төсөөлөл юм. Дотоод эрэлт өсөхийн зэрэгцээ импорт өсч, иенийн ханш чангаснаас шалтгаалан цэвэр экспортын ДНБ-д оруулах хувь хэмжээ багасах хандлага гарч болзошгүй юм. Хувийн хэрэглээнд гарсан өсөлтийн зарим хэсэг нь төсвийн гүйцэтгэлээр нөхөгджээ. 2002 оны сүүл хэсэгт төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ багасах хандлагатай байна. Сүүлийн арван жилийн турш эрх баригчид эдийн засгийн бүтцийн сүл талуудын талаар шийдвэртэй алхам хийхийн оронд аажмаар өөрчлөх бодлого явуулж ирсэн бөгөөд 2001 онд сонгогдсон ерөнхий сайд Коизумигийн Засгийн газар Японы эдийн засгийн үндсэн бэрхшээлүүдийг давж гарах өргөн хүрээтэй бодлого санал болгожээ. Энэ бодлогод банкны салбарыг шинэчлэх, төсвийн тэнцлийг тэнцвэржүүлэх, үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөх зэрэг арга хэмжээнүүд орсон юм.

### Шигтгээ 1. Шилжилтийн эдийн засагтай орнуудын бодит ДНБ-ий өсөлт

Дэлхийн эдийн засагт гарч байгаа удаашралт нь шилжилтийн эдийн засаг (ШЭЗ)-тай орнуудад харьцангуй багаар нөпөөлсөн болон эдгээр улсууд өмнө хэрэгжүүлсэн өөрчлөлт, шинэчлэлтийнхээ үр шимийг хүртэж эхэлснээр эдийн засаг нь тогтворжиж, сүүлийн жилүүдэд тогтвортой өсөлттэй байна. (ШЭЗ-тай улсуудын сүүлийн 4 жилийн дундаж өсөлт 3.0-5.5 хувь байв.)

		1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Төв болон зүн Европ, Балтийн улсууд	Хорват	6.8	6.0	6.5	2.5	-0.9	2.9	3.8	3.5
	Чех	5.9	4.3	-0.8	-1.0	0.5	3.3	3.3	2.5
	Эстон	4.3	3.9	9.8	4.6	-0.6	7.1	5.0	4.0
	Унгар	1.5	1.3	4.6	4.9	4.2	5.2	3.8	4.0
	Латви	-0.9	3.7	8.4	4.8	2.8	6.8	7.7	4.0
	Литва	3.3	4.7	7.3	5.1	-3.9	3.8	5.9	5.2
	Польш	7.0	6.0	6.8	4.8	4.1	4.0	1.0	1.0
	Словак	6.7	6.2	6.2	4.1	1.9	2.2	3.3	3.5
	Словени	4.1	3.5	4.6	3.8	5.2	4.6	3.0	2.7
	ТЗЕБҮ	5.4	4.7	5.0	3.6	2.8	4.0	2.5	2.3
Зүн-Өмнө Европын улсууд	Албани	13.3	9.1	-7.0	8.0	7.3	7.8	6.5	6.0
	Босни Герцогевин	20.8	86.0	37.0	9.9	10.6	4.5	2.3	3.0
	Болгар	2.9	-9.4	-5.6	4.0	2.3	5.4	4.0	4.0
	Югослав	6.1	7.8	10.1	1.9	-18.0	5.0	5.5	3.0
	Македон	-1.2	1.2	1.4	3.4	4.3	4.6	-4.1	2.0
	Румын	7.1	3.9	-6.1	-5.4	-3.2	1.8	5.3	3.5
	ЗӨЕҮ	6.4	3.5	-0.5	-0.7	-3.4	3.6	4.5	3.6
	Армени	6.9	5.9	3.3	7.3	3.3	6.0	9.6	8.0
	Азербайжан	-11.8	1.3	5.8	10.0	7.4	11.1	9.9	8.8
	Беларусь	-10.4	2.8	11.4	8.4	3.4	5.8	4.1	3.0
Тусгаар Тогтоносон Улсуудын Хамтын Некөрлийн	Гурж	2.4	10.5	10.8	2.9	3.0	2.0	4.5	3.5
	Казакстан	-8.2	0.5	1.7	-1.9	2.7	9.8	13.2	7.6
	Киргиз	-5.4	7.1	9.9	2.1	3.7	5.1	5.3	2.0
	Молдав	-1.4	-5.9	1.6	-6.5	-3.4	2.1	6.1	3.5
	Орос	-4.1	-3.4	0.9	-4.9	5.4	8.3	4.9	4.1
	Тажикистан	-12.5	-4.4	1.7	5.3	3.7	8.3	10.3	7.0
	Туркменистан	-7.2	-6.7	-11.3	5.0	16.0	17.6	12.0	13.5
	Украин	-12.2	-10.0	-3.0	-1.9	-0.2	5.9	9.1	4.5
	Узбекистан	-0.9	1.6	2.5	4.4	4.1	4.0	4.5	2.5
	ТТУХН	-4.9	-3.4	1.0	-3.7	4.5	7.9	5.9	4.4
Шилжилтийн эдийн засагтай орнууд	Шилжилтийн эдийн засагтай орнууд	-0.2	0.1	2.3	-1.0	3.0	5.5	4.2	3.4
	Монгол	6.3	2.4	4.0	3.5	3.2	1.1	1.0	3.9

ШЭЗ-тай улсуудын эдийн засгийн өсөлт 2002 онд өмнөх оныхоос саарчээ. Ялангуяа, Төв болон Зүүн Европ болон Балтийн улсуудад (2001 онд 2.5%, 2002 онд 2.3 % байгаа нь бусад орнуудаас бага байна.) энэ хандлага илүү ажиглагдаж байна. Эдгээр улсуудын гол экспортын зах зээл болсон Европын холбооны эдийн засгийн удаашралт, энэ бус нутгийн томоохон улс болох Польшийн эдийн засаг дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр сүл хэвээр байгаа зэрэг нөлөөлжээ.

Зүүн-Өмнөд Европын улсуудын хувьд Балканы хойгийн үндэстэн хоорондын мөргөлдөөн намжсан, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн нь нааштай үр нөлөөг үзүүлж байна. 1999 оноос өмнөх онуудад бодит ДНБ-ий өсөлт хасах үзүүлэлттэй байсан бол сүүлийн 3 жил 3.6-4.5%-д хүрчээ.

Зүүн-Өмнөд Европын улсуудын хувьд Тогтворталтын баримт (Stability Fact)-д оролцсоноор шинээр бий болсон улс төрийн тогтворталтыг ашиглах, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг татахад энэ бус нутаг найдвартай гэж итгүүлэх шаардлагатай байна. Энэ бус нутгийн зарим улсуудад тусламж, гадаадад ажиллагчдын хувийн гүйвуулга /сүүлийн жилүүдэд буурч байгаа/ нэлээд чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Үүгээрээ манай улстай зарим талаараа ижил төстэй. Тусгаар тогтоносон хамтын нөхөрлөл (TTXH)-ийн орнуудын эдийн засаг хөгжлийн хамгийн бага түвшнээс эхлэн (бодит ДНБ-ий өсөлт 1995 өмнөх онуудад бүх орны хувьд сөрөг байснаа 2000 оноос ээрэг болов.) хурдацтайгаар өсч байна. Тус бус нутгийн эдийн засгийн өсөлт хамгийн том эдийн засагтай Оросын дотоод эрэлт өндөр байгаагаас тогтвортой байна. Нефть болон хийн бүтээгдэхүүний үнийн огцом бууралт гол экспортлогч болох Орос болон Каспийн орнуудад нөлөөлсөн хэвээр байна. Цаашид үнэ өсөх хандлага хэвээр байх төлөвтэй байна. Армени, Гурж, Киргиз, Молдав, Тажикистан зэрэг улсуудын нэг хүнд ноогох орлого бага, гадаад өрийн сүлжээ сүүлийн жилүүдэд огцом өсч байна. Макро эдийн засгийн бусад гол үзүүлэлтийн харьцуулалтаар ерөнхий ШЭЗ-н орнуудтай ижил түвшинд байгаа Монгол улсын хувьд бодит өсөлтөөр сүл барих хандлага байна. Монголд тулгарч байгаа цаг уурын тааламжгүй байдлаас Монголын эдийн засгийн өсөлт сүл байна. 2002 онд аж үйлдвэрийн салбарын сэргэлтээс хамаарч бодит ДНБ-ий өсөлт 3.9 хувьд хүрч, 2001 оныхос 2.9 нэгжээр нэмэгджээ. Иймд байгаль цаг агаараас аль болох бага шалтгаалах хөдөлмөр эрхлэлтийг түлхүү дэмжих, цөөн тооны экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, хэмжээг ихэсгэх зорилгоор аялал жуулчлал, мэдээллийн технологи, уул уурхайн олборлолтын чиглэлээр ажиллах шаардлагатай юм.

### *Азийн хөгжлийн буй орнууд*

Ази дахь хөгжиж буй орнуудын үйлдвэрлэл, экспорт оны эхнээс өссөн нь эдийн засагт зэрэгээр нөлөөлөв. Тайлант оны 2 дугаар улирлын үзүүлэлтүүд хүлээгдэж байснаас өндөр гарснаар дотоод эрэлт өсч, ДНБ-ий өсөлт 2002 онд 6 хувьд хүрч, 2003 онд тэр түвшинд байх тооцоо гарч байна. Гэвч эдийн засгийн өсөлт гадаад орчноос шууд хамааралтай хэвээр байгаа бөгөөд Ойрхи Дорнодын байдлаас шалтгаалж нефтийн үнэ өсвөл эдийн засгийн өсөлтөнд сөрөг нөлөө үзүүлж болох юм. Дэлхийн санхүүгийн зах зээл дэх хямрал нь Азийн орнуудад харьцангуй багаар нөлөөлжээ. Гонконг, Хятад, Малайзаас бусад орны доллартай харьцах валютын ханш 3 дугаар сарын сүүлээс чангачээ. Шинээр аж үйлдвэржсэн орнуудаас Өмнөд Солонгосын эдийн засаг дотоод эрэлт, экспортын өсөлт дээр тулгуурлан сэргэлтэд ороод байна.


### *Латин Америк*

Дэлхийн бусад орнуудад гарсан нааштай өөрчлөлтүүдтэй харьцуулбал Латин Америкийн орнуудын эдийн засаг, санхүүгийн байдал 2002 оны эхний хагаст дордсон байна. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн эхний улиралд 2.5 хувиар буурч цаашид ч өсөх хандлагагүй байна. Тус бүс нутгийн эдийн засгийн уналтын гол шалтгаан нь Аргентинд болсон хямрал, түүний үр дагаврын нөлөө юм. Аргентин улсын эдийн засаг сүүлийн 4 жилд 20 гаруй хувиар буурсан бөгөөд 2002 оны эхний улиралд хэрэглээ, хөрөнгө оруулалтын хэмжээ огцом багасч, ДНБ 6 хувиар буурч, ажилгүйдэл 25 хувьд хүрсэн байна. Аргентин улстай хөрш зэргэлдээ орших Уругвай, Парагвай, Болив зэрэг орнуудын эдийн засаг худалдаа, аялал жуулчлал, санхүүгийн сувгуудаар хямралын нөлөөнд автжээ. Дурьдсан хямралын шууд нөлөөнөөс Бразил улс амжилттай гарч чадсан хэдий ч 2002 оны 2 дугаар улиралд бий болсон мөнгөний ханшийн уналт, бондын хүүний өсөлт, зах зээлийн уур амьсгалын эрс доройтол нь 2001 оны 10 дугаар сард болж өнгөрсөн өрөнхийлөгчийн сонгуулиас үүдэн эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдал үүссэнээр тайлбарлагдаж байна. Эквадор, Перу, Венесуэл болон бусад орнуудад бүс нутгийн тогтвортгүй байдал, дотоодын улс төрийн мөргөлдөөн, их хэмжээний гадаад өрийн улмаас эдийн засгийн аюулгүй байдал алдагдсан зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалтын эрсдэл өссөн байна. Төсвийн орлогыг өсгөх, зардлыг багасгах улмаар өрөө барагдуулах нь тус улсуудын эдийн засгийн бие даасан байдлаа хангах хамгийн чухал бодлого болж байна. 2003 онд дэлхийн хэмжээнд болж буй сэргэлт тус бүс нутгийн эдийн засгийн үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах болно.


### *Европын Холбоонд нэр дэвшисэн улсууд*

Дэлхийн хэмжээнд эдийн засгийн өсөлт саарч байхад Европын холбоонд нэгдэхээр төлөвлөж буй Төв болон Зүүн Европ, Балтийн улсуудын хувьд эдийн засгийн өсөлт тогтвортой явагдаж байна. Эдгээр улсуудын өсөлт 2002 онд 2.5-4.5 хувиар хэмжигдэх бөгөөд цаашид түргэсэх хандлагатай байна. Гадаадын


Зураг 4. Шилжилтийн эдийн засагтай орнуудын инфляци



Зураг 5. Шилжилтийн эдийн засагтай орнуудын ДНБ-ий өсөлт



Зураг 6. Дэлхийн гол түүхий эдийн үнийн индекс (1995=100)



шууд хөрөнгө оруулалт ихээр орж ирж байгаа нь санхүүжилтийн нэг үндэс болж, дотоод эрэлтийг буурахаас сэргийлэн бус нутгийн эдийн засгийн үйл ажиллагаанд их хувь нэмэр оруулж байна. Энэ нь тогтвортой, үр дүнтэй макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлсэн болон бизнесийн таатай орчин бүрдүүлсний үр нөлөө юм. Үүнээс гадна дотоод эрэлт нэмэгдсэн нь цалингийн өсөлт, инфляцийн бууралт, мөн зарим улсуудын хувьд татварын ачааллыг багасгасан зэргээс шалтгаалжээ. Эдийн засгийн өсөлтийг үргэлжлүүлэх, эрчимжүүлэх бодлого улсын хувьд өөр өөр боловч өнөөгийн ерөнхий чиг хандлагаас шалтгаалан ихэнх улсуудын хувьд төсвийн тэнцлийг тогтвorumжулах нь хамгийн чухал болоод байна. Ингэснээр макро эдийн засгийн бодлогыг богино хугацаанд хэрэгжүүлэх тогтвортой нөхцөл бүрдэх бөгөөд цаашид Европын холбоо, НАТО-д элсэхтэй холбоотой зардлыг гаргахад арай хялбар болох юм.

### *OХУ*

Тус улсын ДНБ 2002 онд 4 хувиар өсөх төлөвтэй байна. Эдийн засгийн идэвх 4 дүгээр улиралд нэмэгдсээр байх тохиолдолд ДНБ-ий өсөлт 4 хувиас ч өндөр байх төлөвтэй юм. Эдийн засгийн өсөлт голчлон хувийн хэрэглээний өсөлтөөс шалтгаалсан байна. Харин гадаад тэнцэл сөрөг гарч, хөрөнгө оруулалтын хэмжээ буурчээ. Гадаад тэнцэл сөрөг гарсан нь рублийн бодит ханш чангартсан, гол худалдааны түнш орнуудын орлогын өсөлт удааширсантай холбоотой юм. Хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь аж ахуйн нэгжүүдийн ашиг буурснаас шалтгаалсан байна. Инфляцийн түвшин буурч байгаа боловч их удаан байна. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляци оны эцэст 14 хувь байхаар төлөвлөсөн нь бага зэргийн зөрүүтэй биелэхээр байна. Инфляцийн түвшин ТТУХН-ийн орнуудтай харьцуулахад өндөр хэвээр байна.

### *Тусгаар Тогтносон Улсуудын Хамтын Нөхөрлөл (ТТУХН)*

Дэлхийн хэмжээнд болж буй эдийн засгийн удаашралт тус улсуудад харьцангуй багаар нөлөөлсөн юм. ТТУХН-ийн тогтвортой өсөлт тус бусийн хамгийн том эдийн засаг болох Оросын дотоод эрэлт сайн байснаас шалтгаалжээ. Харин 2002 онд дор дурьдсан 2 шалтгааны улмаас гадаад эрэлт сайжирснаас үл хамааран эдийн засгийн өсөлт удаашрах төлөвтэй байна. Нэгдүгээрт, нефтийн орлого буурснаар ОХУ, Казахстаны өсөлт буурсан; хоёрдугаарт, 2001 онд маш эрчимтэй сэргэж ирсэн хөдөө аж ахуйн салбарын өсөлт буцаад хэвийн түвшиндээ орно. Ерөнхийд нь авч үзвэл, шинэчлэлийг арай доогуур түвшинд хийж буй зарим орныг эс тооцвол, дэлхийн эдийн засаг сэргэх, мөн нефтийн үнэ өсөхтэй зэрэгцэн ДНБ-ий өсөлт ТТУХН-ийн орнуудад тогтвортой байх төлөвтэй байна. ОХУ болон өөр бусад харьцангуй хөгжилтэй орнуудад өмнө нь амжилттай хийгдсэн өөрчлөлт шинэчлэлтийн үр дүнд, мөн хувийн хэрэглээ өндөр байгаагийн улмаас дотоод эрэлт эдийн засгийн үйл ажиллагааг хурдасгана. Харин хөгжлөөр арай сул орнуудын хувьд макро эдийн засгийн тогтвортгүй байдал, үйлдвэрлэлийн салбарт бүтцийн шинэчлэлт дутагдаж

## Шигтгээ 2. Шилжилтийн эдийн засагтай орнуудын инфляци

Хуучин социалист системтэй орнуудын хувьд 1990-ээд он нь зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж эхэлсэн онцлог үе байлаа. Социалист систем бүхэлдээ задарснаар мөрдөгдөх ирсэн эдийн засгийн харилцаа үйлчлэх чадваргүй болж шинэ тогтолцоонд тохирох эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлийг хийх хэрэгтэй болов. Шилжилтийн эхний үед эдгээр улсууд гипер инфляцийн түвшинтэй байсан хэдий ч

ОУ-ын байгууллагуудын тусламжтайгаар өөрийн оронд тохирох эдийн засгийн бодлогыг амжилттай авч хэрэгжүүлсний үр дүнд инфляцийн түвшин буурч эдийн засаг хөгжих нөхцөл бүрдсэн юм.

ТЗЕБУ-удын эдийн засаг харьцангуй хурдацтай хөгжиж, инфляцийн түвшин огцом буурсан нь гол экспортын зах зээл болох Европын холбооны улсуудаас шууд хамааралтай юм. Хэдийгээр сүүлийн хоёр жилд дэлхийн эдийн засгийн хөгжил саарсан, Европын дийлэнх хэсэг үерт нэрвэгдсэн ч тус бус нутгийн эдийн засгийн байдал харьцангуй

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002*
<b>Зүүн-Өмнөд Европын улсууд</b>												
Албани	35.5	226.0	85.0	22.6	7.8	12.7	33.2	20.6	0.4	0.1	3.1	5.3
Болгар	333.5	82.0	3.0	96.3	62.0	123.0	1082.0	22.2	0.7	9.9	7.4	6.1
Югослав	121.0	9237.0		3.3	78.6	94.3	21.3	29.5	37.1	60.4	91.3	21.5
Македон	114.9	1664.4	338.4	126.5	16.4	2.5	0.8	2.3	-1.3	6.5	5.3	3.6
Румын	170.2	210.4	256.1	136.7	32.3	38.8	154.8	59.1	45.8	45.7	34.5	22.7
Дундаж (ЗӨЕҮ)	155.0	2284.0	188.1	77.1	39.4	54.3	258.4	26.8	16.5	24.5	28.3	11.8
<b>Төв болон зүүн Европ, Балтын улсууд</b>												
Хорват	123.0	665.5	1517.5	97.6	2.0	3.5	3.6	5.7	4.2	6.2	4.9	2.3
Чех	52.0	11.1	20.8	9.9	9.1	8.8	8.5	10.7	2.1	3.9	4.7	2.3
Эстон	210.5	1076.0	89.8	47.7	29.0	23.1	11.2	8.1	3.3	4.0	5.8	3.8
Унгар	35.0	23.0	22.5	18.8	28.2	23.6	18.3	14.3	10.0	9.8	9.2	4.9
Латви	172.2	951.2	109.2	35.9	25.0	17.6	8.4	4.7	2.4	2.6	2.5	2.3
Литва	224.7	1020.5	410.4	72.1	39.6	24.6	8.9	5.1	0.8	1.0	1.3	0.9
Польш	70.3	43.0	35.3	32.2	27.8	19.9	14.9	11.8	7.3	10.1	5.5	2.1
Словак	61.2	10.0	23.2	13.4	9.9	5.8	6.1	6.7	10.6	12.0	7.3	3.1
Словени	117.7	207.3	32.9	21.0	13.5	9.9	8.4	7.9	6.1	8.9	8.4	7.4
Дундаж (ТЗЕБУ)	118.5	445.3	251.3	38.7	20.5	15.2	9.8	8.3	5.2	6.5	5.5	3.2
<b>Тусгаар Тогтоносон Улсуудын Хамтын Нэхэрлэл</b>												
Армени	274.0	1346.0	1822.0	4962.0	175.8	18.7	14.0	8.7	0.7	-0.8	3.2	1.4
Азербайжан	107.0	912.0	1129.0	1664.0	412.0	19.7	3.5	-0.8	-8.5	1.8	1.5	2.8
Беларусь	94.1	970.8	1190.2	2221.0	709.3	52.7	63.8	73.2	293.8	168.9	61.4	41.4
Гүрж	79.0	887.4	3125.4	15606.5	162.7	39.4	7.1	3.6	19.2	4.1	4.7	0.1
Казакстан	78.8	1381.0	1662.3	1892.0	176.3	39.1	17.4	7.3	8.3	13.2	8.4	6.0
Киргиз	85.0	855.0	772.4	228.7	40.7	31.3	25.5	12.0	35.8	18.7	7.0	2.5
Молдав	98.0	1276.4	788.5	329.7	30.2	23.5	11.8	7.7	39.0	31.3	9.8	9.0
Орос	92.7	1526.0	875.0	311.4	197.7	47.8	14.7	27.6	86.1	20.8	21.6	16.3
Тажикстан	112.0	1157.0	2195.0	350.0	609.0	418.0	88.0	43.2	27.6	32.9	38.6	12.8
Туркменистан	103.0	493.0	3102.0	1748.0	1005.3	992.4	83.7	16.8	24.2	8.3	11.6	9.6
Украин	91.0	1210.0	4734.0	891.0	377.0	80.0	15.9	10.5	22.7	28.2	12.0	1.6
Узбекистан	82.2	645.0	534.0	1568.0	304.6	54.0	58.9	17.8	29.1	24.2	26.2	22.8
Дундаж (ТТУХН)	108.1	1055.0	1827.5	2647.7	350.1	151.4	33.7	19.0	48.2	29.3	17.2	10.5
Монгол	52.7	325.5	183.0	66.3	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	1.6

\* урьдчилсан байдлаар (эх сурвалж: Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк)

тогтвортой байж инфляцийн түвшин доогуур хэвээр байна. 2002 оны эцсийн байдлаар Словени (7.4%), Унгар (4.9%) улсуудын инфляцийн түвшин өндөр байхад Чех (2.3%), Польш (2.1%), Балтын улсуудын (0.9-2.3%) инфляцийн түвшин бага байна.

ЗӨЕҮ-ын инфляцийн түвшин нь Югослав, Румын улсуудаас хамааран ТТУХН-ийн улсуудтай ойролцоо өндөр байна. ЗӨЕҮ-удын хувьд инфляцийн түвшин багатай (5.3%) Албани улс сүүлийн 5 жилийн турш эдийн засгийн тогтвортой хөгжлийг хадгалж байгаа хэдий ч энэ нь гол төлөв гадаадын тусламжаас үүдэлтэй юм. Югослав, Румын улсуудын макро эдийн засгийн үзүүлэлт харьцангуй сайжирч байгаа боловч Югослав улсын инфляци 21.5 хувь, харин Румын улсын хувьд 22.7 хувьтай байна.

ТТУХН-ийн орнуудын эдийн засгийн байдал цаашид сайжрах хандлагатай ч тухайн улсуудын байгалийн баялаг болон бусад онцлогоос шалтгаалан харилцан адилгүй хурдтай хөгжиж байна. Тухайлбал, эдийн засгийн шинэчлэл харьцангуй удаан хийгдэж байгаа Беларусь (41.4%), Узбекистан (22.8%) улсуудад инфляцийн түвшин хамгийн өндөр байна. Орос улсын хувьд сүүлийн дөрвөн жилийн турш тогтвортой эдийн засгийн бодлого баримталсан хэдий ч инфляцийн түвшин харьцангуй өндөр хэвээр байна.

Сүүлийн жилүүдэд Монгол улсын хувьд эдийн засгийн байдал тогтвожин мөнгө санхүүгийн бодлогыг амжилттай хэрэгжүүлсэнд үр дүнд инфляцийн түвшин (1.6 %) буурч нэг оронтой тоогоор илэрхийлэгдэх болсон байна. Инфляцийн түвшин ийнхүү буурч, тогтвожиж байгаа нь ТЗЕБУ-ын түвшинтэй ойролцоо байна.

байгаа, мөн хөрөнгө оруулах таатай нөхцөл бүрдээгүй зэргээс хамаарч өсөлт харьцангуй удаан байх болно. Гадаад худалдааг авч үзвэл, тус бус нутгийн урсгал тэнцлийн илүүдэл 2002, 2003 онуудад буурах төлөвтэй байна. Энэ нь Оросын дотоод эрэлт сайн байгаатай, мөн рублийн бодит ханш чангартай холбоотой юм. Бусад олон орны, тухайлбал гадаад өрийн хэмжээ нь төсвийн болоод худалдааны үйл ажиллагаанд бэрхшээл учруулж буй Киргиз, Молдав, Тажикстан, Гүрж зэрэг орнуудын хувьд гадаад худалдаа их хэмжээний алдагдалтай хэвээр байх шинжтэй байна. Инфляцийн түвшин бус нутгийн хэмжээнд багассаар байгаа боловч Орос болон зарим хөгжлөөр сүл орнуудын хувьд энэ нь бэрхшээлтэй асуудал хэвээр байна.


## БНХАУ

Хятад улсын эдийн засаг ойрын жилүүдэд өндөр өсөлттэй байх төлөвтэй байна. Дотоод хэрэглээ болон хөрөнгө оруулалтын эрчимтэй өсөлтийн дунд 2002 онд Хятад улсын ДНБ 7.4 хувь, үүнээс аж үйлдвэр болон үйлчилгээний салбар 7-9 хувь, хөдөө аж ахуйн салбар 2 хувиар тус тус өсөх хандлагатай байна. Дотоод хэрэглээ, эдийн засаг үргэлжлэн өсч байгаа нь үнэ өсөх дарамт учруулж байгаа ч инфляцийн түвшин бага байх төлөв ажиглагдаж байна. Төсвийн алдагдал 2002 онд ойролцоогоор ДНБ-ий 2 хувьд хүрэх бөгөөд улсын мэдлийн арилжааны банкуудын чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, нийгмийн хамгааллын салбарын шинэчлэлийг хийхэд их хэмжээний төсвийн хөрөнгө шаардагдах болж байна. Мөнгөний нийлүүлэлт тайлант онд 13 хувиар өснө гэсэн хүлээлттэй байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжих үүднээс Хятадын Ардын банк (Төв банк) 2002 оны эхээр хадгаламжийн хүүг 0.25 хувиар, зээлийн хүүг 0.5 хувиар бууруулжээ. Их хэмжээгээр орж буй гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунд төлбөрийн тэнцэл мэдэгдэхүйц сайжирч, жилийн эхний хагаст тус улсын гадаад валютын нөөц 31 тэрбум ам. доллараар нэмэгджээ. Экспорт 2002 онд 6 хувиар өсөх бололцоо байгаа бөгөөд ДХБ-д элссэнээр импортын өсөлт экспортын өсөлтийг давах учраас худалдааны болон урсгал дансны илүүдлийн хэмжээ буурах төлөвтэй байна. ДХБ-ын шаардлагын дагуу тус улсын Засгийн газар цаашид эдийн засгаа улам нээлттэй болгох учраас дээрх урсгал дансны илүүдлийн бууралтын зарим хэсэг нь гадаадын шууд хөрөнгө оруулалтаар нөхөгдөх боломжтой юм. Цаашид эдийн засгийн өсөлт, төсвийн тогтвортой байдал зэрэг нь эдийн засгийн бүтцийн шинэчлэлтийг хэр сайн хийхээс, тэр тусмаа зах зээлд чиглэгдсэн эрүүл саруул банкны тогтолцоог хэр амжилттай хөгжүүлэхээс болон улсын үйлдвэрүүдийг шинэчлэх, хувьчлах үйл ажиллагаанаас хамаарна.


### 1.2. Дэлхийн зах зээлийн ханш, хүү

Дэлхийн эдийн засагт 2002 онд гарсан голлох үйл явдлууд зах зээл дээрх хүүний түвшин болон бараа бүтээгдэхүүний үнэд хүчтэй нөлөө үзүүлж байлаа. Тухайлбал, 2001 оны эцсээр АНУ-д том корпорациудын дампуурал (Enron, World Com, Artur Anderson) нь тус улсын биржүүдийн гол Насдак (Nasdaq),

Зураг 7. Алтны дэлхийн зах зээлийн үнэ



Зураг 8. Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ



Зураг 9. Түүхий нефтийн дэлхийн зах зээлийн үнэ



Доу Жоунс (Dow Jones) индексийг удаан хугацаанд доошлох байдалд хүргэсэн байна. Үүнээс хамааран дэлхийн хөрөнгийн захын арилжааны түвшин 2000 онтой харьцуулахад 40 хувь доогуур хэмжээнд байлаа.

Дэлхийн хамгийн том эдийн засагтай АНУ эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшнээсээ хамааран Төв банкны хүүгээ 2001 онд нийт 11 удаа бууруулсны дараа 2002 оны эхнээс тогтмол нэг түвшинд хүргэж, оны сүүлийн хагаст дахин 1.75 хувь дээр тогтоосон байна. Энэ нь сүүлийн 40 жилд байгаагүй бага түвшин бөгөөд үүнийг инфляцийн түвшин нэмэгдэх шинжтэй байсан, эдийн засгийн өсөлт хангалттай хэмжээнд очихгүй байсан зэргээс Холбооны нөөцийн банкны хэрэгжүүлсэн хүүний бодлогоор тайлбарлажээ.

2002 онд Европын холбооны Төв банкнаас хүүг тогтмол хэмжээнд барьж байсан бөгөөд 4 удаа хуралдаж хүүний түвшинг тухай бүрт нь зохицуулж иржээ. Европын Төв Банкны хүү нь овернайт зээлийн, овернайт хадгаламжийн, дахин санхүүжилтийн зээлийн гэсэн 3 төрлийн хүүний ангилалтай байдаг.

### 1.3. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ

Дэлхийн эдийн засаг гол гол түүхий эдийн үнээс хамааран хэлбэлзэх хандлагатай байдаг. 2001 онд дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ харьцангуй доогуур түвшинд байсан хэдий ч 2002 оны эхний улиралд эдийн засгийн байдал сайжирсны үр дүнд үүний түвшин өссөн байна. Тайлант оны 2 дугаар улиралд түүхий эдийн үнэ тогтворжиж эхэлжээ.

2002 онд нефтийн үнийн хэлбэлзэлд дэлхийн эрэлтийн хэтийн төлөв болон Ойрхи Дорнодын орнууд, Венесуэль дэх улс төрийн үйл явдлууд нөлөөлжээ. Тайлант оны эхэн үе дэх дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв байдал, ялангуяа Ойрхи Дорнодын улс төрийн тодорхой бус байдал нь ОПЕК-ийн зүгээс нефтийн үнийг эргээд 22-28 ам. долларын түвшинд өсгөхөд хүргэсэн хэдий ч энэ нь 2000 оны үнийн өсөлтийн дээд хэмжээнээс доогуур түвшинд байсан байна. Тухайлбал, 1 баррель нефтийн жилийн дундаж үнэ 1999 онд 17.3 ам. доллар, 2000 онд 26.1 ам. доллар, 2001 онд 18.2 ам. доллар байсан бол 2002 оны байдлаар 26.2 ам. долларт хүрчээ. Мөн Ойрхи Дорнодын орнуудын үнэт цаасны зах зээлийн доройтлоос шалтгаалан нефтийн үнэ огцом өсөх магадлал нь дэлхийн эдийн засагт тодорхой эрсдэл учруулсан хэвээр байлаа. Иракийн нефтийн нийлүүлэлт түр зуур зогсоноос шалтгаалж нефть болон нефтийн бүтээгдэхүүний үнэ 2002 онд ижил түвшинд унасан байна. Харин ОПЕК-ийн гишүүн бус нефть нийлүүлэгч хамгийн том хоёр улс болох ОХУ, Норвеги улс 2002 оны 3 дугаар улиралд нефть олборлолтын хэмжээгээ өсгөхөөр зарласан бөгөөд тухайн оны 6 дугаар сард ОХУ анх удаа АНУ-д нефть экспортолжээ.

Сул эрэлт, илүүдэл нийлүүлэлт нь түүхий эдийн үнийг хэлбэлзүүлсэн хэдий ч металл түүхий эдийн үнэ харьцангуй тогтвортой байсан байна. Тайлант оны эхний хагаст гоёл чимэглэлийн зах зээл дээрх алтны хэрэглээ өмнөх жилийнхээс

17 хувиар буурч 1301 тоннд хүрчээ. Үүнд, Энэтхэгийн зах зээл дээрх алтны үнэ өссөн болон аж үйлдвэржсэн орнууд дахь өдийн засгийн тааламжтай бус нөхцөлөөс шалтгаалсан эрэлтийн бууралт зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. Алт олборлогчид борлуулалтын хэмжээгээ багасгасан болон терроризмын аюул хөрөнгө оруулагчдад алт худалдаж авах сонирхлыг нэмэгдүүлсэн зэрэг нь алтны үнийг 2002 оны 2 дугаар хагаст өсгөхөд хүргэсэн байна.

Харин зэсийн дэлхийн зах зээлийн үнэ эрэлтээр тодорхойлогдож байгаа бөгөөд 2002 оны байдлаар цэвэршүүлсэн зэсийн хэмжээ хэрэгцээтэй хэмжээнээс даруй 105.0 мянган тонноор илүү байсныг Олон улсын зэсийн судалгааны төвөөс тогтоожээ. Энэхүү зэсийн илүүдэл нийлүүлэлтийг 2001 онтой (536.0 мянган тонн) харьцуулахад буурсан байгаа хэдий ч дэлхийн тэргүүлэх 9 олборлогч дараагийн жилүүдэд олборлолтын хэмжээгээ 740.0 мянган тонноор бууруулахаа албан ёсоор мэдэгдсэн байна.



## **2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ**

<b>2.1.</b>	<b>Ерөнхий тойм</b>	<b>24</b>
<b>2.2.</b>	<b>Засгийн газрын санхүү</b>	<b>34</b>
<b>2.3.</b>	<b>Төлбөрийн тэнцэл</b>	<b>39</b>
<b>2.4.</b>	<b>Үнэ, цалин, хөлс</b>	<b>47</b>
<b>2.5.</b>	<b>Ажиллах хүчний зах зээл</b>	<b>48</b>

## 2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

### 2.1. Ерөнхий тойм

Тайлант онд Монгол улсын Засгийн газар макро эдийн засгийн тогтвортжуултыг бататгах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, банк санхүүгийн салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх замаар тус салбарын сэргэлтийг гүнзгийрүүлэх, төсвийн байгууллагын бүтцийн өөрчлөлтийг эхлүүлэх, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, өмч хувьчлалыг эрчимжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллав.

Засгийн газраас 2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгон зарлаж, жилийн ажлын хүрээнд хөрөнгө оруулалтын эдийн засаг, эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажилласны үр дүнд 2002 онд 77.8 сая ам. долларын шууд хөрөнгө оруулалт хийгдэв. Банк санхүүгийн салбарт 40 гаруй сая ам. долларын хөрөнгийн урсгал оржээ.

"Хөрөнгө оруулалтыг дэмжих жил"-ийн хүрээнд Монгол улсад хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг Монгол улсын Засгийн газар, Дэлхийн банктай хамтран 2002 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. 1997 онд уул уурхай, газрын тос, байгалийн хийн салбарт, 1998 онд хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулж байсан бол энэ удаа өргөн хүрээнд уул уурхай, хөдөө аж ахуйн боловсруулах салбар, аялал жуулчлал, мэдээлэл холбооны технологи, дэд бүтэц гэсэн Монгол улсын эдийн засгийн чадавхийг тодорхойлдог үндсэн таван салбарт хөрөнгө оруулагчдыг татах зорилготой явагдлаа.

Монгол улсын банкны салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийгдсэн нь арилжааны хамгийн том банк болох Худалдаа хөгжлийн банкны төрийн өмчийн 76 хувийг 2002 оны 5 дугаар сард Швейцарийн "Банка Коммерсиалл Лугано" болон АНУ-ын "Жералд Металс" компанийн хамтарсан консерциумд 12.23 сая ам. доллараар хувьчилсан явдал юм. Швейцарь, Америкийн хамтарсан тус консорциум нь Худалдаа хөгжлийн банкны үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэх зорилгоор 2 жилийн хугацаанд 28.0 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. Активын хэмжээгээр дэлхийд эхний 25-д багтдаг Нидерландын "Ай Эн Жи" (ING) банктай менежментийн тал дээр хамтран ажиллахаар тохиролцсон байна.

2002 онд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо Монголд хандивлагчдын чуулга уулзалт болж, нийт 333.0 сая ам. долларын зээл, тусламж өгөхөөр тохирсны 184.0 сая ам. доллар нь хөнгөлттэй зээл, 140.0 сая ам. доллар нь буцалтгүй тусламж байв.

Манай орны байгаль цаг уурын тааламжгүй байдал, их хэмжээний зудын гамшиг болсны улмаас 2.9 сая том мал хорогдож, зуны саруудад хэт халуун байснаас хураасан ургацын хэмжээ багасч, хөдөө аж ахуйн салбарын

### Хүснэгт 2. Дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн өөрчлөлт (зэрэгцүүлсэн үнээр, %)

	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Дотоодын нийт бүтээгдэхүүн	2.4	4.0	3.5	3.2	1.1	1.0	3.9
Аж үйлдвэр	-3.6	-3.3	4.2	1.1	2.7	16.5	4.7
Хөдөө аж ахуй	4.4	4.3	6.4	4.2	-14.9	-18.5	-10.5
Барилга	2.6	-2.7	-1.1	1.6	-14.6	10.8	11.1
Тээвэр, холбоо	11.2	5.8	7.4	6.1	25.2	14.9	17.1
Худалдаа	0.3	17.1	-3.1	1.3	26.1	9.8	12.3
Үйлчилгээ	7.3	-0.6	1.7	5.4	2.7	-0.2	6.8

Үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөв. Харин аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл өмнөх оныхоос 4.7 хувиар өсчээ. Үүний дотроос боловсруулах салбарын үйлдвэрлэл 22.1, цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 4.0 хувиар нэмэгдсэн байна. ДНБ-ий цэвэр өсөлт урьдчилсан тооцогоор 3.9 хувь болов. Хэрвээ ган зуд, цаг уурын бэрхшээл, дэлхийн зах зээл дээр таагүй нөхцөл үүсээгүй бол манай эдийн засаг б хүртэл хувиар өсөхөөр байв. Цаашдаа эдийн засаг дахь байгаль цаг агаарын хамаарлыг багасгах үүдиэс эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх шаардлагатай байна.

Тайлант онд "Газрын тухай", "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай", "Үнэт цаасны зах зээлийн тухай", "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай", "Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай" зэрэг манай улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд эрх зүйн орчинг бэхжүүлэхэд чухал хувь нэмэр бүхий зарчмын шинж чанартай хуулиуд шинээр батлагдан гарлаа. Мөн төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд шилжсэн нь улсын нэгдсэн төсвийн болон Монгол улсын Засгийн газарт олгосон зээл, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэн, хяналт тавих, Засгийн газар болон бусад байгууллагуудын төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, бүх шатны төсөв захирагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, урт хугацаанд Засгийн газрын зээлийн зардлыг багасгах, төсвийн хөрөнгийн урсгал зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахад чиглэгджээ.

Бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал батлагдсанаар бүсийн төвүүдэд хот суурин газрын төвлөрөл бий болж үргүй зардлуудыг багасгах эдийн засгийн бодлогын эрх зүйн суурь тавигдлаа.

Эдийн засгийн макро орчин, бараа үйлчилгээний үнэ ханш тогтвортой байж, санхүү банкны салбарын зуучлал бүх чиглэлээр гүнзгийрч, банкуудаас олон шинэ санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлсэн нь эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөө үзүүллээ. Хэрэглээний барааны үнийн өсөлт (инфляцийн түвшин) жилийн 1.6 хувь болсон (1991 оноос хойшхи инфляцийн хамгийн бага түвшин), төгрөгийн гадаад валюттай харьцах ханш оны туршид харьцангуй тогтвортой байсан, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл өмнөх оныхоос 4.7 хувиар өссөн зэрэг нь 2002 онд эдийн засаг тогтворжин, өсөх хандлага бодитой болж байгааг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд банкуудын төлбөрийн чадвар сайжран, харилцагчдад хандсан олон шинэ санхүүгийн бүтээгдэхүүнийг нэвтрүүлж, зээл болон хадгаламжийн хүүгээр банкууд өөр хоорондоо өрсөлдөн, үүний үр дүнд нийт банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө эрс нэмэгдэж банкны систем тогтворжиж байна. Тайлант онд зарим банкууд интернет банк, телефон банк зэрэг санхүүгийн шинэ үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн ба 2001 онд анх нэвтэрсэн бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэр болох Мастер (MASTER) болон Виза (VISA) карт, үүнийг дагалдсан үйлчилгээ тогтмолжиж, хамрах хүрээ, хэрэглэгчийн тоо эрс нэмэгдсэн байна. Хөдөөгийн болон орлого багатай зээлдэгчдэд зориулсан зээлийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг манай хэд хэдэн банк 2002 онд нэвтрүүлжээ.


Эдийн засаг дахь санхүүгийн зуучлалын цар хүрээг өргөжүүлэх, жижиг дунд үйлдвэрийг санхүүгийн эх үүсвэрээр хангахад банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ууд ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ зээлийн хүүг бууруулахад тэдгээр нь тодорхой нөлөөг үзүүлж байна. 1999 онд анхны ББСБ байгуулагдаж байсан бол 2002 оны эцэст 66 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 42.0 хувиар өссөн хэдий ч түүний өсөлтийн нөлөө инфляцид бага байж хэрэглээний барааны үнийн өсөлт (инфляцийн түвшин) жилийн 1.6 хувь болсон байна. Санхүүгийн зуучлалын хэмжээ, цар хүрээг илтгэх гол үзүүлэлт болох нийт мөнгө (M2) ба ДНБ-ий харьцаа 2000 онд 25.4 хувь, 2001 онд 27.3 хувь байснаа 2002 онд 38.2 хувь хүрчээ.

Банкны зээл олголтын чанар сайжирснаас үүдэн иргэд болон аж ахуйн нэгжүүдийн банкинд итгэх итгэл дээшилж, 2002 оны эцэст хадгаламж, зээлийн хэмжээ сүүлийн 12 жилийн туршид хамгийн өндөр түвшинд хүрлээ. Хадгаламжийн нийт үлдэгдлийн 52.1 хувь нь төгрөгийн хадгаламж байгаа нь төгрөгийн нэр хүнд иргэд, бизнес эрхлэгчдийн дунд дээшилж байгаагийн илрэл юм. Тайлант оны эцсийн байдлаар нийт хадгаламж ДНБ-ий 22.9 хувь, зээл 18.8 хувийг тус тус эзэлж байна. 1996-1999 онуудад болсон банкны хямралаас сургамж авсан банкуудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд 1999 оны сүүлийн хагасаас тогтворжиж, 2002 оны эцсийн байдлаар банкуудын чанаргүй зээлийн хэмжээ 16.6 тэрбум төгрөг байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувтай тэнцэж, энэ нь 2001 оныхоос 0.8 нэгжээр, 2000 оныхоос 16.7 нэгжээр тус тус буурчээ.

Урсгал дансны алдагдал өнгөрсөн онтой харьцуулахад бараг 2 дахин нэмэгдэж, ДНБ-ий 12.1 хувьтай тэнцүү байгаа нь анхаарал татах макро эдийн засгийн үзүүлэлт болж байна. Урсгал дансны алдагдлыг өнгөрсөн онуутдтай адил шууд хөрөнгө оруулалт, дунд ба урт хугацааны зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хэвээр байна. Тайлант оны эцэст улсын гадаад валютын цэвэр нөөц 225.9 сая ам. долларт хүрсэн нь 15.6 долоо хоногийн импортын хэрэгцээг хангахаар байна.


Зураг 10. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт



Зураг 11. Инфляци



Зураг 12. ДНБ-ний өсөлт (салбаруудаар)



Монгол улсын төсөвт 2002 онд 466.5 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, 536.5 тэрбум төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн нь өнгөрсөн оныхтой харьцуулахад орлого 42.0 тэрбум төгрөгөөр, зарлага санхүүжилт 66.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дэвшигүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Боломжит хөдөлмөр"-ийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулж 2002 онд батлуулав. Хөтөлбөрийг 2002-2010 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд хөдөлмөрийг дээдлэх, бодлогын уялдаа нийгмийн зөвшил, оролцоо зэрэг таван зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлэх юм. 2002 онд төрийн 125.8 мянган албан хаагчийн цалинг 20-22 хувь, тэтгэвэр тэтгэмжийг 20 хувь, хүүхэд асарсны тэтгэврийг 15 хувиар тус тус нэмэгдүүлэв. Төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлж байгаатай холбогдуулан ажилтан, ажиллагсдын цалинг ажилласан жилээр биш ажлын үр дүнгээс хамааран олгохоор тогтоожээ.

Дэлхийн банкны Ерөнхийлөгч Жеймс Д.Волфенсон 2002 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Монгол улсад айлчиллаа. Ноён Волфенсоны айчлалын зорилго нь дэлхийн нийтийн эдийн засгийн уналт болон жил дараалсан зуд тохиолдсон нөхцөлд Монгол орны өнөөгийн эдийн засгийн байдал, тулгарч буй асуудлын талаар санал солилцох явдал байв. Мөн хойд хөршийн Засгийн газрын тэргүүн 30 жилийн дараа буюу 2002 онд ОХУ-ын Засгийн газрын дарга М.Касьянов Монгол улсад албан ёсны айлчлал хийсэн нь улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаанд чухал алхам боллоо. Айлчлалын үеэр ОХУ-д сургах оюутны тоог нэмэгдүүлэх, ОХУ-ын пүүс компаниуд Монголд хөрөнгө оруулах тухай, хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн гэрээний хугацаа дуусч буйг шинэчлэх, Монголд байгаа ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн талаар урсгал ба их өр зэрэг хэд хэдэн чухал асуудлаар санал бодлоо солилцож гэрээ хэлэлцээр хийсэн байна.


### **Аж үйлдвэр**

Тайлант онд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 1995 оны зэрэгцүүлсэн үнээр 174.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оныхоос 7.8 тэрбум төгрөг буюу 4.7 хувиар өссөн нь боловсруулах аж үйлдвэрийн үйлдвэрлэл 22.1 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч, усан хангамжийн үйлдвэрлэл 4.0 хувиар тус тус өссөнтэй холбоотой юм. Харин уул уурхай, олборлох салбарын үйлдвэрлэл 6.8 хувиар буурчээ.


Боловсруулах аж үйлдвэрийн салбарт нэхмэл, хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт, нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх, төмрийн үйлдвэрлэл, төмөр эдлэл, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг үйлдвэрлэл, мебель тавилга үйлдвэрлэл нэмэгдсэн нь салбарын дүнгээр үйлдвэрлэл өсөхөд гол нөлөө үзүүлжээ.

Өнгөрсөн онтой харьцуулахад аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтад уул уурхай, олборлох салбарын эзлэх хувийн жин 1.3 нэгжээр, цахилгаан,


Зураг 13. Хэрэглээний барааны үнийн индекс



Зураг 14. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт (1995 оны үнээр)



Зураг 15. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний бүтэц



дулааны эрчим хүч, усан хангамжийн салбарынх 0.7 нэгжээр тус тус өсч, боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин 2.0 нэгжээр буурсан байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэрийн 179 бүтээгдэхүүнээс молибдений баяжмал, цахилгаан, дулааны эрчим хүч, цемент, шохой, металл бэлдэц, цувимал, алт мөнгөн эдлэл, ном, ээрсэн утас, эсгий, сүлжмэл эдлэл, самнасан ноолуур, гурил, сүү, сүүн бүтээгдэхүүн, өлөн гэдэс, хиамны зүйл, спирт, архи, амтат ус, ундаа, нэг удаагийн тариур зэрэг 91 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөв.

2002 онд тамхи, барилгын хөөсөнцөр хавтан, хөнгөн цагаан, талбайн өнгөт хавтан, явган хүний замын хавтан, бензин А-76, дизелийн түлш, мазут зэрэг бүтээгдэхүүнийг шинээр үйлдвэрлэж эхлэв.

Тайлант онд 2.5 тэрбум квт. цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 5.3 сая тонн нүүрс олборлож, 7.1 сая гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос цахилгаан эрчим хүчиний үйлдвэрлэлт 4.1 хувиар, нүүрс олборлолт 3.4 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт 7.1 хувиар тус тус нэмэгджээ.

2002 онд оны үнээр 677.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд борлуулсан байна.

Тайлант онд Өмнөговь аймгийн Оюутолгойн алт, зэсийн том ордын нөөцийг албан ёсоор зарлалаа.

### Хөдөө аж ахуй

Сүүлийн жилүүдэд тохиолдож буй байгаль цаг уурын тааламжгүй байдал, ган, зудын гамшиг 2002 онд давтагдсаны улмаас хураасан ургац өнгөрсөн оныхоос буурч, 2.9 сая том мал зүй бусаар хорогдсон байна.

Мал тооллогын урьдчилсан дүнгээр нийт 23.7 сая мал, үүний дотор 252.2 мянган тэмээ, 2.0 сая адuu, 2.1 сая үхэр, 10.5 сая хонь, 9.1 сая ямаа тоологдсон нь өмнөх оныхоос 2.4 сая толгойгоор буюу 9.2 хувиар буурсан байна. Малын тоо, толгойн бууралтыг төрлөөр нь авч үзвэл, тэмээ 11.6 хувь буюу 33.0 мянга, адuu 10.1 хувь буюу 221.5 мянга, үхэр 9.7 хувь буюу 200.1 мянга, хонь 11.7 хувь буюу 1400.7 мянга, ямаа 5.6 хувь буюу 535.4 мянган толгойгоор тус тус буурчээ.

2002 онд эх малын 67.9 хувь буюу 7.7 сая эх мал төллөж, 6.8 сая төл бойжуулсан дүнтэй байна. Өнгөрсөн оныхоос төллөлтийн хувь 2.2 нэгжээр буурснаас эм хонь, ингэ, ямааны төллөлтийн хувь 0.6-9.6 нэгжээр доогуур, гүү, үнээнийх 6.4-13.4 нэгжээр дээгүүр байна. Гарсан төлийн 87.8 хувь буюу 6.8 сая төл бойжиж байгаа нь өнгөрсөн оныхоос 562.1 мянгаар цөөн, харин төл бойжилтын хувь 8.6 нэгжээр илүү байна.

### Шигтгээ 3. Ноолуурын салбарын ашигт ажиллагаа

Малын гаралтай түүхий эдийн дотроос хамгийн үнэтэй нь ямааны ноолуур юм. Иймээс ямааны ноолуурыг үйлдвэрлэлийн аргаар иж бүрэн боловсруулж бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь эдийн засгийн хувьд үр ашигтай. Үүнийг үндэс болгон энэ чиглэлийн үйлдвэр байгуулах талаар манай улс 1970-аад оны үеэс эрчимтэй ажиллаж эхэлжээ.

1977 оны эцсээр Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор тус улсад ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах туршилтын үйлдвэрийг Японы тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар байгуулах шийдвэр гарчээ. Анхны туршилтийн үйлдвэр нь ноолуур ялгах, угаах, утас ээрэх, сүлжих үндсэн дамжлагуудаар байгуулагджээ. Бүтээгдэхүүнийг нь дэлхийн зах зээлд сурталчилж АНУ, Европын зарим орнуудад экспортолж эхэлснээр 1981 онд ноолуурган эдлэлийн “Говь” комбинат анх байгуулагдсан. Монголын ноолуур боловсруулах үйлдвэрлэл 90-ээд оныг хүртэл дан ганц “Говь” комбинатаар хязгаарлагдаж байлаа.

Сүүлийн жилүүдэд манай улсын ноолуурын салбарт үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай өндөр хүчин чадал бүхий үйлдвэрүүд ажиллаж байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан 28 компани (эдгээрээс 13 нь БНХАУ, 4 нь АНУ, 4 нь Япон, 3 нь Итали, 2 нь Их Британи, 1 нь Лихтенштэн, 1 нь ОХУ-ын хөрөнгө оруулалттай) дотоодын 4 компани үйл ажиллагаа явуулж байна.

Албан ёсны мэдээлэлд хамрагдсан 12 компанийн дунгээр манай улс жилдээ дунджаар 3.3 мянган тонн ноолуур боловсруулах хүчин чадалтай гэсэн тооцоо байдаг. Үүнд БНХАУ-ын хөрөнгө оруулалттай жижиг үйлдвэрүүд хамрагдаагүйг тооцвол манай улсын ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн нийт хүчин чадал бэлтгэж буй түүхий ноолуурынхаа хэмжээнээс давжээ.

Монголын ноолуурын үйлдвэрлэлийн нийт хүчин чадалд дийлэнх хувийг эзэлж байгаа “ГОВЬ” хувьцаат компанийн үзүүлэлтээр монголын ноолуурын салбараас гарч буй бэлэн бүтээгдэхүүний ашигт ажиллагааг төлөөлүүлэн тооцож үзвэл:

	сая төгрөг				
	1998	1999	2000	2001	2002
Цэвэр борлуулалт	16267.6	24389.7	21922.3	12285.0	20397.1
Цэвэр ашиг	3031.2	4205.3	2561.6	-4874.5	-1674.8
Борлуулалтын өгөөж	18.6	17.2	11.7	-39.5	-8.0
Хөрөнгийн өгөөж	10.5	14.0	7.6	-10.4	-4.4

Ноолуурын салбарын ашигт ажиллагаа сүүлийн жилүүдэд тогтолцоогаар буурч иржээ. Үүний үндсэн шалтгаан нь түүхий эд бэлтгэлийн зардал өөрөөр хэлбэл дотоодын ноолуурын үнэ дэлхийн зах зээл дээрх үнээс хамааралгүйгээр байнга есөн нэмэгдэж байсантай холбоотой.

Монголын ноолуурын салбарын үйл ажиллагаа дэлхийн зах зээл дээрх ноолуурын эрэлт хэрэгцээ, дэлхийн зах зээлийн үнэ, энэ үндэсний хүчинтэй нөлөөлөх Хятадын ноолуурын үйлдвэрлэл зэргээс ихээхэн шалтгаалж байдаг нь харагдаж байна. Ноолуурын салбарын ашигт ажиллагаа нь сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байгаа бөгөөд төдийлөн өндөр биш байна. Зээлийн хүү өндөр байгаа өнөөгийн нөхцөлд ноолуурын үйлдвэрүүд банкуудаас зээл авч түүхий эд бэлтгэх нь эрсдэлтэй гэж үзэх үндэслэл байна.

\* Судалгааг бүрэн эхээр нь Монголбанкны вэб хуудасны ([www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)) Нуйтлэл хэсгээс үзнэ үү

Тайлант онд 125.9 мянган тонн үр тариа, 51.9 мянган тонн төмс, 39.7 мянган тонн хүнсний ногоо хураасан нь өнгөрсөн оныхоос үр тариа 11.5 хувь буюу 16.4 мянган тонноор, төмс 10.6 хувь буюу 6.1 мянган тонноор буурчээ.

Хураасан үр тарианы 34.9 хувь нь Сэлэнгэ аймагт, 21.3 хувь нь Булган аймагт, 13.1 хувь нь Төв аймагт, төмсний 17.5 хувь нь Сэлэнгэ аймагт, 13.8 хувь нь Төв аймагт, 12.5 хувь нь Улаанбаатар хотод, 10.1 хувь нь Ховд аймагт тус тус ноогдож байна. Хүнсний ногооны 23.2 хувийг Сэлэнгэ аймаг, 17.6 хувийг Улаанбаатар хот, 12.0 хувийг Дархан-Уул аймаг, 9.8 хувийг Төв аймаг хураан авсан байна.

Нэг га-аас дунджаар 5.7 центр үр тариа, 56.4 центр төмс хураасан нь өнгөрсөн оныхоос үр тариа 1.4 центрээр, төмс 9.2 центрээр тус тус буурсан байна.

2002 онд 753.8 мянган тонн өвс хадлан, 25.3 мянган тонн тэжээл гараар бэлтгэжээ.

### **Барилга**

Тайлант онд барилгын компаниуд нийт 95.3 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэсэн нь өмнөх оныхоос 23.4 хувиар өссөн бөгөөд нийт гүйцэтгэсэн ажлын 74.7 хувийг дотоодын барилгын байгууллагууд, 25.3 хувийг гадаадын барилгын байгууллагууд эзэлж байна. Өнгөрсөн онтой харьцуулахад дотоодын барилгын байгууллагуудын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 10.4 тэрбум төгрөг, гадаадын барилгын байгууллагынх 7.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Мөн цахилгаан дамжуулах шугам, орон сууц, зам, зам засвар, эмнэлэг, сургууль, дотуур байр зэрэг 16.1 тэрбум төгрөгийн үндсэн фонд бүхий барилга, байгууламжийг ашиглалтанд оруулсан байна.

Монгол улсад хотжилт хурдацтай явагдаж, ялангуяа сүүлийн 10 жилд улам эрчимжих боллоо. Сүүлийн жилүүдэд тохиолдсон ган, зудын улмаас хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэн, томоохон хот суурин газрын нийгмийн ачааллыг ихээхэн хүндрүүлж байгаа ч орон сууцны барилга ихээр баригдаж байна. Тухайлбал, 2001 онд 275 айлын нийт 15 орон сууцны барилгыг ашиглалтанд оруулж байсан бол 2002 онд 828 айлын сууц бүхий 37 барилга ашиглалтанд оржээ. Тайлант онд Барилга корпораци, Нийслэл өргөө хувьцаат компани (ХК)-үүд, Алтан хот корпораци хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) эх үүсвэрийнхээ зарим хэсгийг бондын хэлбэрээр татаж, Монголын хөрөнгийн бирж (МХБ)-ээр 317.5 мянган ширхэг бонд арилжиж, 3.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийв.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны "Орон сууцны санхүүжилтийн төсөл"-ийн хүрээнд орон сууцны зээл олгох бэлтгэл ажил хангагдаж, тус зээлийг одоогийн байдлаар Голомт, Зоос, Монгол шуудан банкуудаар дамжуулан олгохоор болов.

#### Шигтгээ 4. Шилжилтийн эдийн засагтай орнуудын төсвийн зөрүүг ДНБ-д харьцуулсан байдал

Сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засгийн байдал тогтвортгүй байж, дахин гарч болох терроризм, болзошгүй дайны асуудлууд, Аргентины эдийн засгийн сүйрэл зэрэг нь энэ байдлыг улам даамжуулж байгаа хэдий ч шилжилтийн эдийн засагтай улсуудын эдийн засгийн ёсөлт, инфляци, төсвийн зөрүү зэрэг үндсэн үзүүлэлтүүд харьцангуй сайн байв. Монголын эдийн засгийн байдал ч мөн сүүлийн жилүүдэд тогтвортгиж, төсвийн үзүүлэлтүүд сайжрах хандлагатай байна. Төсвийн алдагдлыг ДНБ-д харьцуулсан дээрх хүснэгтээс үүнийг харж болох ба харин 1995-1996 оны төсвийн алдагдлын үзүүлэлтийн огцом ёсөлтийг Монгол улс 1996 оноос эхлэн төсвийн орлого, зарлага, зөрүүг олон улсын жишигт нийцсэн аргачлалаар тооцож эхэлснээр тайлбарлаж болно. Иймээс Монголын төсвийн алдагдлын үзүүлэлтийг эдгээр шилжилтийн эдийн засагтай 27 орны өрөнхий дундажтай харьцуулахдаа 1996-2002 оны тоонуудыг ашиглах нь илүү бодитой юм. Ерөнхий ёсөлт, бууралтын хандлага 1999 оноос харьцангуй төстэй байна. Харин эдгээр

		1995	1996	1997	1998	1999	2000	2001*	2002**
Төв ба зүн Европын ба Балтийн улсууд	Хорват	-1.4	-1	-1.9	-1	-6.5	-7.1	-5.8	-4.6
	Чех	-1.6	-1.9	-2	-2.4	-2	-4.2	-5.2	-9.3
	Эстон	-1.3	-1.5	2.2	-0.3	-4.6	-0.7	0.4	-1
	Унгар	-6.7	-5	-4.8	-4.8	-3.4	-3.3	-4.7	-6
	Латви	-4	-1.8	0.3	-0.8	-3.9	-3.3	-1.9	-2.5
	Литва	-4.5	-4.5	-1.8	-5.9	-8.5	-2.8	-1.9	-1.4
	Польш	-3.1	-3.3	-3.1	-3.2	-3.7	-3.2	-6	-5
	Словак	0.4	-1.3	-5.2	-5	-3.6	-3.6	-3.9	-4.5
	Словени	-0.3	-0.2	-1.7	-1.4	-0.9	-1.3	-1.2	-2.9
	Дундаж (ТЗЕБҮ)	-2.5	-2.3	-2	-2.8	-4.1	-3.3	-3.4	-4.1
Зүн-Энэд Европын уулсууд	Албани	-10.1	-12.1	-12.6	-10.4	-11.4	-9.1	-8.5	-8
	Босни Герцогевин	-0.3	-4.4	-0.5	-8	-9.1	-10.1	-6.3	-5.5
	Болгар	-5.7	-10.3	-2	0.9	-0.9	-1	-0.9	-0.8
	Югослав	-4.3	-3.8	-7.6	-5.4	0	-0.8	-1.9	-5.6
	Македон	-1	-1.4	-0.4	-1.7	0	2.5	-6.3	-4.4
	Румын	-2.5	-3.9	-4.6	-5	-3.5	-3.7	-3.5	-3
	Дундаж (ЗӨӨЕҮ)	-4	-6	-4.6	-4.9	-5	-3.7	-4.6	-4.6
	Армени	-9	-8.5	-5.8	-4.9	-7.4	-6.3	-3.8	-3.2
	Азербайжан	-4.9	-2.8	-1.6	-3.9	-4.7	-0.6	1.4	-0.1
	Беларусь	-2.7	-1.8	-1.2	-0.5	-1.8	0.3	-0.4	-0.7
Тусгэр Тотносон улсуудын Хамтын Унгар	Гурж	-5.3	-7.3	-6.7	-5.4	-6.7	-4.1	-2	-1.7
	Казакстан	-3.4	-5.3	-7	-8	-5.2	-1	-1.1	-2
	Киргиз	-17.3	-9.5	-9.1	-9.4	-11.8	-9.6	-6	-4.9
	Молдав	-13.1	-15.2	-14.1	-5.7	-6.1	-2.6	-0.5	-2.7
	Некерлэн	-6.1	-8.9	-8	-8	-3.3	3	2.9	1.5
	Орос	-3.3	-5.8	-3.3	-3.8	-3.1	-0.6	-0.1	-1
	Таджикистан	-2.6	0.3	0	-2.6	0	0.4	-0.8	-2
	Туркменистан	-6.1	-3.2	-5.4	-2.8	-2.4	0.8	-1.6	-1.8
	Украин	-4.1	-7.3	-2.4	-3	-2.7	-1.2	-0.5	-2.5
	Узбекистан	-6.5	-6.3	-5.4	-4.8	-4.6	-2	-0.9	-1.8
Тусгэр Тотносон улсуудын Хамтын Унгар	Дундаж (ТТУХН)	-4.6	-4.9	-4.1	-4.2	-4.3	-2.7	-2.6	-3.2
	Ерөнхий дундаж	-0.9	-7.5	-7.8	-12.5	-10.6	-7.5	-4.1	-5.7

\*-Урьдчилсан байдлаар

\*\*- Таамаглал

шилжилтийн орнуудын ихэнх, ялангуяа Төв ба Зүүн Европын орнуудын хувьд 2002 онд төсвийн алдагдал нь өмнөх оныхоос нэмэгдэх төлөвтэй байна. Үүний учир нь тэдний гол экспортын зах зээл болох Европын холбооны эдийн засгийн удаашралтай холбоотой хэмээн судлаачид үзэж байгаа юм. Эдгээр улсуудын дотор хамгийн том эдийн засагтай Польшоос гадна Чех, Унгар, Хорват, Словак улсуудын төсвийн алдагдал өндөр байгаа нь эдийн засгийн бэрхшээлийг үсгэж байгаа ба 2002 оны зүн болсон үерийн гамшиг нь энэхүү асуудлыг улам бүр хүндрүүлэх төлөвтэй байна. Зүүн Өмнөд Европын улсуудын хувьд Югославын задралаас хойш хөрөнгө оруулалт, худалдаа, хамтын ажиллагаа сайжирснаар энэ бүсийн орнуудын төсвийн алдагдлын үзүүлэлт сайжирч эхэлсэн нь одоо ч үргэлжилсээр байна. Харин ТТУХН-ын улсуудын төсвийн зөрүүгийн хэмжээ харилцан адилгүй байгаа ба хамгийн сайн үзүүлэлтэй байгаа нь 2000 оноос хойш эерг төсвийн зөрүүтэй байгаа ОХУ юм. Үүний тайлбар нь экспортын гол бүтээгдэхүүн болох газрын тосны үнийн ёсөлттэй шууд холбоотой бөгөөд хэрвээ нефтийн үнэ унаж эхэлбэл энэхүү төсвийн сайн үзүүлэлтэй хадгалахад бэрхшээлтэй болох нь гарцаагүй. Монгол улсын төсвийн алдагдал 2001 онд ДНБ-ийн 4.1 хувьтай байсан ба харин 2002 онд энэ нь 1.6 нэгжээр ёсч 5.7 хувьтай болжээ.

## Тээвэр холбоо

Бүх төрлийн тээврийн хэрэгслээр 13.5 сая тонн ачаа, давхардсан тоогоор 105.7 сая зорчигч тээвэрлэсэн нь өнгөрсөн оныхоос ачаа тээвэрлэлт 14.6 хувь буюу 1.7 сая тонноор, зорчигч тээвэрлэлт 7.3 хувь буюу 7.2 сая хүнээр өссөн байна.

2002 онд нийт тээвэрлэсэн ачааны 86 хувийг төмөр замаар, 14 хувийг авто тээврээр гүйцэтгэсэн бол зорчигч тээвэрлэлтийн 95.9 хувийг авто тээврийн, 3.8 хувийг төмөр замын, 0.3 хувийг агаарын тээврийн хэрэгслээр тээвэрлэжээ. Өмнөх онтой харьцуулахад авто тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн ачаа 13.9 хувь, зорчигч тээвэрлэлт 7.8 хувь, төмөр замаар тээсэн ачаа 14.7 хувь, агаарын зорчигч тээвэрлэлт 5.9 хувиар тус тус өссөн байхад агаарын тээврээр тээвэрлэсэн ачаа 17.2 хувь, төмөр замын зорчигч тээвэрлэлт 2.9 хувиар буурсан байна. Төмөр замын олон улсын зорчигч тээвэрлэлт 1.6 хувь буюу 2.6 мянган хүнээр өсч, дотоодын зорчигч тээвэрлэлт 3.1 хувь буюу 122.8 мянган хүнээр, агаарын тээврийн дотоодын зорчигч тээвэрлэлт 2.0 хувь буюу 2.4 мянган хүнээр тус тус буурсан байна. Агаарын зорчигч тээвэрлэлтийн гуравны хоёрыг олон улсын, гуравны нэгийг дотоодын, төмөр замын зорчигч тээвэрлэлтийн 95 хувийг дотоодын, 5 хувийг олон улсын зорчигч тээвэрлэлт эзэлж байна.

Тайлант онд тээврийн салбараас олсон нийт орлого 152.9 тэрбум төгрөгт хүрч, 2001 оныхоос 26.5 хувиар өсөв. Үүнээс төмөр замын тээврийн орлого хамгийн их буюу 56.7 хувь, агаарын тээврийнх 31.6 хувь, авто тээврийнх 11.7 хувийг эзэлж байна.

Холбоо ашиглалтын нийт орлого 2002 онд 38.7 тэрбум төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 14.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оныхоос 11.6 хувь буюу 2.2 тэрбум төгрөгөөр өсчээ. Телефон цэгийн тоо өнгөрсөн оныхоос 5.8 хувь буюу 7.0 мянгаар нэмэгдэж, радио цэгийн тоо 6.9 хувь буюу 8.4 мянгаар багасав.

## 2.2. Засгийн газрын санхүү

Тайлант оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн орлого 466.5 тэрбум төгрөг (ДНБ-ий 37.9 хувь), төсвийн зарлага 536.5 тэрбум төгрөг (ДНБ-ий 43.6 хувь) хүрч, төсвийн урсгал ашиг 51.7 тэрбум төгрөг (ДНБ-ий 4.2 хувь) болов. Харин төсвийн нийт алдагдал 70 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 5.7 хувьтай гарсан ба энэ нь 2000 оны төсвийн алдагдлын үзүүлэлттэй харьцуулбал 1.1 нэгжээр буурсан, 2001 оныхтой харьцуулбал 1.7 нэгжээр өссөн үзүүлэлт юм. Төсвийн алдагдлын дээрх үзүүлэлт нь Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2001 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-д тусгагдсан төсвийн алдагдлын хэмжээг ДНБ-ий 7.1 хувьтай тэнцэх хэмжээнд хүртэл бууруулах зорилтыг бүрэн хангаж байна.

Төсвийн үндсэн үзүүлэлтүүд 2001 оноос эхлэн сайжрах хандлага ажиглагдаж эхэлсэн ч төсвийн алдагдал өндөр, түүнийг гадаадын зээлээр санхүүжүүлэх

## Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэл

	2001 гүйцэтгэл	2002 төлөвлөлт	2002 гүйцэтгэл <sup>1</sup>	Гүйцэтгэлийн өөрчлөлт	тэрбум ₮
Нийт орлого ба тусlamж	424.5	447.7	466.5	42.0	
Ургал орлого	415.1	439.5	459.4	44.3	
Татварын орлого	319.4	341.3	356.5	37.1	
Орлогын албан татвар	65.0	68.9	70.9	5.9	
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	46.1	42.4	53.4	7.3	
Өмчийн татвар	1.6	4.0	3.0	1.4	
Дотоод бараа, үйлчилгээний татвар	164.7	176.8	178.5	13.8	
Гадаад худалдааны орлого	27.5	23.8	25.1	-2.4	
Бусад татвар	14.5	25.4	25.6	11.1	
Татварын бус орлого	95.7	98.2	102.9	7.2	
Хөрөнгийн орлого	0.3	0.2	0.5	0.2	
Тусlamжийн орлого	9.1	8.0	6.6	-2.5	
Нийт зарлага ба цэвэр зээл	470.0	530.1	536.5	66.5	
Ургал зарлага	359.0	402.9	407.8	48.8	
Бараа ба үйлчилгээний зарлага	247.6	272.8	280.4	32.8	
Цалин хөлс	91.6	104.4	105.3	13.7	
Бараа үйлчилгээний бусад зардал	156.0	168.4	175.1	19.1	
Зээлийн үйлчилгээний зардал	16.2	20.6	17.7	1.5	
Татаас ба ургал шилжүүлэг	95.2	109.5	109.7	14.5	
Татаас	5.7	9.4	9.1	3.4	
Ургал шилжүүлэг	89.5	100.1	100.6	11.1	
Хөрөнгийн зардал	50.3	56.0	63.7	13.4	
Эргэж төлөгдөх цэвэр зээл	60.7	71.2	65.0	60.7	
Ургал тэнцэл	56.1	36.6	51.6	-4.5	
Нийт тэнцэл	-45.5	-82.4	-70.0	-24.5	
Алдагдлыг санхүүжүүлсэн эх үүсвэр	45.5	82.4	70.0	24.5	
Гадаад, цэвэр	62.5	91.8	75.4	12.9	
Ашиглах төслийн зээл	58.3	83.0	75.8	17.5	
Ашиглах санхүүгийн зээл	23.9	21.6	16.3	-7.6	
Зээлийн үндсэн өрийн төлбөр	-19.7	-12.8	-16.7	3.0	
Дотоод, цэвэр	-17.0	-9.4	-5.4	11.6	

<sup>1</sup> Урьдчилсан байдлаар

явдал үргэлжилсэн хэвээр байна. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд гадаадын 92.1 тэрбум төгрөгийн зээл зарцуулсан нь 75.8 тэрбум төгрөг нь ашиглах төслийн зээл, 16.3 тэрбум төгрөг нь ашиглах санхүүгийн зээл байв. 2002 онд нийт 16.7 тэрбум төгрөгийн гадаад зээлийн үндсэн өрийн төлбөр хийгдэж, гадаад цэвэр эх үүсвэрийн хэмжээ 75.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оныхоос 20.6 хувь буюу 12.9 тэрбум төгрөгөөр өсчээ.

Нийт татварын орлогыг ДНБ-д харьцуулан тооцдог татварын ачааллын үзүүлэлт нь 2001 онд 28.6 хувь, 2002 оны урьдчилсан гүйцэтгэлээр 0.4 нэгжээр өсч 29.0 хувь болсон нь бизнес эрхлэгчдэд ноогдох татварын дарамтыг ихэсгэж байна.

УИХ-аас 2002 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай" хуулийг баталж, 1992 оны 12 дугаар сарын 21-ний өдөр батлагдсан "Монгол Улсын төсвийн тухай" хуулийг хүчингүй болголоо. УИХ-ын 2002 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар "Хүн амын орлогын албан татварын тухай," "Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тухай" болон "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулиудад нэмэлт, өөрчлөлтийг оруулсан ба эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болох юм.

### Төсвийн орлого


2002 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн нийт орлогын 98.5 хувийг урсгал орлого, 1.4 хувийг тусlamжийн, 0.1 хувийг хөрөнгийн орлого тус тус эзэлж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг өмнөх оныхтой харьцуулахад урсгал орлогын нийт орлогод эзлэх хувь 0.7 нэгжээр нэмэгдэж, тусlamжийн орлого 0.7 нэгжээр буурч, харин хөрөнгийн орлогод өөрчлөлт гаралаагүй байна.

2002 оны төсвийн урсгал орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогод эзлэх татварын орлого 76.4 хувь, татварын бус орлого 22.1 хувийг эзэлж байгаа нь 2001 оны гүйцэтгэлтэй харьцуулахад татварын орлого 1.2 нэгжээр өсч, харин татварын бус орлого 0.4 нэгжээр буурчээ.


Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 104.5 хувь байгаа нь дотоодын онцгой болон бараа үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдээс хураах татварын орлого, импортын пиво, тамхи, суудлын автомашины татварын орлогоос бусад 18 гол нэр төрлийн орлого давж биелсэнтэй голчлон холбоотой байна.

Хүн амын орлогын албан татвар өнгөрсөн оныхоос 26.6 хувь буюу 5.5 тэрбум төгрөгөөр өссөн ба үүний дотор хувиараа аж ахуй эрхлэгчдийн татварын орлого 84.6 хувиар өссөн нь хөдөлмөр эрхлэлтийн түвшин дээшилсэн, өрхийн мөнгөн орлого нэмэгдсэнтэй холбоотой.


Зураг 16. Төсвийн алдагдал (ДНБ-д эзлэх хувиар)



Зураг 17. Нийт орлого ба тусламж



Зураг18. Нийт зардал ба цэвэр зээл



Татварын бус орлого 102.9 тэрбум төгрөг байсан нь төлөвлөгөөнөөс 4.7 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар давж биелсэн байна. Энэ төрлийн орлогын дийлэнхийг хувьцааны ноогдол ашиг, навигаци, төсөвт байгууллагын өөрийн орлого эзэлж байна.

Улсын нэгдсэн төсвийн дүнгээр өмчийн татварын орлого 2.9 тэрбум төгрөг байсан ба энэ нь төлөвлөсөн хэмжээнээс 1.0 тэрбум төгрөгөөр (25.3 хувь) доогуур байна. Үүний гол шалтгаан нь орон нутгийн төсөвт орох үл хөдлөх хөрөнгийн татварын орлого хураалт сайн зохион байгуулагдаагүйтэй холбоотой юм.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Өмч хувьчлалын талаар тавигдсан зорилтыг ханган биелүүлж, Засгийн газрын 2002 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхэд Өмч хувьчлалын ажлыг чиглүүлэн ажилласан ба уг хөтөлбөрийн дагуу 2002 онд нийт 14 аж ахуйн нэгжийг хувьчилж, 11 үл хөдлөх хөрөнгийг худалдан, улсын төсөвт 15.9 тэрбум төгрөг оруулсан нь өнгөрсөн оныхоос 10.7 тэрбум төгрөгөөр илүү байна.

### Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага 536.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт санхүүжилт 6.4 тэрбум буюу 1.2 хувиар илүү хийгдсэн байна. Улсын төсвөөс хийгдэх нийгмийн хамгаалал, бараа үйлчилгээ худалдан авалт, цалин, тэтгэвэр, тэтгэмж, хангамж, нөхөн олговор, орон нутагт өгөх шилжүүлэг, дотоодын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл бүрэн санхүүжигдэв.

Улсын төсвийн зарлагыг авч үзвэл төсвийн нийт зарлагад бараа, үйлчилгээний зардал 52.3 хувь, зээлийн үйлчилгээний зардал 3.3 хувь, татаас ба урсгал шилжүүлэг 20.4 хувь, хөрөнгийн зардал ба цэвэр зээл 23.6 хувийг тус тус эзэлж байна. 2001 оныхтой харьцуулахад бараа үйлчилгээний зардлын хувь 0.4 нэгж, зээлийн үйлчилгээний зардал 0.1 нэгж, хөрөнгийн зардал ба цэвэр зээлийн хэмжээ 0.4 нэгжээр буурч, харин татаас ба урсгал шилжүүлэг 0.1 нэгжээр өсчээ. Бараа үйлчилгээний зардал 6.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс хэтэрсэн боловч төсөвт байгууллагын түлш халаалтын зардал 1.5 тэрбум, гэрэл цахилгааны зардал 758.8 сая, цэвэр бохир усны зардал 196.1 сая, тээвэр шатахууны зардал 106.2 сая төгрөгөөр тус тус хэмнэгдлээ.

Төсвөөс санхүүжих зээлийн үйлчилгээний төлбөр төлөвлөгөөнөөс 2.9 тэрбум төгрөгөөр хэмнэгдэв. Энэ нь төсвийн мөнгөн урсгалын зохицуулалтыг сайжруулсантай холбоотой юм.

Улсын болон орон нутгийн төсөвт байгууллагад өнгөрсөн онуудаас шилжсэн өглөгийг барагдуулахад онцгой анхаарч үндсэндээ 2002 онд төсвийн өргүйгээр дараа онд шилжих нөхцөлийг бүрдүүллээ.

Хөрөнгийн зардал 63.7 тэрбум төгрөг болж төлөвлөгөөнөөс 7.7 тэрбум төгрөгөөр давж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.4 тэрбум төгрөгөөр илүү байна. Хөрөнгийн санхүүжилтийн энэ өсөлтийн дийлэнхийг дотоодын эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалтын өсөлт эзэлж байна.

Дотоод эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт 2001 оныхоос 16.2 хувиар өсч 50.2 тэрбум төгрөг болсон ба үүний дотор төсвийн хөрөнгө оруулалт, их засвар, авто замын сан ашиглалт, геологи хайгуулын санхүүжилт, ойжуулалт, байгаль орчны бусад арга хэмжээ, улсын нөөц бүрдүүлэлтэд олгогдох санхүүжилт зэрэг бүх үндсэн төрөл дээр давсан үзүүлэлтэй байна.

1991 оноос хойш дорвитой өөрчлөлт огт хийгдээгүй төсвийн зарлагын бүтэц, хэлбэрийг зах зээлийн эдийн засгийн хэв маягтай уялдуулан өөрчлөх зорилго бүхий төрийн албаны шинэчлэлийн зарчмын ажил 2002 оноос эхэлсэн нь тайлант оны бүтцийн гол өөрчлөлтийн нэг байлаа. Мөн УИХ-ын 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 56 тоот тогтоолоор "Нийгмийн салбар төөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийг баталсан ба энэхүү үндсэн чиглэл нь нийгмийн салбар дахь хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үйлчилгээний үр ашиг, хүртээмжийг сайжруулах гэсэн үндсэн зорилготой юм.

### **2.3. Төлбөрийн тэнцэл**

Тайлант онд дэлхийн эдийн засагт өсөлтийн хандлага ажиглагдах болсон, дэлхийн зах зээлд манай улсын экспортын голлох түүхий эд алтны үнэ өсч зэсийн үнэ тогтвортой байсан, 2002 оны дундаас төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханшинд хөдөлгөөн орж эхэлсэн, улсын гадаад валютын нөөц өссөн зэрэг нь төлбөрийн тэнцэлтэй холбоо бүхий гол үйл явдлууд байлаа.

Мөн Засгийн газраас 2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгон зарлаж, уул уурхай, хөдөө аж ахуй, дэд бүтэц, аялал жуулчлал, банк санхүү, мэдээлэл холбооны технологи, барилга зэрэг хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбаруудад голлон анхаарч ажиллав.

Гэвч өнгөрсөн 2-3 жилд болсон байгалийн гамшигт үзэгдлийн улмаас гол төлөв хөдөө аж ахуйн чиглэлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл багасч, дэлхийн зах зээлд манай улсын экспортын голлох түүхий эд ноолуурын үнэ бага байсан зэрэг сөрөг нөлөөллүүд гарлаа.

### **Урсгал данс**

Тайлант онд урсгал дансны алдагдал урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ-ий 12.1 хувьтай тэнцүү байна. Урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх жин өнгөрсөн онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн нь худалдааны тэнцлийн алдагдлаас голлон шалтгаалжээ. Өнгөрсөн жилүүдэд гарсан байгалийн гамшигт үзэгдлийн

нөлөөгөөр дотоодын үйлдвэрлэл, ялангуяа хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл буурсан нь эдгээр салбарын бүтээгдэхүүнүүдийн дотоод эрэлтийг импортын бараа бүтээгдэхүүнээр хангахад хүргэлээ. Сүүлийн жилүүдэд тогтвортой өсч байгаа аж үйлдвэр, барилга, харилцаа холбоо, тээвэр зэрэг салбаруудад хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь гадаад эх үүсвэрээр санхүүжигдсэн, дотоодын зах зээлд эцсийн бүтээгдэхүүн болон техник технологийн үйлдвэрлэлийн хөгжил сүл байгаагаас эдгээр салбаруудад ашиглагдах бараа материал, техник технологийн өсөлтийг импортоор хангасан зэрэг нь урсгал данс, ялангуяа худалдааны тэнцлийн алдагдал нэмэгдэхэд голлон нөлөөлж байна. Мөн 2000 оноос төгрөг, америк долларын нэрлэсэн ханш тогтмол явж ирсэн нь урсгал дансны алдагдал өсөхөд нөлөөлсөн байж болох юм. Тайлант онд улсын төсвийн нийт тэнцлийн алдагдал өнгөрсөн оныхтой харьцуулахад 53.8 хувь, гадаад эх үүсвэрийн санхүүжилт 20.6 хувиар тус тус нэмэгдсэн нь урсгал дансанд сөрөг нөлөө үзүүлэв.


Тайлант оны эцэст хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон төгрөгийн бодит ханшийн индекс өнгөрсөн онтой харьцуулахад 3 нэгжээр суларсан байна. Гадаад худалдаанд 70 орчим хувийг эзэлж байгаа АНУ, ОХУ, Хятадын үндэсний валютуудтай харьцах төгрөгийн ханш суларсан, хэрэглээний барааны үнийн индекс дээрх улсуудтай ижил түвшинд байсан зэрэг нь бодит ханш сулрахад голлон нөлөөлөв.

Урсгал дансны орлогод бараа бүтээгдэхүүний экспортын эзлэх хувийн жин өнгөрсөн онтой харьцуулахад 6 хувиар буурч, энэ хэмжээгээр үйлчилгээний экспортын хувийн жин нэмэгджээ. Харин урсгал дансны зарлагад бараа бүтээгдэхүүний импортын эзлэх хувь 2 нэгжээр нэмэгдэж, энэ хэмжээгээр үйлчилгээний импортын хувийн жин багассан байна.


Урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт эргэлт 1160 сая ам. долларт хүрч, өнгөрсөн оны түвшинд байна. Нийт экспортын хэмжээ 500.9 сая ам. доллар, импорт 752.4 сая ам. долларт хүрч, гадаад худалдааны тэнцлийн алдагдал ДНБ-ий 23.0 орчим хувьтай тэнцүү байна.

Дэлхийн эдийн засгийн зогсонги байдал нь манай улсын экспортын байдалд нөлөөлсөөр байна. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох зэсийн баяжмалын нийт экспортод эзлэх хувийн жин буурч 27.6 хувийг эзлэх боллоо. Зэсийн баяжмалын экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 0.4 хувиар, үнийн дүн нь 6.6 хувиар тус тус буурсан байна. Самнасан ноолуурын экспорт 45.3 хувиар багасч 30.1 сая ам. долларт хүрчээ. Харин дэлхийн үнэт металлын зах зээл дээрх алтны үнийн тааламжтай нөхцөлд Монголбанкнаас 12.4 тонн буюу 117.4 сая ам. долларын алтыг олон улсын банк санхүүгийн байгуулагад зарсан нь гадаад худалдааны тэнцэлд эерэгээр нөлөөлөв. Худалдсан алт үнийн дүнгээрээ 57.4 хувиар (хэмжээгээрээ 46.0 хувиар) өссөн нь нийт экспортын 23.5 хувийг эзэлж байна.


Зураг 19. Худалдааны тэнцэл



Зураг 20. Төлбөрийн тэнцэл (цэвэр дүнгээр)



Зураг 21. Ургалдансын орлого ба зарлагын бүтэц



Импортолсон бараа бүтээгдэхүүний хэмжээ 3.3 хувиар өссөн нь голчлон валютын төлбөртэй бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа, гадаадын захиалагчийн материал, эд зүйлсийн импортын өсөлттэй холбоотой байлаа. Хүнсний төрөл бүрийн бүтээгдэхүүний импорт 10.6 хувиар, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлийн импорт 10 хувиар, өргөн хэрэглээний барааны импорт 16.4 хувиар өссөн нь нийт импортын өсөлтөд голлон нөлөөлөв. Нефтийн бүтээгдэхүүний импорт тайланд онд буурч нийт импортын 16.7 хувийг эзэлж 110.0 сая ам. доллар болсон байна.

2002 онд гадаад орнуудтай хийгдсэн худалдааны эргэлтийг бүтцээр нь авч үзвэл: Хөрш орнуудтай хийгдэж буй худалдаа нийт гадаад худалдааны 52.5 хувь, өндөр хөгжилтэй аж үйлдвэржсэн орнууд 43.4 хувь, хөгжиж байгаа болон шилжилтийн эдийн засагтай орнууд 4.1 хувийг тус тус эзэлж байна. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэсийн баяжмалын 92.0 хувийг БНХАУ-д, мөнгөжөөгүй алтны экспортын 61.0 хувийг АНУ-д, нефть бүтээгдэхүүний 89.3 хувийг ОХУ-аас импортолж байна. Аж үйлдвэржсэн орнуудтай хийгдэж буй гадаад худалдаа 32.9 сая америк доллараар өсөж, нийт гадаад худалдаанд эзлэх хувийн жин 2.9 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант онд дэлхийн зах зээлд төрөл бүрийн металлууд, мод зэрэг манай улсын экспортын голлох түүхий эдүүдийн үнэ өнгөрсөн онтой харьцуулахад буурч, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн байна. 2002 онд бараа бүтээгдэхүүний экспортийн өртөг болон биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч импортын өсөлтөөс бага байна. Түүнчлэн өнгөрсөн онтой харьцуулахад экспортын зарим бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн ч импортын бараа бүтээгдэхүүний үнэ илүү хурдацтай өссөн нь манай улсын худалдааны нөхцөлийг бууруулж, гадаад худалдааны алдагдал нэмэгдэхэд нөлөөлөв.

Манай улсын экспортын бүтэц цөөн нэрийн түүхий эдийн үйлдвэрлэл, тэдгээрийн зах зээлийн үнийн байдлаас хамааралтай хэвээр байна. 2002 онд зэсийн баяжмал, алт, самнасан ноолуур манай улсын экспортын 57.0 хувийг бүрдүүллээ. Бэлэн бүтээгдэхүүн, ялангуяа оёмол болон сүлжмэл бүтээгдэхүүний экспортын хэмжээ сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц нэмэгдэж, энэ онд экспортын

#### Хүснэгт 4. Гадаад худалдааны нөхцөл

	Өнгөрсөн онтой харьцуулсан жилийн өөрчлөлт, хувиар	
	2001	2002 <sup>1</sup>
Экспортын өргтийн өөрчлөлт	(2.4)	12.0
Экспортын биет хэмжээний өөрчлөлт	10.8	8.9
Экспортын үнийн индексийн өөрчлөлт	(11.9)	2.8
Импортын өргтийн өөрчлөлт	2.5	16.1
Импортын биет хэмжээний өөрчлөлт	4.3	13.2
Импортын үнийн индексийн өөрчлөлт	(1.6)	4.8
Худалдааны нөхцлийн өөрчлөлт	10.3	(2.0)

<sup>1</sup> ОУВС-гийн урьдчилсан тооцоо

## Хүснэгт 5. Төлбөрийн тэнцэл

	2001	2002 <sup>1</sup>				сая ам.доллар
		I	II	III	IV	
Худалдааны тэнцэл	-169.9	-11.4	-94.9	-108.0	-37.2	-251.5
Экспорт ФОВ	523.2	115.0	111.1	124.1	150.8	500.9
Үүнээс: Зэсийн баяжмал	147.9	27.1	37.4	38.2	35.4	138.1
Мөнгөжөөгүй алт	74.7	44.4	20.5	14.6	38.1	117.6
Бусад	300.6	43.5	53.2	71.2	77.3	245.2
Импорт СИФ	-693.1	-126.4	-206.0	-232.1	-188.0	-752.4
Үүнээс: Гаалиар бүртгэгдсэн	-630.1	-114.9	-187.3	-213.5	-170.9	-686.5
Үйлчилгээний тэнцэл	-22.2	-13.9	-6.1	25.6	-19.3	-13.8
Орлого	113.5	27.4	41.9	80.5	34.8	184.5
Зарлага	-135.7	-41.3	-48.0	-54.9	-54.1	-198.3
Орлого /цэвэр/	-2.0	1.0	-4.3	-1.1	-0.1	-4.5
Хүүгийн төлбөр	-8.8	-1.1	-4.1	-2.4	-3.1	-10.8
Хувийн гүйвуулга	25.0	2.7	9.8	15.3	36.5	64.4
Ургал дансны алдагдал						
/албан шилжүүлгийг үл оролцуулсан/	-169.1	-21.5	-95.5	-68.3	-20.1	-205.4
Албан ёсны буцалтгүй шилжүүлэг	107.4	22.4	20.8	16.0	14.0	73.2
Албан ёсны тусламж	92.1	16.8	15.3	10.6	10.3	53.0
Бусад	15.3	5.6	5.5	5.4	3.7	20.2
Ургал дансны алдагдал	-61.6	0.9	-74.7	-52.3	-6.1	-132.2
Хөрөнгийн данс	97.7	24.9	23.0	74.4	36.4	158.6
Шууд хөрөнгө оруулалт	43.0	7.0	20.0	22.8	28.0	77.8
Санхүүгийн хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дунд, урт хугацаат зээл	68.6	7.9	4.3	76.4	13.0	101.6
Үүнээс: Ашигласан	167.1	31.9	20.9	101.5	32.7	187.0
Үндсэн өрийн төлбөр	-98.5	-23.9	-16.7	-25.1	-19.7	-85.4
Засгийн газрын зээл ашиглалт	66.2	11.9	8.4	29.9	22.7	72.9
Үүнээс: Ашигласан	84.2	13.7	10.3	33.0	30.0	86.9
Үндсэн өрийн төлбөр	-18.0	-1.8	-1.9	-3.1	-7.2	-14.0
Аж Ахуйн Нэгжийн зээл ашиглалт	2.4	-4.0	-4.1	46.6	-9.8	28.7
Үүнээс: Ашигласан	82.9	16.2	10.7	68.5	2.7	98.2
Үндсэн өрийн төлбөр	-80.5	-20.3	-14.8	-22.0	-12.5	-69.5
Арилжааны банк /цэвэр/	1.4	0.9	5.8	-15.3	-0.8	-9.5
Богино хугацаат хөрөнгө	-15.3	9.0	-7.0	-9.5	-3.7	-11.2
Залруулга	-52.0	10.0	66.3	-29.6	-0.7	46.0
Нийт төлбөрийн тэнцэл	-15.9	35.7	14.7	-7.5	29.6	72.4
Санхүүжилт	15.9	-35.7	-14.7	7.5	-29.6	-72.4
Валютын албан нөөцийн өөрчлөлт	11.1	-35.7	-13.5	8.2	-29.6	-70.6
ОУВС-гийн зээлийн ашиглалт	-1.7	-1.9	-2.0	-2.0	-2.0	-7.8
Нийт албан нөөцийн өөрчлөлт	12.8	-41.4	-8.8	15.0	-27.6	-62.8
Зээлийн өрийн үлдэгдэл	4.8	0.0	-1.2	-0.7	0.0	-1.8
Хугацаа хойшлуулсан өр	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эх үүсвэрийн дутагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

<sup>1</sup> Урьдчилсан байдлаар

19.0 хувийг бүрдүүлсэн байна.

Тайлант онд дэлхийн 75 оронтой гадаад худалдааны хүрээнд хамтран ажиллав. Гадаад орнууттай хийсэн худалдааны бүтцэд томоохон өөрчлөлт гараагүй бөгөөд гадаад худалдааны эргэлтийн 80 орчим хувь нь Хятад, Орос, Америк, Солонгос, Япон зэрэг орнуудад ноогдож байна.

Засгийн газраас хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбаруудад аялал жуулчлал, мэдээлэл холбооны технологи, банк санхүү, тээвэр зэрэг үйлчилгээний салбаруудыг багтаан, дэмжин ажиллаж байгаа нь эдгээр салбаруудын үйлчилгээний цар хүрээ нэмэгдэх нөхцөлийг хангаж байна. Урсгал тэнцлийн орлогын 22.0 хувийг үйлчилгээний орлого бүрдүүлсэн бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 6.0 хувиар нэмэгдсэн байна. Монгол орныг сонирхох гадаадын жуулчдын тоо жил бүр нэмэгдэж байгаа нь аялал жуулчлал үйлчилгээний голлох салбар болж, зөвхөн энэ салбарын төдийгүй агаар, төмөр замын тээвэр, харилцаа холбоо, банк, санхүүгийн үйлчилгээний орлого нэмэгдэх боломжийг бүрдүүлэв. Үйлчилгээний орлогын 70.5 хувь нь аялал жуулчлалын салбарт ноогдож байна.

Арилжааны банкуудын гадаад активын хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 35.1 хувиар нэмэгдсэн ч дэлхийн эдийн засгийн уналтын улмаас зах зээлийн хүүний түвшин 2002 оны туршид бага хэвээр байсан тул хүүний орлого буурав. Гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудад төлсөн ноогдол ашиг өнгөрсөн оны түвшинд байсан бол Засгийн газар, аж ахуйн нэгжүүдийн гадаадаас авсан зээлийн хүүний төлбөр нэмэгджээ.

Аж үйлдвэржсэн орнуудад, ялангуяа БНСУ, Герман, АНУ, Япон, Их Британи улсуудад ажиллахаар гарч байгаа хүний нөөцийн урсгал жил бүр нэмэгдсээр байна. Энэ нь хөгжиж байгаа болон шилжилтийн эдийн засаг бүхий бусад орнуудад тохиолддог нийтлэг гэж хэлж болох хандлага юм. Гадаад орнуудад хөдөлмөр эрхлэгч иргэдийн тоо байнга нэмэгдэж, тэдгээрийн мөнгөн гүйвуулгын урсгал дансанд эзлэх хувь ихэссээр байна. Зарим судалгааны дүнгээс үзэхэд гадаад орнуудад хөдөлмөр эрхлэгч иргэдийн хувийн гүйвуулгын хэмжээ ДНБ-ий 10 гаруй хувьд хүрч, үл хөдлөх хөрөнгийн зах болон гадаад валютын захын эрэлт, нийлүүлэлт зэрэгт нөлөө үзүүлэхүйц хэмжээнд хүрчээ.

#### Хүснэгт 6. Шатахууны төрлийн бус түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн индекс (1990=100)

	2001	2002 <sup>1</sup>
Түүхий эдийн төрөл		
Хүнсний бүтээгдэхүүн	86.3	94.6
ХАА-н гаралтай түүхий эд	97.0	97.3
Металл	75.9	72.7
Бордоо	100.3	101.7
Мод	121.8	115.5
<sup>1</sup> Урьдчилсан тооцоо		

## Хүснэгт 7. Гадаад худалдааны бүтэц

Орнууд	Нийт дүнд эзлэх хувиар					
	Экспорт		Импорт		Худалдааны эргэлт	
	2001	2002	2001	2002	2001	2002
Хөрш орнууд	53.0	50.3	54.3	54.2	53.7	52.5
ОХУ	8.6	8.6	35.4	34.1	23.4	23.1
БНХАУ	44.4	41.7	18.8	20.2	30.3	29.5
Аж үйлдвэржсэн орнууд	45.8	48.5	36.2	39.4	40.5	43.4
Их долоогийн бүлгийн орнууд	37.1	38.7	18.0	15.9	26.6	25.9
АНУ	27.8	31.6	2.2	3.5	13.7	15.7
Япон	3.0	1.3	8.8	6.0	6.2	4.0
ХБНГУ	0.4	0.5	4.8	4.5	2.8	2.8
Франц	0.1	0.0	1.0	0.7	0.6	0.4
Итали	3.2	1.7	0.5	0.4	1.8	1.0
Их Британи	2.4	3.5	0.6	0.4	1.4	1.7
Канад	0.2	0.1	0.2	0.4	0.2	0.3
Европын холбоо	7.0	6.5	10.3	8.3	8.9	7.5
Европийн бүс	4.7	3.0	8.5	7.3	6.8	5.4
Шинээр аж үйлдвэржсэн Азийн орнууд	5.2	5.1	13.6	18.8	9.8	12.9
Гонконг	1.3	0.6	2.5	4.3	2.0	2.7
Солонгос	3.9	4.4	9.1	12.2	6.8	8.8
Сингапур	0.0	0.0	1.6	1.7	0.9	0.9
Бусад аж үйлдвэржсэн орнууд	2.6	4.0	1.1	2.5	1.8	3.1
Австрали	1.9	3.5	0.2	1.7	1.0	2.5
Хөгжиж байгаа орнууд	0.4	0.6	1.8	1.8	1.2	1.3
Ази	0.0	0.0	1.5	1.5	0.9	0.8
Ойрхи Дорнод ба Турк	0.2	0.3	0.2	0.2	0.2	0.2
Өмнөд ба Хойд Америк	0.2	0.3	0.0	0.1	0.1	0.2
Шилжилтийн эдийн засагтай орнууд	0.8	0.6	7.7	4.6	4.6	2.8
Төв ба Зүүн Европ	0.6	0.0	3.8	2.8	2.3	1.6
Хуучин социалист орнууд	0.2	0.5	5.2	2.7	2.9	1.7

Гадаадад ажиллагсдын хувийн гүйвуулга нь зөвхөн хадгаламжийн дүнд нөлөөлөөд зогсохгүй, ханшиг тогтвортжуулах, байр орон сууцны үнийн өсөлт зэрэгт нөлөөлж байгаа тул БНСҮ, Герман, АНУ, Их Британиас ирдэг хувийн гүйвуулгын цар хүрээ, хэмжээний талаар дорвитой судалгаа тоо баримт шаардлагатай байна.

### Хөрөнгийн данс

Урсгал дансны алдагдлыг урт хугацааны шууд хөрөнгө оруулалт болон зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн хэвээр байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ ДНБ-ий 7.0 орчим хувьтай тэнцүү болж, өнгөрсөн онтой харьцуулахад 2 нэгжээр нэмэгдсэн байна. Засгийн газрын өмч хувьчлалын хөтөлбөр батлагдан хэрэгжиж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдэх боломжийг хангаж байна. Сүүлийн жилүүдэд хувийн секторын хөгжлийг урт хугацаанд дэмжих зорилгоор Дэлхийн банкнаас "Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт"-ыг Засгийн газартай хамтран

Улаанбаатар хотод тогтмол зохион байгуулж байгаа нь гадаадын хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.

Тайлант онд хөрөнгө оруулалт хийх сонирхлоо илэрхийлсэн гадаадын аж ахуйн нэгжийн тоо 387, бүртгүүлсэн хөрөнгийн хэмжээ 51.0 сая ам. доллараар тус тус нэмэгдсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 80 орчим хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, нийтийн хоол, уул уурхай, олборлох үйлдвэр, банк санхүү, боловсруулах үйлдвэрийн салбарт ноогдож байна. Худалдаа, нийтийн хоолны салбарт оруулахаар бүртгүүлсэн хөрөнгө оруулалт хамгийн их буюу нийт хөрөнгө оруулалтын 50 орчим хувийг эзэлж байна. Хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбарын нэг болох банк санхүүгийн салбарт анх удаа гадаадын томоохон шууд хөрөнгө оруулалт хийгдлээ. Өмч хувьчлалын хөтөлбөрийн дагуу хөрөнгө болон ашгийн хэмжээгээрээ манай улсад хамгийн том Худалдаа хөгжлийн банкны төрийн мэдлийн хувьцааг гадаадын хөрөнгө оруулагчдад худалдав.

Хөрөнгө оруулалтын хэмжээгээр Хятад, БНСУ, Канад, АНУ-ын хөрөнгө оруулагчид тэргүүлэх байр эзэлж, нийт хөрөнгө оруулалтын 85 орчим хувийг эзэлж байна.

1991 оноос хойш олон улсын банк, санхүүгийн байгуулага, хандивлагч орнуудаас авсан зээлийн нийт өрийн үлдэгдэл ДНБ-ий 82.0 хувьтай тэнцүү байна. Эдийн засгийн өсөлтийг хангах дотоод эх үүсвэрийн дутагдалтай байдлаас шалтгаалан гадаад өр цаашид ч нэмэгдэх хандлагатай байгаа тул энэ үзүүлэлт улам өсөх төлөвтэй байна.

Тайлант онд Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагуудаас 86.9 сая ам. долларын урт ба дунд хугацаат зээлийг олгосноос, Азийн Хөгжлийн банк, БНСУ, Япон улсын засгийн газар, Дэлхийн банкинд нийт зээлийн 82.0 хувь нь ноогдож байна. Зээлийн хөрөнгийн 68.9 хувь нь дэд бүтцийг сайжруулах, хувийн секторыг дэмжих, засаглал болон шүүх эрх зүйн шинэтгэлийг хөгжүүлэх, тогтвортой амьжиргааг дээшлүүлэх төслүүдэд, үлдэх хувь нь улсын төсвийн санхүүжилтэнд зарцуулагджээ.

Тайлант онд хийгдсэн нийт гадаад өрийн үйлчилгээ экспортын 7.0 хувь, төсвийн орлогын 8.0 хувьтай тэнцүү байна.

1991 оноос хойш авсан гадаад зээлийн дийлэнх хэсгийг Засгийн газар хоорондын болон Засгийн газрын баталгаа бүхий зээл эзэлж байсан бол сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн гадаад зээлийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

2002 оны эцсийн байдлаар гадаад валютын цэвэр албан нөөц 225.9 сая ам. долларт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 41.2 хувиар нэмэгджээ. Гадаад валютын цэвэр албан нөөц импортын 15.6 долоо хоногийн хэмжээг хангахуйц түвшинд хүрлээ.

### Шигтгээ 5. Шилжилтийн эдийн засагтай орнуудын төлбөрийн тэнцэл/ДНБ-ний харьцаа

2002 онд Монгол улсын гадаад худалдааны ургал дансны алдагдал ДНБ-ий 12.1 хувийг эзэлж байна. Энэхүү үзүүлэлт өмнөх оныхоос 2 дахин нэмэгдсэн нь худалдааны тэнцлийн алдагдлаас голлон шалтгаалжээ. Мөн улсын төсвийн нийт тэнцлийн алдагдал өмнөх оныхоос 54 хувиар өссөн нь ургал дансанд сөргөөр нөлөөлсөн байна. Монгол улс ургал

дансны алдагдалын хэмжээгээрээ бусад шилжилтийн эдийн засагтай улсуудтай харьцуулахад их байгаа ба Зүүн өмнөд Европын орнуудын дундажтай ойролцоо байна. Төв Европ болон Балтийн орнууд ба ТТУХН-ын орнуудын дунджаас их байна. Монгол улстай харьцуулахад эдгээр орнуудын эдийн засаг нь ургал тэнцлийн алдагдлаа гадаад хөрөнгө оруулалт, зээлээр нөхөх бололцоо нь их юм. Шилжилтийн эдийн засагтай орнуудын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бодлого нь улс улсын хувьд өөр боловч өнөөгийн ерөнхий байдлаас шалтгаалан ихэнх улсуудын хувьд

		1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Төв ба Зүүн Европын ба Балтийн улсууд	Хорват	-7.7	-5.5	-11.6	-7.1	-7	-2.3	-3.3	-3.5
	Чех	-2.6	-7.1	-6.7	-2.2	-2.7	-5.3	-4.6	-3.6
	Эстон	-4.4	-9.2	-12.1	-9.2	-4.7	-5.7	-6.2	-6.7
	Унгар	-5.6	-3.7	-2.1	-4.9	-4.3	-2.8	-2.1	-2.4
	Латви	-0.4	-5.5	-6.1	-10.7	-9.8	-6.9	-9.7	-8.5
	Литва	-10.2	-9.2	-10.2	-12.1	-11.2	-6	-4.8	-5.8
	Польш	4.5	-1	-3.2	-4.4	-7.5	-6.3	-3.9	-3.8
	Словак	2.1	-10.6	-9.6	-9.7	-5.5	-3.7	-8.8	-9.1
	Словени	-0.5	0.2	0.1	-0.8	-3.9	-3.4	-0.4	1.2
	Дундаж (ТЗЕБҮ)	-2.8	-5.7	-6.8	-6.8	-6.3	-4.7	-4.9	-4.7
Зүүн-Омнэд Европын улсууд	Албани	-7.2	-9.1	-12.1	-6.1	-7.2	-6.9	-6.3	-6
	Босни Герцогевин	-10.3	-27.3	-31	-17.1	-20.7	-21.4	-23.1	-20.3
	Болгар	-0.2	0.2	4.1	-0.5	-5.3	-5.6	-6.5	-5.9
	Югослав	-	-11.6	-7.7	-4.8	-7.5	-7.4	-10.7	-12.9
	Македон	-5	-6.5	-7.7	-10.1	-3.4	-3.1	-9.8	-10.2
Тусгай Тогтолцоон Улсуудын Хамгийн Нийхүүлэлт	Румын	-5	-7.3	-6.1	-7	-3.7	-3.7	-6.1	-5
	Дундаж (ЗӨӨҮ)	-5.5	-10.3	-10.1	-7.6	-8	-8	-10.4	-10
	Армени	-17	-18.2	-18	-21.3	-16.6	-14.6	-9.5	-8.9
	Азербайжан	-13.2	-25.8	-23.1	-30.7	-13.1	-3.2	-0.9	-22.4
	Беларусь	-4.4	-3.6	-6.1	-6.7	-1.6	-2.1	0.8	-0.4
Тусгай Тогтолцоон Улсуудын Хамгийн Нийхүүлэлт	Гүрж	-7.5	-9.1	-10.6	-9.4	-8.2	-5.5	-6.8	-6.2
	Казакстан	-1.3	-3.6	-3.6	-5.6	-1	2.2	-7.8	-5.5
	Киргиз	-13.9	-21.4	-7.8	-25	-19.5	-11.6	-3.4	-2.9
	Молдав	-6.8	-9.8	-12.6	-16.7	-2.9	-8.4	-9.1	-9.2
	Орос	2.2	2.8	0.5	0.3	12.7	17.9	11.3	8
	Тажикстан	-16	-7.1	-5.4	-9.1	-3.4	-6.4	-6.9	-4.1
	Туркменистан	0.9	0.1	-25.3	-37.4	-24.8	15.2	-2.5	0.8
	Украин	-3.1	-2.7	-2.7	-3.1	2.6	4.7	3.7	4
	Узбекистан	-0.2	-7.8	-5.4	-0.4	-2	2.8	-0.5	0.6
	Дундаж (ТТУХН)	-6.7	-8.8	-10	-13.7	-6.5	-0.8	-2.6	-3.9
	Монгол	5.2	-4	9.9	-7	-5.2	-5.8	-6.1	-12.1

төсвийн тэнцлийг тогтвожуулах нь хамгийн чухал болоод байна. Социализмын үеийн үрэлгэн зардлын бүтцээ өөрчилж, татварын дарамтыг аажмаар баагасах, нийгмийн салбарын биеэ даагаад явах хэсгийг хувьчлах арга замыг өргөн хэрэглэж байна. Гадаад өрийн хэмжээ ихтэй зарим шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд төсвийн болоод худалдааны үйл ажиллагаанд саад болж, гадаад худалдааны алдагдал ихээр байх төлөвтэй байна.

#### 2.4. Үнэ, цалин хөлс

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгасан макро эдийн засгийн тогтвортой байдал болон үнэ ханшийн тогтвожилтыг бататгах, санхүү банкны салбарын зуучлалыг гүнзгийрүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах зэрэг бодлогын үр дунд 2002 онд хэрэглээний үнээр илэрхийлэгдэх инфляцийн түвшин 1.6 хувь болж, өмнөх оныхоос 6.4 нэгжээр буурсан байна. Энэ нь сүүлийн 12 жилийн хувьд хамгийн бага үзүүлэлт юм. 2002 оны туршид инфляцийн сарын хэлбэлзэл өмнөх онтой харьцуулахад 4.5 дахин буурчээ.

Инфляци буурч, харьцангуй тогтвожиж байгаа нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн үнэд үзүүлэх нөлөө буурч, бодит эдийн засаг тогтвожиж эхэлж буйн илрэл гэж үзэж байна. Тайлант оны инфляцийн түвшинг суурь инфляци буюу улирлын хэлбэлзэл ихтэй мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсий ногооны дэд бүлгийг хэрэглээний барааны сагснаас хасан тооцсон

инфляцитай харьцуулахад 5.5 хувиар бага гарсан байна. Суурь инфляци өндөр байгаа нь мах, махан бүтээгдэхүүний үнийн улирлын хэлбэлзэлд өөрчлөлт гарч байгаатай холбоотой юм.

Тайлант хугацаанд хэрэглээний сагс дахь 239 зүйлийн бараа, үйлчилгээний 27 зүйлийн бараа, үйлчилгээний үнэ өсч, 3 зүйлийн үнэ буурч, 209 зүйлийн үнэ тогтмол байжээ. Оны эхнээс хэрэглээний сагсанд хамгийн их хувийн жин эзэлдэг хүнсний барааны бүлгийн үнэ 1.2 хувиар буурсан нь гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ 8.2 хувиар, архи, ундаа 6.7 хувиар, сахар, чихэр, цай, жимс 4.4 хувиар, мах, махан бүтээгдэхүүн 0.3 хувиар тус тус буурсантай холбоотой байна. Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, соёл, боловсролын бараа үйлчилгээ болон бусад бүлгүүдийн үнэ тариф 2.4-9.2 хувиар өссөн байна.

Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 195 тоот тогтоолын дагуу 2002 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх шийдвэрт төсөвт байгууллагын 125.8 мянган албан хаагч хамрагджээ. Төрийн албанд өндөр мэдлэгтэй залуу боловсон хүчин татах, тэднийг тогтворт суурьшилтай ажиллуулах үүднээс цалинг ажлын үр дүнгээс хамааруулан тогтоох алхмыг хийснээрээ энэ удаагийн цалин нэмэгдүүлэх арга хэмжээ илүү ач холбогдолтой болсон байна. Төрийн үйлчилгээ, төрийн тусгай алба, төрийн дээд байгууллагын албан хаагчдын цалин дунджаар 20 хувиар, төрийн захиргааны албан хаагч, шүүх, прокурорын ажилтнуудын цалин дунджаар 22 хувиар өсчээ. Энэ арга хэмжээнд улсын төсвөөс нийт 4.3 тэрбум төгрөгийг нэмж зарцуулсан байна. 2001 оны 4 дүгээр сараас хойш цалин гурав дахь удаагаа нэмж байгаа бөгөөд 2000 оны түвшинтэй харьцуулахад нийтдээ 31.0 хувиар өсчээ.

Засгийн газрын 2002 оны 263 дугаар тогтоолоор төр, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2001 онд 24750 төгрөг байсныг 30000 төгрөг болгон шинэчилснээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний түвшинг 2000 онтой харьцуулахад 2.5 дахин нэмэгдүүлсэн байна.

Мөн Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүднээс Нийгмийн халамжийн сангаас олгодог тэтгэврийг 20 хувиар, хүүхэд аасарсны тэтгэмжийг 15 хувиар нэмэгдүүлж, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг дунджаар 20 хувиар нэмэв. Тэтгэвэр нэмэгдүүлэх 2002 оны арга хэмжээнд нийт 263.8 мянган тэтгэвэр авагчдыг бүрэн хамруулжээ.

## 2.5. Ажиллах хүчиний зах зээл

Монгол Улсын нийт хүн ам 2002 оны эцсийн байдлаар 2475.4 мянга, үүний дотор хөдөлмөрийн насны хүн ам 1439.2 мянга, ажиллах хүч буюу эдийн засгийн идэвхтэй хүн ам 901.7 мянга, ажиллагчид 870.8 мянга байна.

Хөдөлмөрийн зах зээлийн хөгжил, хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг тодорхойлдог гол үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшин 2002 оны эцэст 62.7 хувьд хүрч өмнөх оныхоос 0.5 нэгжээр өссөн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2002 оны үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Боломжит хөдөлмөр"-ийн үзэл баримтлалтай нийцүүлэн боловсруулж "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг батлав. Хөтөлбөрийг 2002-2010 онуудад хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх ба 2010 онд бодит ажилгүйдлийн түвшинг 2002 оны түвшнээс 2 дахин бууруулахаар төлөвлөж байна.

Тайлант хугацааны эцэст аймаг нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанад бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 30.9 мянгад хүрч, өнгөрсөн оныхоос 23.5 хувь буюу 9.5 мянган хүнээр буурав. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн (улсын дунджаар) 54.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр нь авч үзвэл нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 25.1 хувь буюу 7.7 мянга нь 16-24 насны, 34.4 хувь буюу 10.6 мянга нь 25-34 насны, 30 хувь буюу 9.3 мянга нь 35-44 насны, 10.5 хувь буюу 3.2 мянга нь 45-59 насны хүмүүс байна. Ажилгүйчүүдийн 8.8 хувь нь дээд, 10.9 хувь нь тусгай дунд, 12.2 хувь нь мэргэжлийн анхан шатны, 62.4 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 5.0 хувь нь бага боловсролтой, 0.7 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

2002 онд аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн албанад 45.3 мянган ажилгүйчүүд шинээр бүртгүүлж, улсын хэмжээгээр 35.5 мянган хүн ажилд орсны 4.6 хувь нь улсын үйлдвэрийн газарт, 9.5 хувь нь төсвийн байгууллагад, 85.9 хувь нь компани, нөхөрлөл, хоршоо болон бусад газарт ажилд орж, мэргэжлийн сургалтанд 15.4 мянган хүн хамрагджээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Голомт, Хас, Интер банкууд, Мон-Арвис, Мөнх-Арилжаа ББСБ-уудад нийт 613.0 сая төгрөг байршуулж, 400 иргэн, 20 аж ахуйн нэгжид зээл олгосноор 2200 ажлын байр шинээр бий болсон байна.

Мөн АХБ-ны "Ажлын байр нэмэгдүүлэх" төслийн хүрээнд 144 аж ахуйн нэгж, 159 иргэнд 2.4 тэрбум төгрөгийн зээл олгосноор 4200 ажлын байр шинээр бий болов.

"Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай" хуулийг хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гадаадад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн дадлага хийх таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам "Тулуй" ХХК-д, "Бумтод" БНН-д БНЧУ-д, "Будын" ХХК-д БНУУ-д, "Заг", "Бридж", "Ти Си Ай", "Мөхөт" ХХК болон "Их хийморь Төв" Төрийн бус байгууллагад Япон улсад, "Заг" ХХК-д БНСУ-д хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгов. Тайлант онд хөдөлмөр эрхлэхээр нийт 300 гаруй хүн гадаадад гарчээ.

Мөн Монгол улсад 56 орны 6118 иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосноос 4617 хүнийг хөдөлмөр эрхлүүлэхээр гадаадаас урих урьдчилсан зөвшөөрлийг аж ахуйн нэгж байгууллагад олгож, 1975 хүний ажиллах хугацааг сунгасан байна.

### **3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ**

<b>3.1.</b>	<b>Мөнгөний нийлүүлэлт</b>	<b>52</b>
<b>3.2.</b>	<b>Мөнгөний зах зээл</b>	<b>56</b>
<b>3.3.</b>	<b>Хөрөнгийн зах зээл</b>	<b>57</b>

### 3. МӨНГӨ, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Мөнгө, санхүүгийн салбарын хувьд 2002 он иргэдийн банкинд итгэл дээшилсэн, банкны салбарын санхүүгийн зуучлал сайжирсан, бодит эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ ахиу оруулсан жил болж өнгөрөв. Хэрэглээний үнийн индексээр тооцсон инфляцийн түвшин оны турш тогтвортой байж, тайлант оны эцэст жилийн 1.6 хувь болсон нь сүүлийн 12 жилийн туршид хамгийн доод түвшиндээ хүрлээ. Мөнгөний бодлогыг оны турш чангатгах тохируулга хийсэн боловч дотоод эрэлт өндөр байсан нь нийт мөнгөний өсөлтийг өндөр буюу 42.0 хувьд хүргэхэд нөлөөлөв. Төгрөгийн америк доллартай харьцах нэрлэсэн ханш жилийн турш тогтвортой байсан, мөн малчид ирэх онд дахин байгалийн гамшиг тохиолдоно гэсэн хүлээлттэй байсны улмаас бэлтгэсэн махны нөөц өсөж махны үнэ өсөөгүй нь инфляци тогтвортой байхад нөлөөлөв.

#### 3.1. Мөнгөний нийлүүлэлт

2002 онд нийт мөнгө буюу M2 оны эхнээс 42.0 хувиар буюу 139.0 тэрбум төгрөгөөр өсч 470.1 тэрбум төгрөгт хүрчээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг түүний бүрэлдэхүүн тус бүрийн өсөлтөөр авч үзвэл оны эхнээс банкнаас гадуурхи мөнгө 8.3 хувиар, төгрөгийн харилцах 14.3 хувиар, хугацаат хадгаламж 42.9 хувиар, гадаад валютын хадгаламж 34.5 хувиар тус тус өсчээ.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн бүтэц өмнөх жилийнхээс эрс өөрчлөгдлөө. Өмнөх жилд M2-ийн өсөлтийн 35.1 хувийг банкнаас гадуурхи мөнгө, харилцах (M1)-ын өсөлт тодорхойлж байсан бол тайлант онд нийт өсөлтийн дөнгөж 22.7 хувь нь M1-ийн өсөлтөөр хангагджээ. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх хувийг төгрөгийн болон валютын хадгаламжийн өсөлт эзэлж байгаа нь иргэд байгууллагын банкинд итгэх итгэл дээшилж, санхүүгийн зуучлал гүнзгийрч байгааг харуулж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийг гадаад, дотоод цэвэр өөрчлөлтөөр авч үзвэл өсөлтийнх нь дийлэнх буюу 64.0 хувийг гадаад цэвэр актив (ГЦА), 36.0 хувийг дотоод цэвэр актив (ДЦА) хангаж байна. ГЦА болон ДЦА-ын өөрчлөлтийн хандлага харьцангуй тогтвортгүй байсан бөгөөд тайлант оны сүүлийн 2 сард ГЦА-ын өсөлт ДЦА-ын өсөлтөөс өндөр байсныг харж болно. Иймд дээрх үзүүлэлтийг 12 сарын туршид дундажлан үзвэл дээрхийн эсрэгээр нийт мөнгөний өсөлтийн 36.0 хувийг ГЦА, 64.0 хувийг ДЦА хангаж байна. Үүнээс үзэхэд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх нь дотоод зээлийг нэмэгдүүлж байв.

Санхүүгийн секторын либералчлал хийж буй бусад орнуудын адилаар дотоод цэвэр зээлийн өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөөс давж 54.7 хувьд хүрсэн нь дотоод цэвэр актив өмнөх оныхоос 50.7 тэрбум төгрөгөөр буюу 46.0 хувиар нэмэгдэхэд голлон нөлөөлөв. Засгийн газрын цэвэр зээл 25.6 тэрбум төгрөг

### Хүснэгт 8. Мөнгө санхүүгийн салбарын гол үзүүлэлтүүд

	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
М2/ДНБ	52.4	27.6	21.9	23.7	18.5	19.9	20.4	20.5	23.8	24.8	29.7	38.2
Зээл/ДНБ	68.0	40.4	16.2	16.3	11.4	10.0	6.1	10.5	8.4	6.4	12.1	18.8
Хадгаламж/ДНБ	13.8	11.4	12.4	13.5	10.8	9.9	11.3	10.4	11.4	12.3	15.7	23.0
Банкнаас гадуурхи мөнгө/M2	17.1	14.1	20.5	24.4	25.1	32.5	29.3	33.7	39.6	39.0	33.0	25.7
Зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)	12.9	19.1	31.6	52.8	62.7	64.8	50.4	85.6	77.5	66.8	135.1	231.4

буюу 4.8 дахин буурсан бол улсын болон хувийн секторт олгосон цэвэр зээл 90.7 тэрбум төгрөг буюу 72.4 хувиар нэмэгджээ.

Тайлант онд ГЦА-ын хэмжээ 40.1 хувь буюу 88.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь гадаад цэвэр албан нөөц 38.4 хувь буюу 77.6 тэрбум төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалав. Гадаад цэвэр албан нөөцийн өөрчлөлтөд Монголбанкны эзэмшиж буй гадаадын засгийн газрын үнэт цаасны хэмжээ 2.1 дахин буюу 23.8 тэрбум төгрөг, гадаадын банк дахь хугацаат хадгаламжийн хэмжээ 27.0 хувь буюу 41.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

#### *Бага мөнгө буюу M1*

2002 оны эцсээр бага мөнгө (M1) 31.6 тэрбум төгрөгөөр өсч, 187.7 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт мөнгөний 39.9 хувийг эзэлж байна. M1-ийн үндсэн хэсэг болох банкнаас гадуурхи мөнгөний өөрчлөлт улирлын шинж чанартай хэлбэлздэг.

Тайлант онд банкнаас гадуурхи мөнгө 11.6 тэрбум төгрөг буюу 10.6 хувиар, харилцах 19.9 тэрбум төгрөг буюу 42.3 хувиар тус тус өсчээ. Ард иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдсэн болон төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэрүүдийг нэвтрүүлэх болсон нь M1-д банкнаас гадуурхи мөнгөний эзлэх хувийн жин 5.6 нэгжээр буурахад нөлөөлсөн байна.

Ийнхүү санхүүгийн зах хөгжиж, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслийд нэвтэрч эхэлснээр бэлэн мөнгөний эрэлт багасах зүй тогтлын дагуу мөнгөний урсгал банкны сектор руу чиглэж эхэлсэн нь мөнгөний зах дээр гарсан шинэ эерэг хандлага байлаа. 2002 онд төлбөрийн картын үйлчилгээг хөдөө орон нутагт нэвтрүүлж эхэлсэн бөгөөд оны эцэс гэхэд Худалдаа хөгжлийн банкны Виза (VISA), Голомт банкны Master (Master), Виза (VISA), Анод банкны Цахим төгрөг карт эзэмшигчдийн тоо нийлбэр дүнгээрээ 23.5 мянгад хүрсэн байна.

#### *Бараг мөнгө*

Тайлант онд бараг мөнгө (банкны системийн хугацаат хадгаламж болон валютын хадгаламжийн нийлбэр) 61.5 хувиар өсч, 282.4 тэрбум төгрөгт хүрэв.

**Хүснэгт 9. Нөөц мөнгө, М2, ХБҮИ, ханшны өөрчлөлт**

	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Нөөц мөнгө	157.1	168.6	104.1	28.7	36.5	23.1	18.7	49.9	18.6	8.2	21.9
Нийт мөнгө (M2)	31.6	227.6	79.5	32.9	25.8	32.5	-1.7	31.6	17.6	27.9	42.0
ХБҮИ	325.5	183.0	66.3	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	1.6
Ханш	0.0	891.3	4.4	14.4	46.4	17.3	10.9	18.9	2.3	0.5	2.1

Энэ нь нийт мөнгөний 60.1 хувийг эзэлж байна. Өмнөх жилүүдэд бараг мөнгөний өсөлтийн дийлэнх хэсгийг гадаад валютын хадгаламжийн өсөлт эзэлдэг байсан бол 2002 онд төгрөгийн хугацаатай хадгаламжийн өсөлт давамгайлж, нийт өсөлтийн 55.4 хувийг эзэлжээ. Хугацаатай хадгаламж оны эхнээс 68.0 хувиар өсч, 147.2 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант оны туршид төгрөгийн ханш тогтвортой, инфляци бага байсан бөгөөд цаашид эдгээр үзүүлэлтүүд нь харьцангуй тогтвортой байж хүлээлттэй байсан нь иргэдийг хадгаламжаа үндэсний мөнгөн тэмдэгтээр байршуулах хөшүүргийг бий болгосон байна.


***Нөөц мөнгө***

Тайлант онд нөөц мөнгө 21.9 хувиар өсч 175.3 тэрбум төгрөгт хүрэв. Нөөц мөнгөний өөрчлөлтийг бүтцээр нь авч үзвэл банкнаас гадуурхи мөнгө оны эхнээс 10.6 хувиар, банкуудын нөөц 57.8 хувиар тус тус өссөн байна. Нөөц мөнгөний өөрчлөлтийг сүүлийн 2 жилийн байдлаар авч үзэхэд оны эхний хагасд харьцангуй өсөх, 3 дугаар улиралд тогтворжих, 4 дүгээр улиралд буурах хандлага ажиглагдаж байна. Энэ нь нийт эдийн засгийн улирлын идэвхжилтээр, ялангуяа дотоодын алт олборлолтын хэмжээгээр тодорхойлогдож байна. Монголбанк аж ахуйн нэгжүүдээс алт худалдан авахад төлж буй үнийн дүнгээр нөөц мөнгөний өсөлтийг шууд бий болгодог.


Тайлант оны эхний саруудад нөөц мөнгө харьцангуй тогтвортой байснаа 3 дугаар сарын сүүлээс 9 дүгээр сарын эцэс хүртэлх хугацаанд тогтмол өсч харин оны эцэст буурч, тогтворжих хандлагатай болжээ. Алт олборлолтын оргил үе 2, 3 дугаар улирал байдаг бөгөөд 9 дүгээр сард нөөц мөнгө хамгийн их хэмжээндээ буюу 189.8 тэрбум төгрөгт хүрэв. Өмнөх жилүүдийн хувьд Засгийн газар улирлын чанартай төсвийн орлого, зарлагын зөрүү болон тэтгэвэр, тэтгэмж тавьж олгоход зориулж Монголбанкнаас зээл авснаар нөөц мөнгөний өсөлтийг бий болгодог байсан бол 2002 онд энэ зориулалтаар зээл олгогдоогүй байна.

Тайлант оны туршид, Монголбанк мөнгөний бодлогын шууд бус арга хэрэгслүүдийг ашиглан нөөц мөнгөний огцом өсөлтийг хязгаарлах, тогтвортжуулах чиглэлд анхаарал тавьж ажиллалаа. Үүний үр дүнд Олон улсын валютын сан (ОУВС)-тай хамтран хэрэгжүүлж буй Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах (ЯБӨХ) хөтөлбөрийн хүрээнд тавигдсан 2002 оны жилийн эцсийн нөөц мөнгөний зорилтолт хэмжээг биелүүлж ажилласан юм.


Зураг 22. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн бүтэц



Зураг 23. Мөнгөний нийлүүлэлт, дотоод болон гадаад цэвэр активуудын жилийн өөрчлөлт



Зураг 24. Нөөц мөнгөний динамик 2002 онд



### 3.2. Мөнгөний зах зээл

Төв банк, Засгийн газар болон банкууд мөнгөний зах зээлийн үйл ажиллагаанд голчлон оролцдог бөгөөд бусад зах зээлтэй харьцуулбал үйл ажиллагаа нь илүү нээлттэй, ил тод зохицуулагдаж байдаг.

Монголбанкнаас 2002 онд 4 төрлийн (7, 14, 28, 91 хоногийн) үнэт цаас гаргаж хямдруулалтын хэлбэрээр арилжаалсан байна. Нийт 98 удаагийн арилжаагаар 1.0 сая ширхэг ТБҮЦ-ыг нэг бүрийг нь нэг сая төгрөгийн нэрлэсэн үнэтэйгээр гаргаж, 0.8 сая ширхэг үнэт цаас борлуулсан нь өмнөх турван жилийн дундаж дүнгээс гаргасан хэмжээ нь 0.4 сая ширхэгээр буюу 1.7 дахин, борлогдсон хэмжээ нь 0.3 сая ширхэгээр буюу 1.6 дахин илүү байлаа.

2002 оны туршид банкууд өдөрт дунджаар өөрсдийн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 13.8 хувийг ТБҮЦ-д байршуулж байжээ.

Тайлант онд ТБҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 94 удаа 86.2 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагджээ. Энэ нь 2001 оныхтой харьцуулахад 35.2 тэрбум төгрөгөөр буюу 1.7 дахин, 2000 оныхоос 53.0 тэрбум төгрөгөөр буюу 2.6 дахин илүү байна.

Монголбанк нь банк хоорондын мөнгөний захыг хөгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 552 тоот тушаалын дагуу "Банк хоорондын мөнгөний зах"-ын мэдээг сар бүр нэгтгэн авч байна.

2002 онд банк хоорондын зах дээр нийт 23.2 тэрбум төгрөгийн арилжаа, үүний 1.0 тэрбум нь банк хоорондын зээлээр, 13.8 тэрбум нь репо хэлцлээр, 8.1 тэрбум нь ТБҮЦ-аар, 0.3 тэрбум нь овернайт зээлээр хийгдсэн байна.

Засгийн газрын үнэт цаас, өрийн бичиг нь төсвийн алдагдал болон өрийг санхүүжүүлэхээс гадна мөнгөний зах зээлийн нэг хэрэгсэл болдог. Засгийн газраас 2002 онд богино хугацааны хямдруулсан, богино хугацааны энгийн, дунд хугацааны тусгай зориулалтын, дунд хугацааны хямдруулсан гэсэн 4 төрлийн нийт 50.1 тэрбум төгрөгийн бондын арилжаа явууллаа. Тайлант онд засгийн газрын үнэт цаасны арилжааны нэг онцлог нь хямдруулсан болон тусгай зориулалтын (замын) гэсэн 2 төрлийн дунд хугацааны бонд шинээр гаргасан явдал байв.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2002 онд Засгийн газрын арилжаалсан бондын хэмжээ 10.4 тэрбум төгрөг буюу 26.2 хувиар, оны эцсийн үлдэгдэл нь 3.7 тэрбум төгрөг буюу 1.5 дахин нэмэгджээ.

2002 онд арилжаалсан нийт бондын 78.0 хувь буюу 39.1 тэрбум төгрөгийг богино хугацааны хямдруулсан бонд, 12.0 хувь буюу 6.0 тэрбум төгрөгийг богино

хугацааны энгийн бонд, 5.0 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг дунд хугацааны тусгай зориулалтын (замын) бонд, 5.0 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг дунд хугацааны хямдруулсан бонд эзэлж байна. Харин жилийн эцсийн үлдэгдэл бондын 40.9 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг дунд хугацааны тусгай зориулалтын (замын) бонд, 40.9 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг дунд хугацааны хямдруулсан бонд, 18.0 хувь буюу 1.1 тэрбум төгрөгийг богино хугацааны хямдруулсан бонд тус тус эзэлж байна.

Нийт арилжаалсан бондын 48.3 тэрбум төгрөг буюу 96.4 хувийг арилжааны банкууд худалдан авсны дотор Худалдаа хөгжил, ХААН, Хадгаламж болон бусад банкууд тогтмол оролцож ихэнх хэсгийг нь авчээ.

Засгийн газрын 1-3 сар, 4-6 сар, 1 жилийн хугацаатай бондын хүү (хямдруулалтын хувь хэмжээ) оны эхний 3 улиралд өсөх буюу тогтвортой байснаа оны эцэст буурсан, харин 1.5-2 жилийн хугацаатай бондын хүү оны эцэст өссөн байдал ажиглагдаж байна. Энэ нь Засгийн газраас гаргаж буй одоогийн бонд ихэвчлэн (93.7 хувь нь 1 жил хүртэл хугацаатай) тухайн жилийн төсвийн орлого зарлагын түр хугацааны зөрүүг нөхөхөд зориулагдан, оны эцэст төлөгдөж дуусдаг онцлогтой холбоотой юм. Түүнчлэн засгийн газрын үнэт цаасны төлөгдөх хугацаа уртсах тусам хүүний хувь хэмжээ өндөрсөх хандлагатай байна.

2002 онд нийт арилжигдсан засгийн газрын богино хугацааны хямдруулсан бондын жигнэсэн дундаж хүү 11.6 хувь байсан нь ТБҮЦ-ныхаас 2.1 нэгжээр, оны эцсийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү 9.34 хувьтай байгаа нь ТБҮЦ-ныхаас 1.3 нэгжээр тус тус дээгүүр байлаа.

### **3.3. Хөрөнгийн зах зээл**

Санхүүгийн зуучлалын хоёр дахь сонгодог хэлбэр болсон үнэт цаасны захын хөгжил сул хэвээр байгаагаас дотоодын зах зээлд банкууд дангаар иөрхөх, хүүний түвшин өндөр хэвээр байх, зээлийн хомсдол ажиглагдах зэрэг сөрөг үр дагавар гарсаар байна. УИХ-аас "Үнэт цаасны зах зээл"-ийн тухай хууль батлагдсан, "Шинэ зуун" болон "Нийслэл өргөө" бондууд арилжаалагдсан зэрэг

**Хүснэгт 10. Засгийн газрын бондын арилжаа, үлдэгдэл**

Засгийн газрын бондын ангилал	тэрбум төгрөг			
	2001	2002	арилжаа	үлдэгдэл
Богино хугацааны хямдруулсан бонд	39.7	2.4	39.1	1.1
Богино хугацааны энгийн бонд			6	
Хадгаламж			2	
Монголбанк			4	
Дунд хугацааны тусгай зориулалтын /замын/ бонд			2.5	2.5
Дунд хугацааны хямдруулсан бонд			2.5	2.5
Дүн	39.7	2.4	50.1	6.1

нааштай эхлэлүүд гарчээ. 2003 онд Монголбанкнаас орон сууц барьцаалан олгох үл хөдлөх хөрөнгийн зээл (ипотекийн зээл)-ийн хууль эрхийн орчныг бий болгох, энэ хэлбэрийн зээлийн бүтээгдэхүүнээр үйлчлэх арилжааны банкуудын ажлыг уялдуулан зохицуулах чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.

#### *Монголын хөрөнгийн бирж*

2002 онд Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр үнэт цаасны 255 удаагийн арилжаагаар нийт 9.8 сая ширхэг хувьцаа, 465.0 мянган ширхэг засгийн газрын бонд, 317.5 мянган ширхэг компанийн бонд арилжаалагдаж, нийт 46.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Нийт гүйлгээний үнийн дүнгийн 90.6 хувь буюу 41.7 тэрбум төгрөгийг засгийн газрын бондын арилжаа, 6.4 хувь буюу 3.0 тэрбум төгрөгийг компанийн бондын арилжаа, 3.0 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийг хувьцааны арилжаа эзэлж байна. Дээрх үзүүлэлтүүдийг 2001 оны мөн үетэй харьцуулахад хувьцааны гүйлгээний хэмжээ үнийн дүнгээр 348.7 сая төгрөг буюу 20.2 хувиар, арилжигдсан хувьцааны тоо 6.0 сая ширхэг буюу 38.0 хувиар буурчээ.


Тайлант хугацааны эцсийн байдлаар 403 (61 нь төрийн өмчийн оролцоотой, 342 нь бүрэн хувьчлагдсан) ХК-ийн 657.2 сая ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 475.1 сая ширхэг буюу 72.3 хувь нь төрийн мэдэлд, 182.1 сая ширхэг буюу 27.7 хувь нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эзэмшилд байна.

2001 онд нийт бүртгэлтэй хувьцааны тоо 274.2 сая ширхэг байсан бол 2002 онд 657.2 сая болж 2.4 дахин өссөн байна. Нийт хувьцааны 60.2 хувь (2002 онд шинээр бүртгэгдсэн хувьцааны 99.0 хувь)-ийг нь шинээр ХК-ийн хэлбэрт шилжиж, хувьцаагаа бүртгүүлсэн эрчим хүчний салбарын компанийдын хувьцаа эзэлж байна. Бүртгэгдсэн хувьцааны тоогоор арилжааны хэмжээ нэмэгдэж хөрөнгө оруулалтын хэмжээ өсдөг зүй тогтолтой байтал өнөөгийн манай биржид бүртгэж байгаа компаниуд өмч хувьчлалын бэлтгэл ажил гэсэн нэрээр ёс төдий бүртгэгдэн, бүртгэлтэй хувьцааны тоог хиймлээр нэмэгдүүлж байна.


Сүүлийн 2 жилийн байдлаар авч үзвэл нийт арилжааны үнийн дүн 2001 онд 2000 оныхоос 19.6 тэрбум төгрөгөөр, 2002 онд өнгөрсөн оныхоос 12.3 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Тайлант онд нийт арилжааны 166.7 сая төгрөгийг төрийн өмчийн хувьцаа, 532.0 сая төгрөгийг багцаар хэлцэл хийгдсэн АПУ, Багануур, Баянгол, Монголын цахилгаан холбоо, Талх чихэр ХК-уудын хувьцаа, 674.8 сая төгрөгийг чөлөөтэй арилжигдсан хувьцаа тус тус эзэлж байна. Чөлөөтэй арилжигдсан хувьцааны үнийн дүн нийт арилжааны 49 хувь, нийт гүйлгээний 1.4 хувь болж байна.

2001 онд шинэчлэгдэн батлагдсан "МХБ-д үнэт цаас бүртгэн авах журам"-ын дагуу тайлант онд шинээр 153 ХК-уудыг ангилалд хамрууллаа. 2002 оны эцсийн

Зураг 25. Топ-75 индекс



Зураг 26. Нийт хувьцааны зах зээлийн үнэлгээ



### Хүснэгт 11. Компанийн бондын арилжааны мэдээ

Бондын төрөл	Арилжигдсан		сая төгрөг Эзлэх хувь
	тоо ширхэг	үнийн дүн	
Шинэ зуун	174549.0	1746.0	59.0
Их барилга	99493.0	994.9	33.6
Нийслэл өргөө	43425.0	217.1	7.3
Нийт	317467.0	2958.0	100.0

байдлаар МХБ-д бүртгэлтэй нийт 403 ХК байгаагаас 37 ХК дээд, 366 ХК доод (тайлангаа ирүүлээгүй ХК-иудыг доод ангилалд оруулсан болно) ангилалд хамаарагдсан байна.

Тайлант оны эцсийн байдлаар TOP-75 индекс 933.93 нэгжид хүрч, өнгөрсөн оныхоос 119.9 нэгжээр өссөн байна. TOP-75 индексийн хамгийн өндөр үзүүлэлт 2002 оны 10 сарын 10-ны өдөр 1450.4 нэгжид хүрчээ. Одоогийн байдлаар TOP-75 индекс тооцох сагсыг МХБ-ийн үнийн индекс тооцох журам, индекс тооцох программд өөрчлөлт оруулан зах зээлийн үнэлгээ өндөр 20 компаниар тооцож байна.

Тайлант онд засгийн газрын бондын арилжаа 19 удаа явагдсанаас 5 удаагийн арилжаагаар 27.0 мяняган ширхэг бондыг нэг бүрийг нь 10000 төгрөгийн нэрлэсэн үнэтэйгээр иргэдэд зориулан арилжив. 2002 онд арилжигдсан засгийн газрын бондын гүйлгээний үнийн дүн арилжих үнийн дүнгээс 112.5 сая төгрөгөөр өссөн нь засгийн газрын бондын хүүний зардлыг бууруулсан байна. Засгийн газрын бондын хэмжээ 2001 оныхтой харьцуулахад өссөн боловч үнийн дүнгийн өсөлт 41.3 сая төгрөгөөр буурчээ. Энэ нь бондын нийлүүлэлтийг их хэмжээгээр хийж байснаас арилжаанд оролцогчдыг хоорондоо тохиролцон хэлцэл хийх нөхцөлийг бүрдүүлсэнээс шалтгаалжээ.

Цаашид Засгийн газраас хөрөнгийн биржийг хөгжүүлэх талаар дорвитой цогц арга хэмжээ авснаар санхүүгийн зах зээл үнэн утгаараа ажиллах нөхцөл бүрдэх юм.

УИХ, Засгийн газрын тогтоол, Монгол улсын санхүү, эдийн засгийн сайдын тушаалын дагуу засгийн газрын хямдруулсан бондыг бүртгэж, "Барилга корпораци" ХК-ийн нэмж гаргасан "Шинэ зуун", "Нийслэл өргөө" ХК-иас

### Хүснэгт 12. Бондын төлбөр тооцоо

Бондын нэр	Ширхэг	Бондын орлогод	сая төгрөг	
			Бондын болон хүүгийн төлбөрт	
Засгийн газрын бонд	465010	41.6		41.6
Шинэ зуун	174597	1.7		1.2
Их барилга	99493	99.1		
Нийслэл өргөө	43425	216.3		

### Шигтгээ 6. Шилжилтийн эдийн засагтай орнуудын гадаадын шууд хөрөнгө оруулалт

Шилжилтийн эдийн засагтай орнууд дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 2002 онд 31 тэрбум ам.доллар хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ нь тус бүс нутгийн ихэнх орнуудад макро эдийн засгийн тогтвортой байдал бий болсон, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа сайжирсан, бүтцийн өөрчлөлт, шинэчлэлтийг эрчимжүүлэн, бизнес ба хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлсний үр нөлөө юм.

		/сая ам.доллар/							
Төв ба зүн Европын ба Балтийн улсууд	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002	
	Хорват	109	486	347	835	1,445	1,086	1,325	970
	Чех	2,526	1,276	1,275	3,591	6,234	4,943	4,820	8,000
	Эстон	199	111	130	574	222	324	343	300
	Унгар	4,410	2,279	1,741	1,555	1,720	1,090	2,103	2,559
	Латви	245	379	515	303	331	400	170	250
	Литва	72	152	328	921	478	375	439	395
	Польш	1,134	2,741	3,041	4,966	6,348	8,171	6,502	5,000
	Словак	194	199	84	374	701	2,058	1,460	4,000
	Словени	183	188	340	250	144	110	338	553
Зүн-Зүн Европын улсууд	Дундаж (ТЗЕБҮ)	9,072	7,811	7,801	13,369	17,623	18,557	17,500	22,027
	Албани	89	97	42	45	51	141	204	153
	Босни Герцогевин	98	138	507	537	789	1,003	641	800
	Болгар				100	90	150	130	200
	Югослав			740	113	112	25	165	300
	Македон	12	12	18	175	27	175	445	70
	Румын	417	415	1,267	2,079	1,025	1,051	1,154	1,200
	Дундаж (ЗӨЕҮ)	616	662	2,574	3,049	2,094	2,545	2,739	2,723
	Армени	25	18	52	221	122	104	70	75
	Азербайжан	330	627	1,115	1,023	510	119	227	1,300
Тусгаар Тогтолцоон Хамтын Нэхэрлийн	Беларусь	15	105	350	201	443	90	84	146
	Гүрж	6	54	236	221	60	152	100	80
	Казакстан	964	1,137	1,320	1,143	1,584	1,245	2,760	2,500
	Киргиз	96	47	83	86	38	-6	22	25
	Молдав	73	23	71	88	34	128	60	100
	Орос	1,460	1,657	1,679	1,496	1,103	-496	-137	1,000
	Тажикстан	10	18	18	25	21	24	9	20
	Туркменистан	233	108	108	62	125	126	133	150
	Украин	257	516	581	747	489	594	769	750
	Узбекистан	-24	90	167	140	121	73	71	75
	Дундаж (ТТУХН)	3,445	4,400	5,780	5,453	4,650	2,153	4,168	6,221
Нийт	13,132	12,872	16,153	21,871	24,367	23,254	24,407	30,971	
Монгол	9.8	15.9	25	18.9	30.4	53.7	43	77.8	

улсуудын байгалийн баялаг гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцөл болсон бол Польш, Румын, ОХУ улсуудын том, өргөн зах зээл гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэх таатай нөхцөл болж чадсан байна. Мөн Европын Холбоонд элсэх гэж зэхжэй байсан орнуудад гадаадын шууд хөрөнгө оруулалт их хэмжээгээр орж байжээ.

гаргасан "Нийслэл өргөө", Алтан хот корпораци ХХК-ийн гаргасан "Их барилга" бондыг бүртгэлийн шалгалт хийсний дагуу бүртгэн авлаа.

2002 онд компанийн бондын арилжаа нэлээд эрчимжиж, арилжааны үнийн дүн өмнөх жилээс 1.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Компанийн бондын арилжаагаар давхардсан тоогоор нийт 317.5 мянган ширхэг бонд арилжигдаж 3.0 тэрбум орчим төгрөгийн гүйлгээ хийгджээ. Мөн 250 ширхэг "Шинэ зуун" бонд хоёрдогч зах зээлд арилжигдсан байна.

#### Өмч хувьчлал

Засгийн газрын 2002 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу тайлант онд нийт 14 аж ахуйн нэгжийг хувьчилж, 11 үл хөдлөх хөрөнгийг худалдан, улсын төсөвт 15.9 тэрбум төгрөгийг оруулсан бөгөөд энэ нь 2001 онтой (5.2 тэрбум) харьцуулахад 3 дахин их байна.

Шилжилтийн эдийн засагтай орнууд дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын дийлэнх хувь нь өмч хувьчлалын үйл ажиллагааны үр дүнд орж ирсэн байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь өр үүсгэдэггүй урсгал учраас урсгал тэнцлийн алдагдлыг нөхөх ашигтай хувилбар юм.

Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ /2002 онд 77.8 сая ам.доллар/ бусад шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад бага байгаа нь тухайн эдийн засгийн хэмжээ, шингээх чадвартай холбоотой.

Азербайжан, Казахстан,

ОХУ, Туркменистан

### Шигтгээ 6. Шилжилтийн эдийн засагтай орнуудын гадаадын шууд хөрөнгө оруулалт /үргэлжлэл/

Нэг хүнд ногдох гадаадын шууд хөрөнгө оруулалтын үзүүлэлт нь шилжилтийн эдийн засагтай орнуудын хөрөнгө оруулалт татах чадавхийг илүү бодитойгоор харьцуулах үзүүлэлт юм. Нэг хүнд ногдох гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр

Чех, Словак улсууд бусад

орнуудтай харьцуулахад маш өндөр байна. Зүүн

өмнөд Европын улсуудын

хувьд Македониас бусад

эдийн засгууд сайжрах төлөвлөхийн байгаад учир

үүнийг дагаад гадаадын

шууд хөрөнгө оруулалт өсөх

хандлагатай байна. Тусгаар

тогтносон хамтын

нэхөрлөлийн орнуудын

хувьд эрчим хүчиний нөөцийг

даган хөрөнгө оруулалт

хийгдэх хандлага илт

ажиглагдаж байна.

Монгол улс гадаадын шууд

хөрөнгө оруулалтын нийт

хэмжээгээрээ бусад

шилжилтийн эдийн засагтай

улсуудтай харьцуулахад

бага боловч нэг хүнд ногдох

хөрөнгө оруулалтын

хэмжээгээрээ хуучин ЗХУ-

ын бүрэлдэхүүнд байсан

зарим улсуудаас өндөр

байна. Нэг хүнд ногдох

Нэг хүнд ногдох гадаадын шууд хөрөнгө оруулалт /ам.доллар/

	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
Төв ба зүүн Европын ба Балтийийн улсууд	Хорват	23.2	108.0	75.4	185.6	314.1	248.0	297.0
	Чех	245.2	123.9	123.8	348.6	605.2	479.0	468.0
	Эстон	142.1	79.3	92.9	410.0	158.6	237.0	252.0
	Унгар	432.4	223.4	170.7	154.0	172.0	109.0	207.0
	Латвия	98.0	151.6	206.0	126.3	137.9	169.0	72.0
	Литва	20.0	42.2	91.1	263.1	136.6	108.0	126.0
	Польш	29.4	71.0	78.6	128.3	164.0	211.0	168.0
	Словак	35.9	36.9	15.6	69.3	129.8	381.0	270.0
	Словени	91.5	94.0	170.0	125.0	72.0	55.0	171.0
	Дундаж (ТЗЕБҮ)	115.3	99.5	99.1	170.7	225.1	222.0	226.0
Зүүн-Өмнөд Европын улсууд	Албани	27.8	29.4	12.4	13.2	15.0	41.0	66.0
	Босни Герцеговин	11.7	16.6	61.1	65.5	96.2	123.0	79.0
	Болгар	-	-	-	23.8	20.9	35.0	30.0
	Югослав	-	-	69.8	10.7	13.3	3.0	19.0
	Македон	6.0	6.0	9.0	87.5	13.5	88.0	223.0
	Румын	18.4	18.4	56.1	92.4	45.6	47.0	52.0
	Дундаж (ЗӨЕҮ)	12.1	13.0	50.4	59.9	42.9	56.0	78.0
	Армени	8.1	5.6	16.8	71.3	39.4	33.0	22.0
	Азербайжан	42.9	80.4	141.1	127.9	63.8	15.0	28.0
	Беларусь	1.5	10.2	34.3	19.7	44.3	9.0	8.0
Тусгаар Тогтолцоон Улсуудын Хамтын Нэхөрлийн	Гүрж	1.1	10.0	43.7	40.9	11.1	28.0	19.0
	Казакстан	60.3	72.4	85.2	75.2	106.3	84.0	186.0
	Киргиз	21.3	10.2	18.0	18.3	8.1	-1.0	5.0
	Молдав	17.0	5.3	16.5	20.5	7.9	35.0	17.0
	Орос	9.8	11.2	11.4	10.2	7.6	-3.0	-1.0
	Тажикстан	1.7	3.1	3.0	4.1	3.4	4.0	1.0
	Туркменистан	50.7	23.0	22.0	12.4	24.0	23.0	24.0
	Украин	5.0	10.1	11.4	14.8	9.8	12.0	16.0
	Узбекистан	-1.1	3.9	7.1	5.8	4.9	3.0	3.0
	Дундаж (ТТУХН)	12.1	15.5	20.4	19.3	16.5	20.0	27.0
Монгол	Нийт	139.5	128.0	169.9	249.9	284.5	298.0	331.0
	Монгол	4.4	6.8	10.6	7.9	12.9	22.5	17.0
								360.4
								23.1

хөрөнгө оруулалтын хэмжээгээр Монгол улсын үзүүлэлт ТТХН-ын дундажтай ойролцоо, Зүүн өмнөд Европын орнуудын дунджаас хоёр дахин бага, Төв Европ болон Балтийийн орнуудын дунджаас даруй арав гаруй дахин бага байна.

Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт бусад шилжилтийн эдийн засагтай орнуудтай харьцуулахад бага байгаа нь газар зүйн байршил, зах зээлийн хэмжээ бага зэргээс шалтгаалж байна. Харин орж ирсэн хөрөнгө оруулалтын дийлэнх нь байгалийн баялагт (уул уурхай, олборлолт); Монгол улсын АНУ-ын зах зээлд нэвтрэхэд үзүүлж буй хөнгөлөлтийг ашигласан хөнгөн үйлдвэр; ховор түүхий эд болох ноолуурын салбар; үйлчилгээг шууд зах зээл дээр нь нийлүүлэхээс өөр аргагүй үйлчилгээний салбаруудад чиглэсэн байна. Хамгийн гол нь улс төрийн болон макро эдийн засгийн тогтвортой байдал гадаадын хөрөнгө оруулалтыг татахад маш чухал үүрэгтэй байдаг.

"Худалдаа хөгжлийн банк" ХХК, "НИК" ХК-ийн лаборатори, "Сэргэлт авто зам" ХК, "Гал" ХК болон "Хөргүүлтэй агуулахын цогцолбор"-ын дуусаагүй барилга, "Цайз" ХК, "Үндэсний үнэт цаас" ХХК, "Монгол Шуудан банк" ХХК, Төрийн өмчийн хорооны спортын заал, "Хөвсгөл авто зам" ХХК зэргийг хувьчиллаа. Мөн "Бэрх-Уул" ХК-ийн төрийн мэдлийн 67 хувийг менежментийн гэрээгээр хувьчилсан бөгөөд гэрээг нэг жилийн дараа дүгнэхээр шийдвэрлэжээ.

"Говь" ХК, "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монгол даатгал" компани, "НИК" ХК зэрэг үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн хувьчлалын бэлтгэл ажлыг хангаж байна. 2002 онд "ХААН" банкийг хувьчлах тендерийн үйл ажиллагааны

бэлтгэл хангагдаж 2003 оны 1 дүгээр сард амжилттай явагдаж дууслаа. Мөн "МИАТ" ХК-ийн удирдлагын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх тендерийг Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран зохион байгуулж байна.

"Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл"-ийг **БСШУЯ, ЭМЯ, НХХЯ**-тай хамтран боловсруулж, УИХ-ын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлав. Тус салбарт өөрчлөлт, шинэчлэл хийх болон хувьчлах байгууллагын жагсаалтыг гарган УИХ-ын Нийгмийн бодлогын болон Эдийн засгийн бодлогын байнгын хороодтой зөвшилцөн, Засгийн газраар батлуулахаар болов. Энэ ажлын хүрээнд 2003 онд нийгмийн салбарын 14 байгууллагыг хувьчлах, 25 байгууллагад өөрчлөлт шинэчлэлт хийх журам, гэрээний төслүүдийг боловсруулж байна.

2000 онд хийгдсэн эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтийн дагуу зохион байгуулагдсан төрийн өмчит 18 ХК-ийн үйл ажиллагааг "Компанийн тухай хууль"-д нийцүүлэн арилжааны хэлбэрт шилжүүлэх үйл явцад нэлээд анхаарч ажиллалаа.



#### **4. БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ**

<b>4.1.</b>	<b>Банкны салбар</b>	<b>70</b>
<b>4.2.</b>	<b>Банк бус санхүүгийн байгууллагууд</b>	<b>74</b>

## 4. БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ

Улсын хэмжээнд 2002 онд 16 банк, 66 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, бүх аймгийн нутаг дэвсгэрт нийт 595 салбар нэгж (96 салбар, 481 тооцооны төв, 18 хадгаламжийн касс)-ээр дамжуулан харилцагчдад банкны үйлчилгээ үзүүлж байна. Аймаг сумдад 13 банкны харьяа 470 салбар нэгжээр үйлчилгээ үзүүлж байгаа нь өмнөх оныхоос 30-аар нэмэгдэн нийт салбар нэгжийн 79.0 хувийг эзэлж байна.

Банкуудын санхүү төлбөрийн чадвар сайжирч байгаагаас иргэд байгууллагын банкинд итгэх итгэл дээшилж, салбарын нийт актив 48.2 хувиар, харилцах 50.0 хувиар, хадгаламж 62.2 хувиар, өөрийн хөрөнгө 29.9 хувиар тус тус өсч, чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь буурсан зэрэг нааштай өөрчлөлтүүд гарлаа.

Тайлант онд бүх банкуудын активын дүн нэмэгдсэн бөгөөд санхүүгийн салбарын зуучлалыг тодорхойлогч гол үзүүлэлт болох мөнгөний нийлүүлэлт буюу М2, ДНБ-ий харьцаа 1990 оноос хойш хүрч байгаагүй түвшинд буюу 38.2 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 8.5 нэгжээр, 2000 оныхоос 12.8 нэгжээр тус тус их байна.


Өмнөх оны байдлаар Монголбанкнаас зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа 16 банкнаас төрийн өмчит 2, төрийн өмчийн оролцоотой 4, хувийн 10 (үүнээс гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай банк 1) банк байсан бол тайлант онд төрийн өмчит 2, төрийн өмчийн оролцоотой 2, хувийн 12 банк үйл ажиллагаагаа явуулж, үүнээс ХААН банкны хувьчлалын үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байна. 2001 оны байдлаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудад банкны салбарын нийт хадгаламжийн үлдэгдлийн 58.6 хувь, харилцах дансны үлдэгдлийн 77.9 хувь нь төвлөрч байсан бол тайлант онд хадгаламжийн 30.3 хувь, харилцах дансны үлдэгдлийн 22.0 хувь нь байрших болжээ. Энэ нь Худалдаа хөгжлийн банкны хувьчлал, хувийн өмчит банкууд идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсон зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд орон нутагт харьцангуй олон салбар нэгжтэй банкуудын үйл ажиллагааг дэмжих бодлого хэрэгжүүлж байсны үр дүнд хөдөө орон нутаг дахь


**Хүснэгт 13. Банк санхүүгийн системийн үзүүлэлтүүд**

	1996	1997	1998	1999	2000	2001	2002
М2/ДНБ	19.9	20.4	20.5	25.2	26.4	29.7	38.2
Зээл/ДНБ	10.2	6.1	11.6	9.4	6.8	12.1	18.8
Өөрийн хөрөнгө/ДНБ	-2.1	2.0	0.9	2.2	3.1	4.2	5.0
Нийт актив/ДНБ	21.3	23.6	22.0	22.9	23.1	29.8	40.1
Банкнаас гадуурхи мөнгө/ДНБ	6.5	6.0	6.9	10.0	10.3	9.7	9.8
(М2-Бэлэн мөнгө)/ДНБ	13.4	14.4	13.6	15.2	16.1	19.6	28.4


Зураг 27. Мөнгөний нийлүүлэлт, банкнаас гадуурхи мөнгийг ДНБ-д харьцуулсан хувиар



Зураг 28. Чанаргүй зээл



Зураг 29. Θөрийн хөрөнгө болон активын өгөөж



харилцагчдын банкинд итгэх итгэл эрс дээшиллээ. Үүний дунд банкуудын орон нутагт салбар нэгжээ байгуулах сонирхол нэмэгдэж, салбарын хэмжээгээр хөдөө орон нутаг дахь харилцахын үлдэгдэл 4.2 тэрбум буюу 23.0 хувиар, хадгаламжийн үлдэгдэл 9.9 тэрбум төгрөг буюу 85.4 хувиар, зээлийн өрийн үлдэгдэл 24.6 тэрбум төгрөг буюу 2.8 дахин тус тус нэмэгдэж, 7.3 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь салбарын нийт татварын өмнөх ашгийн 40.0 хувийг эзэлж байна. Харилцах данс эзэмшигчдийн тоо 2 дахин, зээлдэгчдийн тоо 2.8 дахин өсчээ. ХААН банкны үйл ажиллагаа хөдөө орон нутагт голлох байр суурийг эзэлж байгаа бөгөөд тус банкны санхүү төлбөрийн чадвар, ашигт ажиллагааны түвшин өмнөх онуудтай харьцуулахад эрс сайжирч, активын өсөлтийн хувь нь салбарын нийт активын өсөлтийн хувиас 1.8 дахин их байсны зэрэгцээ үйл ажиллагааны цар хүрээ болон хэмжээгээрээ томоохон 3 банкны түвшинд хүрэх боллоо.

Банкууд зах зээл дэх байр сууриа тэлэх зорилгоор хөрөнгө их хэмжээгээр татан төвлөрүүлэх үүднээс эх үүсвэрийн хүүний түвшнээрээ өрсөлдөж байгаа нь хадгаламжийн хүүний түвшин хангалттай буурахгүй байх гол шалтгаан болж байна. Нөгөө талаас энэ байдал нь тэдгээрийг зах зээлийн эрсдэлд орох нөхцөлийг бий болгож байгаа хэдий ч санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр харилцагчдад үйлчлэх хандлагыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, манай улсын худалдааны гол түвшн орнуудын банкуудтай идэвхтэй, өргөн хүрээтэй хамтын ажиллагаа бий болгох, бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэр болох төлбөрийн картуудыг харилцагчдын хэрэгцээ, боломжид тохируулан гаргах, интернет банкны үйл ажиллагаа эрхлэх зэрэг болно. Голомт, Худалдаа хөгжлийн банкуудаас олон улсад нэр хүндтэй

Хүснэгт 14. Банкуудын салбар, нэгж (2002 оны эцсийн байдлаар)

	Улаанбаатар хот		Хөдөө орон нутаг		Нийт	
	Салбар нэгжийн тоо	Өөрчлөлт <sup>1</sup>	Салбар нэгжийн тоо	Өөрчлөлт <sup>1</sup>	Салбар нэгжийн тоо	Өөрчлөлт <sup>1</sup>
1 Хөдөө аж ахуй	11	4	352	25	363	29
2 Худалдаа хөгжил	8	0	10	-1	18	-1
3 Хадгаламж	32	1	9	0	41	1
4 Голомт	10	0	2	0	12	0
5 Шуудан	9	8	62	-1	71	7
6 Эрэл	3	0	1	0	4	0
7 Улаанбаатар хотын банк	16	0	2	0	18	0
8 Шинэчлэл	5	3	1	0	6	3
9 Тээвэр хөгжлийн банк	3	-1	0	0	3	-1
10 Кредит	4	3	1	0	5	3
11 Зоос	4	0	6	0	10	0
12 Анод	7	0	3	-1	10	-1
13 Интер	2	1	1	0	3	1
14 Капитрон	3	2	0	0	3	2
15 XAC	7	-1	20	8	27	7
16 Менатеп	1	0	0	0	1	0
Бүгд	125	20	470	30	595	50

<sup>1</sup>Өмнөх оны эцсээс өөрчлөгдсөн тоо

## Шигтгээ 7. Банк санхүүгийн салбарын ирээдүйн зорилт болон тулгамдсан асуудлууд

1999 оны сүүлээс банкны салбар эрс идэвхжиж, зээл, хадгаламжийн хэмжээ илт ёсч ББСБ-үүд ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлэв. Харин аж ахуйн нэгж, иргэдийн эх үүсвэрийн тур хугацааны дутагдлаа нөхөн хоёрдахь зарчмын /банкны зээлээс гадна/ суваг болох хөрөнгийн зах Монголд төдийлэн идэвхжилгүй өдийг хүрлээ. Монголын хөрөнгийн бирж нь гараагаа хувьчлалын цэнхэр, ягаан тасалбараар 1991 онд амжилттай эхэлсэн хэдий ч 90-д оны сүүлийн хагасаас уналтанд орсон. Унаж унтаниг байдалд орсон хөрөнгийн захахаа сэргээх нь нөгөө л банкнаас гадуур яваа мөнгийг банк болон бирж руу татах хамгийн зарчмын шийдэл мөн. Юун түрүүнд, засгаас биржээр дамжин алдагдсан иргэдийн 1 тэрбум төгрөгийн асуудлыг биржийн ирээдүйн хувьчлалын орлогыг барьцаалах замаар, эсхүл шууд нэг удаагийн төсвийн санхүүжилтээр хаахыг санал болгож байна. Ингэсний дараа шинэ гараанаас ажлаа эхлэх Монголын хөрөнгийн биржийн өнөөгийн институциональ бүтцийг ашиглан хөрөнгийн захыг идэвхжүүлэх арга замыг эрэлхийн нь зүйтэй.

Хөрөнгийн зах идэвхжих нь банкуудын дангаар ноёрхолыг эвдэн эдийн засаг дахь хүүний түвшинг бууруулан санхүүгийн зуучлалыг олон талт болгон гүнзгийрүүлэх эерэг талтай.

Төрийг санхүү банкны салбарын зээл олголтоос аль болохоор хол байлгах шаардлагатай. Төр тун тааруухан зээл олгогч гэдгийн жишээ лав л Монгол улсын хувьд хангалттай. Хэрэв төр тодорхой салбаруудыг хөрөнгөөр дэмжих болон тодорхой нийгмийн асуудлуудыг шийдэх шаардлагатай бол төсвөөс шууд санхүүжүүлдэг хөгжлийн банкаараа дээрхи асуудлыг хариуцуулан ашгийн төлөө санхүүгийн бусад зуучлалыг банкууд болон хөрөнгийн захахар гүйцэтгүүлэх.

Найдваргүй зээлдэгчдээ дампууруулах, өөрчлөх замаар эдийн засгийг цэвэрлэх үүргээ манай банкууд тун хангалтгүй гүйцэтгэж ирснээс эргээд өөрсдөө зээлийн хүндэрлэл ордог хандлага ажилгагддаг. Зүүн Европын шилжилтийн эдийн засагтай орнуудын туршлагаас харахад банкууд чанаргүй зээлээс болж дампуурсан аж ахуйн нэгжүүдийн бүтцийн өөрчлөлт болон дампуурлын ажиллагаанд активыг нь борлуулах, удирдлагыг нь өөрчлөх болон гардан явуулах, өглөгийг барагдуулах зэрэгт хамгийн идэвхтэй оролцож market exit policy-г банкууд сахиуулж иржээ. Харин манайд бол банк нь хөөцөлсөөр дампуурсан, эсхүл бүтцийн өөрчлөлтөнд хамрагдсан аж ахуйн нэгжийг хайвал хэдэн нэгж гарах бол?

Жинхэнэ утгаараа бие даасан, банкны гүйцэтгэх захирал болон бусад удирдлагын албан тушаалтны нөлөөнөөс ангид дотоод хяналтын алба банкинд байх нь гүйцэтгэл, түүнд тавих хяналтын зарчим хэрэгжихэд их чухал.

2004 оны 1 дүгээр улирлын эцсээр банкуудын хүрэх ёстой 4 тэрбум төгрөгийн дүрмийн сангийн доод хэмжээний шинэ шаардлагаас үүдээд банкуудын дунд тодорхой хэмжээний консолидаци ирэх хоёр жилд явагдах магадлалтай. Зарим жижиг банкууд нь том банкиндаа нэгдэн /corporate takeover or acquisition/, эсхүл өөр хоорондоо нийлэх болов уу, гэвч өнгөрсөн жилүүдийн дүрмийн сангийн өөрчлөлтүүдээс харахад Монголын банкирууд нийлэх, тохиролцох, нэгдэх асуудлууд дээр туйлын амжилт мутай нь харагдсан.

Банкуудын нийлж хамтрах чадавхи одоохондоо тааруу байгаа нь банкуудаас хам зээлжүүлэлт /co-financing/ ажиллагаа хэрэгжихгүй байгаагаар мөн батлагддаг. Хөрөнгийн хэрэгцээ том, эсхүл эрсдэл өндөртэй дэд бүтцийн болон үйлдвэрлэлийн төсөлд хэсэг банкууд эх үүсвэрээ нийлүүлэн орж хам зээлжүүлэлтийг явуулан эрсдэлээ хувацаан ашиг олдог нь аж ахуйн нэгжүүдэд олон банк дамжин зээл хайх бэрхшээлийг арилгадаг сайн талтай.

Манай эдийн засгийн хүчин чадал, зах зээлийн эрэлт хэрэгцээг ажиглаваас жижиг болон дунд үйлдвэрлэлийг (SME) зээлж санхүүжүүлэх нь банкуудад хамгийн ирээдүйтэй.

Инфляцийг төв банк жилийн 4-5 хувьд тогтвортой барьсан тохиолдолд жилийн 8-14.4 хувийн хүүтэй 12-24 сарын хугацаатай зээлийг олгох хөрс нь банкуудад бүрдэнэ. Зээлийн хүү буурч хугацаа уртасахын хирээр зээлжүүлэлтийн хэв загвар өөрчлөгдөн арилжаа наймаа гэхээсээ илүү хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл руу зээл чиглэнэ.

Өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол орны хувьд санхүүгийн үйлчилгээг орон нутагт жигд тэгш хүргэх асуудал нийгмийн эрх тэгш байдалд тун чухал. Хөдөөд үйлчилгээ үзүүлдэг ХААН болон ХАС банкууд, мөн хөдөөгийн ББСБ, гадаадын зээл тусламжийн төслүүд, мөн малчид тариаланчдын өөрсдийг нь хоршоолох хэлбэрийг хослуулах замаар хөдөөгийн санхүүгийн асуудлыг шийдэж болмоор.

**Шигтгээ 7. Банк санхүүгийн салбарын ирээдүйн зорилт болон  
тулгамдсан асуудлууд /үргэлжлэл/**

Монгол улсад хамгийн элбэг байгаа боловч одоогоор эдийн засаг болон мөнгөн эргэлтээс гадна байгаа цорын ганц актив болох газрыг эдийн засаг болон мөнгөний эргэлтэнд яаралтай оруулж газрыг бараа таваар актив болгох шаардлагатай. Энэ нь асар их хэмжээний нэмүү өргтийг хормын зуур бий болгоос гадна банкуудын үл хөдлөх хөрөнгийн зээлжүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ. Өмчлөлийн суурь ойлголтыг газар л төрүүлнэ, гаднаас хөрөнгө татах том суваг ч болж чадна.

Дотоодын аж ахуйн нэгжүүдийн бүртгэл тооцоо сайжирч, аудитын байгууллагын ажиллагааг жигдрэхийн хирээр дотоодын аж ахуйн нэгжүүдийн тайлан тэнцэлтэй ажилласны үндсэн дээр тэдгээрийн төлбөрийн чадварт үнэлгээ өгч, хооронд нь зэрэглэл тогтоох ажил аажимдаа хийгдэх ёстой.

Монголын Банкуудын Холбооны /МБХ/ ажлыг эрс идэвхижүүлэх замаар Төв банкнаас одоо эрхэлж байгаа клирингийн тооцоо, Банкны зээлийн мэдээллийн сан, Банкны сургалтын төв зэрэг арилжааны чиглэлийн үйл ажиллагааг банк дундынх болгох бололцоо болон шаардлага бий. Дээр дурьдагдсан дотоодын аж ахуйн нэгжүүдийн зэрэглэл тогтоох асуудал ч МБХ-нд хамаарч болно. Мөн МБХ-р дамжуулан Монголын банкны ажилтны ёс зүйн чанд хэм хэмжээг тодорхойлсон эрх зүйн актыг гарган мөрдүүлэх замаар банкны ажилтанг авилгаг, албан тушаал эрх мэдлээ хэтрүүлэн ашиглахаас сэргийлэх ёстой.

Өрсөлдөөн нэмэгдэж санхүүгийн зуучлал цаашид гүнзгийрэхийн хирээр банкуудын ажиллагаанд зах зээлийн болон суурь эдийн засгийн судалгааны ажлын шаардлага улам өсөх нь дамжиггүй. Энд ялангуяа Төв банкны судалгаа, эдийн засгийн ажилд тавигдах шаардлага улам өндөрсөнө. Эдийн засаг, санхүү банкны салбар дахь зүй тогтолцыг олж тогтоох, тэдгээрийн цаащдын хөгжил хандлагын төлөвийг таамаглах, эдийн засгийн загварчлалын эхний оролдлогыг хийх зэргээр Монголбанк өөрийн бодлого боловсруулт, шийдвэр гаргалтаа улам үндэслэлтэй болгон чанаржуулж чадваржуулах ёстой.

\* Судалгааг бүрэн эхээр нь Монголбанкны вэб хуудасны ([www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)) Нийтлэл хэсгээс үзнэ үү

Виза (VISA), Мастер карт (MasterCard) зэрэг картуудыг зөвхөн олон улсын эрхтэйгээр гаргаж байсан бол 2002 онд дотоодын картуудыг эрчимтэйгээр гаргасан нь амжилттай хэрэгжиж байна.

Санхүүгийн салбарт гарч байгаа гол өөрчлөлтийн нэг бол сүүлийн жилүүдэд УИХ-аас баталсан Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд БССБ-ын үйл ажиллагааг дэмжих талаар тусгагдсан зорилт байв. Үүний үр дүнд 1999 онд 2, 2000 онд 5, 2001 онд 21 БССБ байгуулагдан Монголбанкнаас банкны зарим үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан бол тайлант онд 41 БССБ шинээр байгуулагдсан байна.

#### **4.1. Банкны салбар**

Тайлант онд банкны салбарын нийт активын хэмжээ 48.2 хувь буюу 160.3 тэрбум төгрөгөөр өсч ДНБ-д эзлэх хувийн жин нь 40.0 хувь болсон байна. Активын дүн огцом өсөлттэй байгаа нь харилцахын үлдэгдэл 43.7 тэрбум, иргэд байгууллагын хадгаламжийн үлдэгдэл 83.8 тэрбум (үүнээс иргэдийн хадгаламж 82.2 тэрбум төгрөгөөр), өөрийн хөрөнгө 14.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байв.

Банкны салбарын нийт активын 45.2 хувийг цэвэр зээл, 14.3 хувийг гадаад актив, 12.3 хувийг Төв банкны үнэт цаас (ТБҮЦ), 11.1 хувийг банкны нөөц, 6.2 хувийг

## Хүснэгт 15. Зээлийн тайлан салбараар (тэрбум төгрөгөөр)

	Эхний үлдэгдэл	Олгосон	Төлсөн	2002.12.31 Эцсийн Үлдэгдэл
Зээлийн нийт дүн	135.1	469.7	374.3	231.3
Үйлдвэрлэлийн зориулалтаар	77.0	195.2	156.6	118.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт	7.6	13.0	12.1	8.4
Цахилгаан хий үйлдвэрлэл, усан хангамж	4.1	9.1	9.5	3.5
Барилга	7.4	18.9	12.1	14.3
Уул уурхай, олборлох үйлдвэрлэл	19.9	80.9	65.5	35.6
Боловсруулах үйлдвэр	38.0	73.3	57.4	56.2
Үйлдвэрлэлийн бус зориулалтаар	58.1	274.5	217.7	113.3
Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засвар	38.8	178.7	144.6	72.9
Аялал, жуулчлал, зочид буудал, зоогийн газар	3.9	8.2	7.0	4.0
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	2.9	11.8	8.7	6.0
Үл хөдлөх хөрөнгө, түрээсийн бизнесийн үйл ажиллагаа	1.1	4.5	3.3	2.2
Эрүүл мэнд, боловсрол	1.2	1.6	1.9	1.0
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.5	4.0	3.0	1.1
Бусад	9.7	65.7	49.2	26.1

засгийн газраас авах авлага тус тус эзэлж байгаа нь өмнөх оны байдалтай харьцуулахад цэвэр зээл, банкны нөөцөөс бусад активуудын нийт активт эзлэх хувийн жин буурсан байна. Харин актив тус бүрийн өөрчлөлтийн хувьд банкны нөөц 57.5 хувиар, бусад банкнаас авах авлага, ТБҮЦ-ны үлдэгдэл 30.0 хувиар, цэвэр зээлийн өрийн үлдэгдэл 73.7 хувиар, бусад үнэт цаас 5.5 дахин, үндсэн хөрөнгө 22.9 хувиар, репо хэлцлээр худалдаж авсан үнэт цаас 2.8 дахин, бусад актив 34.6 хувиар тус тус өслөө. Өөрөөр хэлбэл, засгийн газраас авах авлагын цэвэр үлдэгдэл, өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн цэвэр дүн буурч харин цэвэр зээлийн өрийн үлдэгдэл, Төв банк, Засгийн газрын үнэт цааснаас бусад төрлийн үнэт цаасны цэвэр дүн, мөнгөн хөрөнгийн дүн харьцангуй өндөр хурдацтай нэмэгджээ.

Тайлант онд банкны салбарын нийт пассивын дүн 51.2 хувь буюу 146.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 57.4 хувийг иргэд байгууллагын хадгаламж, 30.0 хувийг харилцах, 5.3 хувийг гадаад пассивын өсөлт тус тус эзэлж байна. Банкны салбарын пассивын бүтэц өмнөх оныхтой харьцуулахад харьцангуй тогтвортой байгаа бөгөөд нийт пассивын 50.6 хувь нь иргэд байгууллагын хадгаламж, 30.3

## Хүснэгт 16. Зээл, хадгаламж, банкнаас гадуурхи мөнгөний өсөлт

	1996	1997	1998	1999	2000	2001	2002 сая төгрөг
Нийт зээлийн өрийн үлдэгдэл	65860.9	50763.0	94614.1	82000.0	67000.0	135270.0	231729.8
Өсөлт	-0.7	-22.9	86.4	-13.3	-18.3	101.9	71.3
Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл	33048.0	14544.8	32638.9	30504.0	15718.0	10821.6	16690.1
Өсөлт	145.1	-56.0	124.4	-6.5	-48.5	-31.2	54.2
Хадгаламж	45917.8	58469.4	59308.7	69978.2	92686.2	134607.4	218359.6
Өсөлт	-2.4	27.3	1.4	18.0	32.5	45.2	62.2
Банкнаас гудуурх мөнгө	41704.4	49768.3	56445.8	87281.3	100933.4	109160.7	120783.6
Өсөлт	63.0	19.3	13.4	54.6	15.6	8.2	10.6

хувь нь харилцах, 6.9 хувь нь засгийн газрын хадгаламж, 3.2 хувь нь бусад пассиваас бүрдэж байна.

Дээрх байдлаас үзэхд, банкны салбарын хэмжээгээр харилцах, хадгаламжийн үлдэгдэл болон өөрийн хөрөнгийн өсөлтөөс бий болсон эх үүсвэрийн дийлэнх хэсгийг зээлд байршуулсан нь нэг талаас иргэд, байгууллагын банкинд итгэх итгэл дээшилсэн, нөгөө талаас зээлдэгчдийн санхүү төлбөрийн чадвар сайжирсантай шууд холбоотой. Цэвэр зээл өсч, нийт активт эзлэх хувь 6.7 нэгжээр нэмэгдэн 45.2 хувьд хүрсэн нь өмнөх онуудтай харьцуулахад өндөр үзүүлэлтэд тооцогдох бөгөөд тэнцлийн актив хөрөнгийн бүтцийн хувьд зээлээс бусад активуудын нийт активт эзлэх хувь хэмжээ буурсан байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд банкуудын сүл чөлөөтэй мөнгөн хөрөнгийг зээлд ашиглах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажилласны үр дүнд зээлийн өрийн үлдэгдлийн нийт активт эзлэх хувь хэмжээ нэмэгдэж, төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оныхоос 8.0 нэгжээр, валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2.4 нэгжээр тус тус буурсан байна.

Тайлант онд банкууд нийт 469.9 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өмнөх оныхоос 81.3 хувиар их байгаа бөгөөд үүний 41.5 хувийг үйлдвэрлэлийн салбарт, 58.5 хувийг үйлдвэрлэлийн бус салбарт олгосон нь 2001 онтой харьцуулахад үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн хувийн жин 10.4 нэгжээр буурсан байна. Үйлдвэрлэлийн бус салбараас бөөний болон жижиглэн худалдаа, аялал жуулчлал, зочид буудал, тээвэр холбооны салбарт олгосон зээлийн хэмжээ

**Хүснэгт 17. Банкуудын орлого, зарлага**

	тэрбум төгрөг									
	2002		2001		2000		2002/2001		2002/2000	
	Дүн	Хувь <sup>1</sup>	Дүн	Хувь <sup>1</sup>	Дүн	Хувь <sup>1</sup>	Дүн	Хувь <sup>2</sup>	Дүн	Хувь <sup>2</sup>
Нийт орлого	84.6	100.0	52.1	100.0	36.5	100.0	32.4	62.2	48.1	131.6
Хүүгийн орлого	57.9	68.4	35.0	67.1	22.6	61.9	22.9	65.5	35.3	156.1
Арилжааны орлого	12.3	14.5	5.1	9.8	1.2	3.3	7.2	140.4	11.1	927.9
Ханшийн тэгшитгэлийн орлого	4.1	4.9	2.5	4.8	5.2	14.4	1.6	64.4	-1.1	-21.2
Шимтгэлийн орлого	7.3	8.6	5.2	10.0	3.8	10.5	2.1	39.6	3.5	91.0
Бусад орлого	3.0	3.5	4.3	8.3	3.6	10.0	-1.3	-31.1	-0.7	-18.5
Нийт зарлага	66.7	78.9	36.1	69.2	24.6	67.3	30.6	84.8	42.2	171.5
Хүүгийн зарлага	24.2	28.7	13.4	25.7	8.5	23.4	10.8	80.7	15.7	183.9
Болзошгүй эрэдлийн зарлага	5.9	7.0	2.3	4.4	2.1	5.8	3.6	156.7	3.8	177.3
Арилжааны зарлага	11.4	13.5	3.7	7.1	0.2	0.5	7.7	207.0	11.2	6664.3
Ханшийн тэгшитгэлийн зарлага	3.8	4.5	2.5	4.9	5.3	14.5	1.3	51.2	-1.5	-27.5
Боловсон хүчний зарлага	9.5	11.2	5.9	11.3	3.0	8.2	3.6	61.1	6.5	216.0
Элэгдлийн зардал	1.9	2.2	1.2	2.3	0.7	1.9	0.7	55.9	1.2	170.1
Бусад зардал	9.9	11.8	7.0	13.5	4.2	11.5	2.9	41.8	5.8	137.1
Татварын өмнөх цэвэр ашиг	17.8	21.1	16.0	30.8	11.9	32.7	1.8	11.2	5.9	49.5
Татварын зардал <sup>1</sup>	6.8	8.1	6.2	11.8	0.6	1.5	0.7	10.6	6.3	1127.8
Цэвэр ашиг	11.0	13.0	9.9	18.9	11.4	31.1	1.1	11.5	-0.4	-3.3

<sup>1</sup> -нийт орлогод эзлэх хувь

<sup>2</sup> -өөрчлөлтийн хувь

### Шигтгээ 8. Хадгаламжийн даатгалын тухай

Сүүлийн жилүүдэд зарим нэг томоохон банкны хүндрэл нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг алдагдуулж, улмаар нийт эдийн засгийн тогтвортой ёсөлт, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байсан юм. Үүнд хүндрэлд орсон банкууд харилцагчдынхаа төлбөр тооцоог саатуулж, хадгаламж эзэмшигчдийн мөнгийг цаг тухайд нь тавьж олгож чадахгүй байснаас иргэдийн банкинд итгэх итгэл алдагдаж, банкнаас гадуур их хэмжээний санхүүгийн эх үүсвэр эргэлдэх болсон. Үүнээс үүдэлтэй хүчин зүйлсийн дор нийт эдийн засаг дахь санхүүгийн зуучлалын цар хүрээ хумигдаж, бодит эдийн засагт орох мөнгөний хэмжээ буурч байв. Дампуурсан банкуудын иргэдийн хадгаламжийг тавьж олгох асуудалтай холбоотой дарамтыг ихэнх тохиолдолд төр дангаараа үүрч байсан. Тухайлбал, өөрчлөлтийн хүрээнд 1996-1999 оны хугацаанд төрөөс нийт 70 гаруй тэрбум төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь төсвийн нийт орлогын 40 орчим хувийг, ДНБ-ний 7 орчим хувийг эзэлж байгаа юм. Иймд цаашид гарч болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хадгаламж эзэмшигчдийн банкинд итгэх итгэлийг дээшлүүлэх үүднээс хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна. Олон улсын байгууллагуудаас хийсэн судалгаанаас үзэхэд хадгаламжийн даатгалын тогтолцооны бүтэц, зохион

Иргэдийн мөнгөн хадгаламжийн үлдэгдлийн судалгаа (2002/12/31)

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжийн дүн	сая төгрөг		
			Хувь	ХЭ-ийн тоо	Хувь
0.0-0.5 сая хүртэлх	төгрөгийн валютын	9940.2 810.6	10,750.80	5.2	345,677 89.1
0.0-1.0 сая хүртэлх	төгрөгийн валютын	16380.8 1547.4	17,928.20	8.6	360,925 93.1
0.0-3.0 сая хүртэлх	төгрөгийн валютын	33792.0 5003.0	38,795.00	18.7	373,969 96.4
0.0-5.0 сая хүртэлх	төгрөгийн валютын	48780.4 9072.9	57,853.40	27.9	379,056 97.8
0.0-10.0 сая хүртэлх	төгрөгийн валютын	71385.9 16281.9	87,667.80	42.3	383,434 98.9
Бүгд	төгрөгийн валютын	153136.0 54254.1	207,390.18	100.0	387,758 100.0

байгуулалтын талаар тогтсон загвар байхгүй боловч бусад оруудын даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны туршлагаас үндэслэн зохистой зарчмуудыг тогтоон тэдгээрийг мөрдөн ажиллахыг зөвлөдөг байна. Үүнд:

Хадгаламжийн даатгалын асуудлыг төрийн ямар нэг эрх бүхий байгууллага, ихэнх тохиолдолд Төв банкинд хариуцуулж, үйл ажиллагааг нь хязгаарлагдмал хүрээнд буюу зөвхөн мөнгө хуримтлуулах, хадгаламж тавьж олгох хүрээнд явуулдаг байна. Үүнд холбогдох даатгалын санг төрөөс буюу Сангийн яам (СЭЗЯ), Төв банкнаас хөрөнгө нийлүүлэх замаар байгуулдаг. Харин цаашидын үйл ажиллагааг шимтгэл, хураамжийн болон хөрөнгө оруулалтын орлогоос санхүүжүүлдэг. Даатгалд хамрагдах байгууллагуудын хувьд бүх банкийг оролцуулах нь зүйтэй бөгөөд энэ нь эрсдэлийг тархаан байршуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Даатгуулах эх үүсвэрийн хувьд гол төлөв бага хэмжээний хөрөнгө мөнгөтэй, өөрийн эрх ашгийг хамгаалах чадвар нь хязгаарлагдмал, хөрөнгө мөнгөний эрсдэлийн удирдлагын талаар мэдлэг хомс жижиг хадгаламж эзэмшигчдийн мөнгийг хамруулах нь зүйтэй гэж үздэг.

#### Монгол улс дахь хадгаламжийн даатгал

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү эдийн засгийн сайд болон Хууль, зүй дотоод хөргийн сайдын шийдвэрээр Монгол улсад хадгаламжийн даатгалын тогтолцоог шийдвэрлэх асуудлыг судлах ажлын хэсгийг байгуулсан болно. Ажлын хэсгийн зүгээс тайлант хугацаанд банкуудын харилцах, хадгаламжийн үлдэгдэл судалгаа хийх, бусад оруудын туршлагатай танилцах, олон улсад хадгаламжийн даатгалын асуудлыг хариуцаж буй байгууллагуудтай холбоо тогтоож санал солилцох ажлыг хийж гүйцэтгэв. Иргэдийн мөнгөн хадгаламжийн судалгаанаас үзэхэд нийт хадгаламж эзэмшигчдийн 89.1 хувь буюу 345.7 мянган хадгаламж эзэмшигч нь 500.0 мянга хүртэлх төгрөгийн хадгаламжтай бөгөөд нийт хадгаламжийн 5.2 хувь буюу 10.8 тэрбум төгрөг байна. Мөн 1.0 сая төгрөг хүртэлх хадгаламж эзэмшигчийг оруулж тооцвол нийт хадгаламж эзэмшигчдийн 93.1 хувь буюу нийт 360.9 мянган хадгаламж эзэмшигч бөгөөд нийт хадгаламжийн 8.6 хувь буюу 17.9 тэрбум төгрөг байна. Түүнчлэн 3.0 сая төгрөг хүртэлх хадгаламж эзэмшигчдийг оруулж тооцвол нийт хадгаламж эзэмшигчдийн 96.4 хувь буюу 374.0 мянган хадгаламж эзэмшигч бөгөөд нийт хадгаламжийн 18.7 хувь буюу 38.8 тэрбум төгрөг байна. Хэрвээ 5.0 сая төгрөг гэж үзвэл одоогийн нийт хадгаламж эзэмшигчдийн 97.8 хувь буюу 379.1 мянган хадгаламж эзэмшигчийн мөнгөн хадгаламжийн дунгээр 57.9 тэрбум төгрөг буюу нийт хадгаламжийн 27.9 хувийг хамарч байна. Харин даатгуулах хадгаламжийн доод хэмжээг 10.0 сая төгрөгөөр тооцвол нийт хадгаламж эзэмшигчдийн 98.9 хувь буюу 383.4 мянган хадгаламж эзэмшигчдийн мөнгөн дунгээр 87.7 тэрбум төгрөгийн буюу нийт хадгаламж эзэмшигчдийн 42.3 хувийг хамарч байна. Мөн дээрхи судалганаас харахад нийт иргэдийн хадгаламж эзэмшигчдийн 3.4 хувь буюу 13.1 мянган хадгаламж эзэмшигч, нийт хадгаламжийн 26.2 хувь буюу мөнгөн дунгээр 54.3 тэрбум төгрөгийн валютын хадгаламж эзэлж байна. Мөн ажлын хэсгийн зүгээс хадгаламжийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулаад байгаа бөгөөд уг төсөлд хадгаламжийн даатгалын байгууллага нь СЭЗЯ, Монголбанк, банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгөөр байгуулах бие даасан хуулийн этгээд байх бөгөөд иргэдийн 5.0 хүртэлх сая төгрөгийн хадгаламжийг даатгаж үйл ажиллагаагаа явуулахаар тусгасан байна.

Өмнөх оныхоос их хэмжээгээр өсчээ. Аж үйлдвэрийн салбарт олгосон зээлийн хэмжээ 2001 оныхоос 33.1 хувиар, харин бусад салбарт олгосон зээлийн хэмжээ 120.4 хувиар өслөө.

Монголбанк Төв банкны тухай хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу 2001 оны 9 дүгээр сард үйл ажиллагаа явуулж байгаа банкуудад дүрмийн сангийн доод хэмжээгээ 2004 оны 1 дүгээр улиралд багтаан 4 тэрбум төгрөгт хүргэхийг үүрэг болгосны дагуу банкууд тайлант онд дүрмийн сангаа нэмэгдүүлэх байдал ажиглагдаа. Тайлант оны эцсийн байдлаар банкуудын өөрийн хөрөнгө нь дүрмийн сан болон ашгийн хэмжээгээр нэмэгдэн, өмнөх оны мөн үеийнхээс 14.1 тэрбум төгрөгт буюу 29.9 хувиар өсч, 43.1 тэрбум төгрөгт хүрэв.

Өмнөх онтой харьцуулахад банкуудын нийт орлого 62.2 хувиар, нийт зардал 84.8 хувиар тус тус өсч, үүний дүнд нийт ашгийн хэмжээ 11.5 хувиар нэмэгдсэн байна. Банкууд хөрөнгөө зээлд их хэмжээгээр байршуулж байгаатай холбогдон зээлийн хүүний орлого 2 дахин нэмэгдсэн хэдий ч хүүний зардал хүүний орлогоос илүү хурдацтайгаар нэмэгдсэн, болзошгүй эрдэлийн зардал өссөн зэрэг нь нийт зардал өсөхөд нөлөөлөв. Сүүлийн 2 жилийн хугацаанд банкуудын дунд өрсөлдөөн ихэсч байгаа нь тэдгээрийн эх үүсвэрт зарцуулж байгаа болон актив хөрөнгөдөө зарлаж байгаа хүүний түвшний өөрчлөлтөөр илрөч байна. Банкууд харилцагчдаа татах үүднээс зээлийн хүүгээ бууруулж, хадгаламжийн хүүндээ өөрчлөлт оруулахгүй байгаа зэргээс активын өгөөжийн үзүүлэлт 1.4 нэгжээр буурч 4.4 хувь боллоо.

#### 4.2. Банк бус санхүүгийн байгууллагууд

Монголбанкаас санхүүгийн зуучлалын үүргийг нэмэгдүүлэх, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих ажлын хүрээнд 1999 оноос иргэд байгууллагад банкны зарим үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох явдлыг дэмжсэний дүнд 2002 онд 41 ББСБ-д банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олголоо. УИХ, Засгийн газраас Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлан гаргаж, эдийн засаг нийгмийн хөгжлийг тэнцвэртэй хөгжүүлэх арга хэмжээг авч байна. Энэ хүрээнд Монголбанкаас ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг хот хөдөөд ялгавартай тогтоож, хөдөө орон нутагт санхүүгийн зуучлалыг өргөжүүлэх боломжийг нэмэгдүүллээ. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан нийт 66 ББСБ-ын 60 нь Улаанбаатар хотод, 3 нь Дархан хотод, 3 нь хөдөө орон нутаг (Төв, Архангай, Завхан аймгууд)-т

Хүснэгт 18. Банк бус санхүүгийн байгууллагуудын үзүүлэлтүүд

	тэрбум төгрөг		
	2000	2001	2002
Зээлийн өрийн үлдэгдэл	1.5	13.2	36.0
Нийт актив	3.0	23.4	44.1
Нийт пассив	1.4	3.1	18.4
Өөрийн хөрөнгө	1.6	20.3	25.7

байна. Иймд хөдөө орон нутагт энэ төрлийн байгууллага байгуулагдах нөхцөлийг бүрдүүлэхэд илүүтэй анхаарах хэрэгтэй байна. УИХ-аас "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль"-ийг батлан гаргасан нь цаашид ББСБ-ын үйл ажиллагаа өргөжин хөгжихөд гол түлхэц болно гэж дүгнэж байна.


ББСБ-уудын ихэнх нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх, цөөн байгууллагууд нь мөнгөн гүйвуулга, санхүүгийн түрээс, факторингийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна. Санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээ, бүтээгдэхүүн нэвтрүүлэх тал дээр дутмаг ажиллаж, тэдгээрийн санхүүгийн салбарын үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага, шинэ байгаа зэргээс ББСБ-аар үйлчлүүлэх иргэд цөөн, нөгөө талаас хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин доогуур, орлого бага, тэдгээрт хүрч үйлчлэх боломж дутмаг, мэдээлэл сурталчилгаа нь сайн хийгдэхгүй байгаа зэргээс шалтгаалж үйл ажиллагааны төрөл өргөжихгүй байна.

ББСБ-ын нийт активын хэмжээ өнгөрсөн оныхоос 88.5 хувиар өсч тайлант оны эцэст банкны салбарын нийт активын 8.9 хувийг эзэлж байна. ББСБ-ын нийт активт цэвэр зээл 80.6 хувийг, мөнгөн хөрөнгө 10.9 хувийг тус тус эзэлж байна. ББСБ-ын нийт орлогын 83.5 хувь нь зээлийн хүүнээс бүрдэж тайлант онд нийт 1.2 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

## **5. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

<b>5.1.</b>	<b>Мөнгөний бодлого</b>	<b>80</b>
<b>5.2.</b>	<b>Валютын бодлого, нөөцийн удирдлага</b>	<b>92</b>
<b>5.3.</b>	<b>Банк санхүүгийн байгууллагын хяналт шалгалт</b>	<b>96</b>
<b>5.4.</b>	<b>Бүртгэл тооцоо, мэдээллийн технологи</b>	<b>104</b>
<b>5.6.</b>	<b>Бусад үйл ажиллагаа</b>	<b>106</b>

## МОНГОЛБАНКНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## МОНГОЛБАНКНЫ УДИРДЛАГА



Ерөнхийлөгч О.Чулунбат



Тэргүүн дэд ерөнхийлөгч А.Батсүх



Тамгын газрын захирал  
Л.Мандал



Мөнгөний бодлого,  
судалгааны газрын захирал  
Б.Энххуяг



Дотоод аудитын газрын  
захирал Ц.Цолмон



Бүртгэл тооцоо, мэдээллийн  
технологийн газрын захирал  
Б.Лхагвасүрэн



Хяналт шалгалтын газрын  
захирал Л. Чимгээ



Валютын газрын захирал  
Ц.Одонгуа



Хуулийн хэлтсийн  
захирал Г.Эрдэнэбаяр



Үйлчилгээ аж ахуйн  
хэлтсийн захирал  
Ж.Халтар



Ерөнхийлөгчийн  
туслах, ерөнхий эдийн  
засагч Т.Ариунтунгалаг



Сургалтын  
төвийн захирал  
Д.Төрбат



Ноёцийн албаны  
захирал Г.Төмөрбаатар



Мөнгөний бодлогын  
хэлтсийн захирал  
Д.Болдбаатар



Судалгааны хэлтсийн  
захирал Н.Амар



Мөнгөн тэмдэгтийн  
хэлтсийн захирал  
Т.Халтар



Мэдээллийн  
технологийн хэлтсийн  
захирал Д.Гантулга



Хяналт шалгалтын  
хэлтсийн захирал  
Д.Ганбат



Бодлого зохицуулалтын  
хэлтсийн захирал  
Д.Бадраа



Банкны ўйл  
ажиллагааны хэлтсийн  
захирал Г.Тогтохбаатар

## 5. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тайлант онд Монголбанк макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, сүүлийн жилүүдэд гарсан үнэ, ханшийн тогтвормжилтыг бататган, санхүүгийн салбарт хийх бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх замаар тус салбарын сэргэлтийг гүнзгийрүүлэх, гадаад валютын нөөцийг зөв зохистой байршуулах, өсөлтийг хангахад анхаарч ажиллав.

### 5.1. Мөнгөний бодлого

Тайлант онд мөнгөний бодлого өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй зөвлөрсөн бөгөөд Монголбанкаас эдийн засгийн идэвхжлийг богино хугацаанд мөнгөний нийлүүлэлтээр дэмжих талаар санаачилгатай ажилласан жил байлаа. Мөнгөний өсөлтийн хурд нэмэгдэж, Монголбанкны бодлогын гол хэрэгсэл болох ТБҮЦ-ны хүү буурсан нь үүний нотолгоо юм.


Мөнгөний хурдтай өсөлт, хүүний бууралт нь санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлж буй хэрэг бөгөөд одоогоор харьцангуй бага судлагдсан манай эдийн засгийн мөнгөжилтийн үйл явцыг нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл санхүүгийн зуучлалд тулгарч байсан захирагаадлын дарамт үгүй болж, зуучлагчдын бизнесийн орон зай нэмэгдсэнээр санхүүгийн үйлчилгээний хомсдол арилж, үнийн хүчтэй өсөлтгүйгээр мөнгөний өсөлтийг бий болгох боломж бүрдэж байна. Банкны хууль зэрэг санхүүгийн зуучлалыг зохицуулах эрх зүйн орчинд дорвитой өөрчлөлт орсон, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл цэгцэrsэн зэрэг нь санхүүгийн зуучлалын дарамтыг арилгаж, үйлчилгээг хүртээлтэй болгоход нэн чухал хувь нэмэр оруулсан байна. Эдгээр нь бодит эдийн засгийн идэвхжлийг мөнгөний бодлогоор дэмжих бололцоо олгоод зогсоогүй түүний мөнгөтэй харьцах тааламжтай орчинг бүрдүүлж өгсөн юм.

Тайлант онд нийт мөнгөний хэмжээ эрчтэй өсч 470.1 тэрбум төгрөг болсон нь 1996 оноос хойшхи хамгийн өндөр өсөлт байлаа. Оны туршид гарсан мөнгөний өсөлтийг түүгээр санхүүжигдсэн активын хэлбэрээр авч үзвэл гадаад цэвэр актив 40.1 хувиар, дотоод цэвэр актив 54.7 хувиар өссөн юм. Энэ нь мөнгөний өсөлтийн дийлэнх нь дотооддоо зээл болсныг илтгэж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх нь банкуудын тогтвортой эх үүсвэр болох төгрөгийн болон гадаад валютын хадгаламжийн өсөлт байв. 2002 оны эцэст төгрөгийн хугацаат хадгаламж 147.2 тэрбум, гадаад валютын хадгаламж 135.2 тэрбум төгрөгт хүрч, нийт мөнгөний нийлүүлэлтийн 60.1 хувийг эзэлж байв. Нийт мөнгөний өсөлтийн 42.9 хувь нь төгрөгийн, 34.5 хувь нь гадаад валютын хадгаламжийн өсөлт байлаа.

Харин бэлэн болон бэлэн бус төлбөр тооцоонд хэрэглэгдэх мөнгө болох банкнаас гадуурхи мөнгө, банкууд дахь харилцаахуудын нийлбэр нийт өсөлтийн 22.7 хувийг эзэлж байв. Энэ нь манай иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд


Зураг 30. Мөнгөний өсөлтийн хурд, ТБҮЦ-ны хүү, ТБҮЦ-ны хүүгийн хандлага



Зураг 31. Хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгийн индексүүд, хувиар (2000.12=100)



Зураг 32. Мөнгөний үржүүлэгч



банкны тогтолцоонд илүү итгэлтэй хандах болсны илрэл бөгөөд банкууд нь нэмэгдэн ирж буй эх үүсвэрээр дотоодын зээлийг илүүтэй санхүүжүүлж байна гэж дүгнэж болохоор байна.

2002 онд олгосон дотоодын зээлийн өрийн үлдэгдлийн нийт хэмжээ 96 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний 90 гаруй хувь нь хувийн секторт олгосон зээлийн өсөлт байлаа. Зах зээлийн эдийн засгийн тогтолцоо бэхжиж, хувийн секторын үйл ажиллагаа идэвхжин, түүнийг дагаад санхүүгийн эх үүсвэр ч энэ секторт илүүтэй хуваарилагдах болжээ. Нөгөө талаас Засгийн газар банкуудаас ихээр зээлж, хувийн хэвшилд ноогдох зээлийн хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулдаг байсан зуршил өөрчлөгджэй, бодит эдийн засгийн бүтээлч ажиллах орон зайд нэмэгдүүллээ. Нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх чанааргүй зээлийн хувь 0.8 нэгжээр буурчээ.

Иргэд, байгууллагуудын хадгаламж өсч, түүнийг дагаад дотоодын зээлийн хэмжээ нэмэгдсэний дүнд дотоодын зээлийн (төгрөгийн) жилийн жигнэсэн дундаж хүү өмнөх жилийнхээс 8 нэгжээр буурлаа. Зээлийн хүүний энэ бууралт нь санхүүгийн зуучлалын хүрээ тэлж, төрөл зүйл нь олшрох зэргээр энэ салбарын эрүүл өрсөлдөөн нэмэгдсэний үр дагавар юм.

Бодит эдийн засагт очиж буй санхүүжилт хөрөнгийн захаар дамжиж эхэлсний жишээ нь барилгын бонд юм. 2002 онд МХБ-ээр дамжуулан арилжигдсан барилгын бондын жилийн дундаж хүү 19.7 хувь байлаа. Цаашдаа санхүүгийн салбарын тогтвортой ажиллагааны нэг нөхцөл болох хөрөнгийн захаар дамжин хийгдэх санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх бололцоо бүрдэж эхэлж байна. Гэвч санхүүгийн зуучлалын хоёр дахь сонгодог хэлбэр болсон хөрөнгийн захын ажиллагаа Монголд төдийлөн идэвхжихгүй байгаагаас зах зээл дээр банк, ББСБ-үүд дангаар ноёрхох, санхүүгийн үйлчилгээний хэт төвлөрлийг үүсгэх, хүүний түвшин өндөр байгаад нөлөөтэй байж болох талтай юм.

Мөнгөний бодлогыг үнэлэх гол үзүүлэлт инфляцийн хэмжээ 2002 оны эцэст жилийн 1.6 хувьтай байлаа. Сар бүрийн үнийн өөрчлөлт 2002 онд өнгөрсөн оныхоос эрс тогтвортой байв. Инфляцийн тогтвожилтийг сар бүрд ажиглагдсан үнийн хэлбэлзлийн дисперсиэр жишивэл 2002 онд өмнөх жилээсээ даруй 4.5 дахин бага байв.

Хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгийн индексүүдийн өөрчлөлтийг 1996-2002 оноор авч үзвэл хүнсний бүтээгдэхүүний бүлгийн индекс хамгийн их тогтвортой байв. 1999 оны 12-р сард хүнсний бүтээгдэхүүний индекс хамгийн бага буюу 36.3 (энэ үед ХҮИ 65.8) байсан бол 2001 оны 5-р сард 68.7(энэ үед 118.6) хүрсэн нь хамгийн өндөр утга байлаа. Хэрэглээний бараа, бүтээгдэхүүний сагсанд өндөр хувийн жин эзэлдэг мах болон сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны улирлын хэлбэлзлийн хандлагыг даган хүнсний бүтээгдэхүүний бүлгийн индекс улирлын хэлбэлзэлтэйгээр өөрчлөгджэй иржээ. 1997-1999 онуудад хүнсний бүтээгдэхүүний улирлын хандлага харьцангуй тогтвортой

### Шигтгээ 9. Монгол дахь инфляцийн эконометрик загвар болон инфляцийн шинж чанар

Нэг тэгшитгэлээс бүрэлдсэн эконометрик загварыг Ordinary Least Square /OLS/ аргаар Монголын эдийн засгийн 1993-2000 онуудын сар тутмын зарим үзүүлэлтүүд дээр тооцож Монголд инфляцийг тодорхойлогч хүчин зүйлсийг гаргаж тогтоох эмпирик оролдлогыг хийлээ. Зорилго бол мөнгөний нийлүүлэлт, ханш нь инфляцид нөлөөлдөг эсэхийг тогтоох, түүнчлэн Granger causality тестийн тусламжтайгаар мөнгөний өсөлт үнийн өсөлтийн “шалтгаан” болж өгдөг, мөн эргээд үнийн өсөлт нь мөнгөний өсөлтөө далладаг эсэхийг тогтооход оршино.

Инфляци, ханш болон мөнгөний нийлүүлэлтийн уялдаа харьцааг тооцох үүднээс дараахь регрессийг тооцов. Үүнд:

$$dCPI = a + b * dCPI_{(t-n)} + c * dER_{(t-n)} + d * dM_{(t-n)}$$

$dCPI_{(t-n)}$  нь  $(t-n)$  сарын Хэрэглээний үнийн индексийн /ХҮИ/ сарын өөрчлөлт

$dER_{(t-n)}$  нь  $(t-n)$  сарын төгрөгийн нэрлэсэн ханшийн хөдөлгөөний сарын өөрчлөлт

$dM_{(t-n)}$  нь  $(t-n)$  сарын M1 болон M2 мөнгөний агрегатын хөдөлгөөний сарын өөрчлөлт

Монгол бол жижиг бөгөөд нээлттэй эдийн засаг учраас төгрөг, америк долларын ханшийг тэгшитгэлд оруулав. Төгрөг америк долларын эсрэг супрахын хирээр инфляци өсөж болох талтай. Тус судалгааг хийхдээ монетарист загварыг авч тооцсон нь бүтцийн инфляцийн сургуулийг гадуурхсан хэрэг огт биш юм. Харин ч мах болон бусад хүнсний бүтээгдхүүний нийлүүлэлт улирлын ихээхэн хэлбэлзэлтэй, тэр хэлбэлзлээс шалтгаалан Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ ихээхэн хөдөлж ирснийг бид харсан.

CPI, M ER гэсэн үзүүлэлтүүдийн time series properties шинж чанарыг шалгахын тулд Augmented Dickey-Fuller (ADF) тестийг тооцоход гурван үзүүлэлт маань stationary буюу Гранжерийн тестийг явуулж болно гэсэн дун гарсан.

CPI, M болон ER гэсэн үзүүлэлтүүдийн time series properties шинж чанарыг шалгасны дараа өөрийн үндсэн инфляцийн загварыг тооцоход тэгшитгэлийн тайлбарлах чадавхи болох R2 үзүүлэлт маш бага гарч, мөн CPI, M болон ER үзүүлэлтүүд статистикийн хувьд тэгээс ялгаагүй гарсан. Мөн Jarque-Bera normality тестээр регрессийн үлдэгдлүүд хэвийн бус тархалттай гарсан нь CPI, M болон ER гэсэн үзүүлэлтүүд маань бүтцийн гүн гүнзгийн өөрчлөлтийн нөлөөнд автсаныг илэрхийлнэ. Дээрхи хүчин зүйлсээс шалтгаалан миний бодсон регрессийн тэгшитгэлийн үр дүнг цаашид ашиглах бололцоогүй юм. Иймд судалгааны хоёрдахь шат болсон Granger-Sims F-тестийг ашиглан үзүүлэлтүүд маань хамтдаа /jointly/ инфляцид нөлөөж байгаа эсэхийг тооцсон.

Эдгээр тооцоон дээр үндэслэн дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

Инфляцийг тодорхойлогч хүчин зүйлсийг Монголын нөхцөлд судлахаад Ordinary Least Squares /OLS/ аргачлалыг тун болгоомжтой хэрэглэх. Учир нь тооцоонд хамруулсан эдийн засгийн бүх үзүүлэлтүүд маань гүн гүнзгий бүтцийн өөрчлөлтөнд автсан учраас дун нь тодорхойгүй гарав.

12 сарын хоцролттой мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлт ХҮИндекст сувалтар нөлөөлдөг, бусад тохиолдолд энэ нөлөөлөл нь батлагдаагүй.

M2 агрегатын урьд өмнөх үзүүлэлтүүд түүний одоогийн түвшинг тодорхойлоход нөлөөгүй.

ХҮИндекстийн өмнөх үзүүлэлтүүд инфляцийн одоогийн түвшинг тодорхойлоход нөлөөгүй.

Бүтцийн учир шалтгаантай инфляцийн онол Монголын инфляцийг тайлбарлахад үүрэгтэй байж болох. Хамгийн энгийн жишээ бол махны улирлын шинж чанартай хомсдол нь ХҮИ-н өөрчлөлтийн 25 хувь хүртэл хэмжээнд нөлөөлдөг.

\* Судалгааг бүрэн эхээр нь Монголбанкны вэб хуудасны ([www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)) Нийтлэл хэсгээс үзнэ үү

байсан бол 2000-2001 онуудад энэхүү улирлын хэлбэлзэл илүү их нэмэгджээ. Харин өнгөрсөн онд хүнсний бүтээгдэхүүний улирлын хэлбэлзэл эргэж буурах хандлага ажиглагдаж байв.

Бусад бараа, үйлчилгээний бүлгийн индексүүдийн хувьд улирлын хэлбэлзэл ажиглагдахгүй байна. Орон сууц, цахилгааны бүлгийн индекс 1997-2000 оны сүүл хүртэл харьцангуй тогтвортойгоор өөрчлөгдөж ирсэн бол түүнээс хойш тогтвортгүй өөрчлөгдөх болсон байна. Энэ нь тухайн үед цахилгаан, дулааны үнийг нэмэгдүүлсэн (энэ нь нэг удаагийн шинжтэй арга хэмжээ байв)-тэй холбоотойгоор бүлгийн индекс хүчтэй өөрчлөгдсөн байж болох юм.

Хувцас, гутал, тээвэр, холбооны бүлгийн индексүүд дээрх хугацаанд тогтвортойгоор өсөн нэмэгдэж ирсэн бол гэр ахуйн бараа, эм, тариа, соёл, боловсрол, бусад бараа, үйлчилгээний бүлгийн индексүүд харьцангуй тогтвортой буюу бага өөрчлөгдөж байв.

Тайлант оны дунд үеэс эхлэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглах илүү уян хатан хэрэгсэл болох репо арилжааг нэвтрүүлэн хэрэглэж байгаа ч ТБҮЦ бодлогын гол хэрэгсэл байсаар байна. 2002 онд банкууд сард дунджаар 42.7 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ыг эзэмшиж байсан бөгөөд банк хоорондын зах дээр 7.1 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий үнэт цаас арилжаалагдсан байна.

Банк хоорондын захын арилжаа идэвхжин банкууд хоорондоо сард дунджаар 4.5 тэрбум төгрөгийн спот арилжаануудыг хийжээ.

#### *Төв банкны үнэт цаас*

Банкууд 2002 оны туршид өдөрт дунджаар 35.5 тэрбум төгрөгийн ТБҮЦ эзэмшиж байсан нь сүүлийн 3 жилийн дунджаас даруй 1.5 дахин их болсон бөгөөд оны эцэст Монголбанкнаас худалдсан үнэт цаасны хэмжээ 61.0 мянган ширхэг байв.

Тайлант онд ХААН, Худалдаа хөгжил, Анод, Голомт, Хадгаламжийн банкууд банк хоорондын зах дээр худалдсан болон худалдан авсан ТБҮЦ-ны нийт хэмжээний 85 хувийг эзэлж байна.

2002 оны эцсээр ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 9.97 байсан нь өмнөх гурван жилийн дунджаас 0.25 нэгжээр их байлаа. ТБҮЦ-ны жигнэсэн дундаж хүү 1, 4 дүгээр улиралд өсөх, 2, 3 дугаар улиралд буурах хандлага ажиглагдлаа. Хавар, зуны улиралд улирлын чанартай бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, алтны үйлдвэрлэл, ноос, ноолуурын бэлтгэл, ургац хураалт, барилга засвар, өвөлжилтийн бэлтгэл зэрэг нь бэлэн мөнгөний эрэлтийг ихэсгэж, банкуудын зээл олголт эрс нэмэгддэгтэй холбоотойгоор үнэт цаасны борлуулалт буурснаар үнэт цаасны жигнэсэн дундаж хүү өсч, 7 дугаар сараас хойш зээлийн эргэн төлөлтийн үйл ажиллагаа идэвхжиж, банкууд зээл олголтоо хязгаарлаж

### Шигтгээ 10. Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн уялдаа

Жилийн инфляцийн түвшин 1992 оноос хойш эрчимтэй буурч, тогтвортых хандлагатай байхад, харин мөнгөний нийлүүлэлт (M2) тогтвортой өсөх хандлагатай байлаа. Энэхүү инфляци, мөнгөний нийлүүлэлтийн эрс ялгаатай хандлагаас харахад инфляци, мөнгөний нийлүүлэлтийн хооронд тогтвортой хамаарал байгаа эсэх эргэлзээтэй юм. Энэ нь манай эдийн засгийн бүтцийн өөрчлөлтүүдтэй холбоотой байж болох талтай. Инфляци эдийн засагт тодорхой хугацааны хоцролт (time lag)-тойгоор нөлөөлдөг учраас түүнийг прогнозлох нь мөнгөний бодлогыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Инфляцид эдийн засгийн олон хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд: нийлүүлэлтийн талын хүчин зүйлс: зарим бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний улирлын хомсдол (markup) болон өртгийг нэмэгдүүлэх нөлөө (cost push); эрэлтийн талын хүчин зүйлс: эрэлтийн инфляци (demand inflation); мөнгөний нийлүүлэлтийн хүчин зүйлс болон гадаад хүчин зүйлс багтдаг.

Ихэнх судлаачид инфляци, мөнгөний нийлүүлэлтийн хамаарлыг судлахдаа бүтээгдэхүүн, мөнгөний зах зээлийн хамаарлыг илэрхийлсэн энгийн хоёр тэгшигтэлт загварыг ашигладаг. Бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл дээр, үнийн түвшин ( $P$ ) нь худалдагддаг бүтээгдэхүүний үнэ (tradable  $P_T$ ) ба худалдагддаггүй бүтээгдэхүүний үнэ (non-tradables  $P_{NT}$ )-ийн жигнэсэн дунджаар тодорхойлогдоно. Худалдагддаг бүтээгдэхүүний үнэ ( $P_T$ ) нь ханш (exchange rate E), гадаад зах зээлийн үнэ ( $P^*$ )-ээр тодорхойлогддог бол худалдагддаггүй бүтээгдэхүүний үнэ ( $P_{NT}$ ) нь нэгж хөдөлмөрийн өртөг (unit labor cost W)-ээр тодорхойлогддог.

Мөнгөний зах зээл дээр, мөнгөний бодит нийлүүлэлт (supply for real money ms) нь үнийн түвшин ( $p$ ), валютын ханш ( $e$ ), хүү ( $r$ ) болон ДНБ ( $y$ )-ээс хамаарал бүхий мөнгөний бодит эрэлт (demand for real money)-тэй тэнцүү байна.

Судалгаанд хамрагдсан бүх үзүүлэлтүүдийн хувьд нэгж язгууртай байна гэсэн  $H_0 : p = 1$  таамаглалыг няцааж чаддахгүй байгаа учир тогтвортой бус буюу  $I(1)$  процесс болно.

Шинжилгээний арга техникийн хувьд эдгээр үзүүлэлтүүдийн 1-р эрэмбийн ялгаварыг олж тогтвортой үзүүлэлт болгох замаар регрессийн шинжилгээг хийх эсвэл тогтвортой бус байдлаар ко-интэгрэйшн (co-integration) шинжилгээг хийх 2 боломжит хувилбар байж болох юм. Хугацааны хамаарлыг урт болон богино хугацааны байдлаар салган харуулж, аливаа бодлогын болон гадаад хүчин зүйлсийн шокуудын нөлөөт тооцох боломжтой байдгаараа ко-интэгрэйшн анализ нь давуу талтай юм. Гэвч судалгаанд хамрагдаж байгаа үзүүлэлтүүдийн динамик харьцангуй богино байгаа нь ко-интэгрэйшн анализыг үнэлэхэд хангалтгүй байж болох талтай. Загварын үнэлгээг Eviews 4.0 программаар үнэлэн, хязгаарлалт тавигдсан ко-интегреишн векторыг дараах тэгшигтэлээр харуулав.

$$CPI = 8.99E - 0.05t$$

$$M2 = -0.19CPI + 2.72E - 0.002R + 0.62Y$$

Судалгаанд хамрагдсан үзүүлэлтүүдийн хооронд 4-н боломжит урт хугацааны шугаман хамаарал байж болохыг Johansen тестиийн үр дүнгээс харж болно. Үзүүлэлтүүдийн динамик харьцангуй богино байгаа нь үнэлэгдсэн ко-интэгрэшн тэгшигтэлүүдийн корреляцийг (serial correlation) арилгахад хангалтгүй байна. Иймд судалгааны үр дүнг тооцоо, төлөвлөлтөнд ашиглах нь учир дутагдалтай юм.

\* Судалгааг бүрэн эхээр нь Монголбанкны вэб хуудасны ([www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)) Нийтлэл хэсгээс үзнэ үү

эхэлдэгтэй холбоотойгоор үнэт цаасны борлуулалт нэмэгдэж, жигнэсэн дундаж хүү буурдаг байна.

Тайлант онд ТБҮЦ-ны журамд дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг орууллаа.

Үүнд:

1. ТБҮЦ-ны арилжааг явуулахдаа хямдруулж дуудах анхны үнэ бус хямдруулалтын хувийг зарласны үндсэн дээр энэхүү хувь хэмжээгээр үнэ

- хаялцуулдаг;
2. ТБҮЦ-ны арилжаа явагдаж дууссаны дараа үлдэгдэл үнэт цаасыг арилжихгүй;
  3. Монголбанк банкуудаас хямдруулан худалдаж авсан үнэт цаасаа банкуудад дахин арилжихгүй зэрэг болно.

Энэхүү өөрчлөлт орохоос өмнө ТБҮЦ-ны арилжаа явагдаж дууссаны дараа нээлттэй зах зээл дээр нийт борлогдоогүй үлдсэн үнэт цаасны 74.7 хувь нь борлогдож байжээ.

Тайлант онд нийт гаргасан үнэт цаасны борлуулалт 80 хувьтай байсан нь өмнөх турван жилийн дунджаас 4 нэгжээр буурчээ.

Тайлант онд Монголбанкнаас ТБҮЦ-ны хүүд нийт 3.9 тэрбум төгрөг төлсөн нь өмнөх жилийнхээс 1.1 тэрбум төгрөгөөр буюу 37.1 хувиар өссөн байна.

#### *Rепо арилжаа*

Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд ашиглах илүү уян хатан хэрэгсэл болох репо арилжааг 2002 оны 7 дугаар сараас эхлэн банк хоорондын мөнгөний зах дээр албан ёсоор нэвтрүүллээ. "Буцаан худалдан авах ерөнхий гэрээ"-г банкуудтай байгуулсны үндсэн дээр Монголбанкны зүгээс нөөц мөнгөний хэмжээг уян хатан зохицуулах, банкуудын хувьд өөрийн илүүдэл нөөцийг үр ашигтай хэлбэрт байршуулах, эсвэл түр зуурын эх үүсвэрийн дутагдлаа нөхөх зорилготой арилжаануудыг шуурхай хийх болсон байна.


Монголбанк тайлант онд өөрийн эзэмшиж буй засгийн газрын бондыг мөн өөрийн гадаад активыг барьцаалан нийт 4 удаа 16.5 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнийн дүнтэй репо арилжаа хийсэн байна. Түүнчлэн банкууд банк хоорондын зах дээр ТБҮЦ-ыг барьцаалан репо хэлцэл идэвхтэй хийж ирлээ. Тухайлбал, 2002 оны 11, 12 дугаар сард банк хоорондын зах дээр нийт 23 удаа нэг бүр нь нэг сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 32.8 мянган ширхэг ТБҮЦ-ыг хямдруулан репо хэлцлээр арилжааллаа.

#### *Заавал байлгах нөөц*


Монголбанк нь төрөөс явуулж буй мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор банкны бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулах шаардлага тавин, өдөр бүр хангальтанд нь хяналт тавин ажиллав.

Заавал байлгах нөөцийг тооцож хяналт тавих, нөөц дутагдуулсан тохиолдолд ноогдуулах торгууль, банкуудын Монголбанк дахь харилцах дансандaa


Зураг 33. Банкуудын репо хэлцлээр худалдсан болон худалдан авсан ТБҮЦ-ны хэмжээ (2002/11-12)



Зураг 34. Заавал байлгах нөөцийн хүрэлцээ



Зураг 35. Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү



төвлөрүүлсэн хэсэгт төлөх хүүний хэмжээ зэргийг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 онд баталсан журмын дагуу тогтоож байна. Банкуудын харилцах дансанд төвлөрүүлсэн хэсэгт хүү төлж байсныг 2002 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн зогсоолоо.

Заавал байлгах нөөц тооцох, хяналт тавих журмын дагуу банкуудын заавал байлгах нөөцийн тооцоог сард хоёр удаа хийн, нөөцийн шаардлагыг хангагүй банкуудад торгууль ногдуулан ажиллалаа. 2002 онд банкуудын харилцах дансанд төвлөрүүлсэн хөрөнгөнд нийтдээ 102.9 сая төгрөгийн хүү төлж, нөөцийн шаардлагыг хангаж ажиллаагүй банкуудад 5.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна. Банкны системийн хэмжээгээр банкуудын заавал байлгах нөөц 2002 онд сар бүр хангагдаж байсан бөгөөд харилцах дансанд байлгах өдрийн дундаж үлдэгдэл 17.6 тэрбум төгрөг байхаас 28.7 тэрбум төгрөг байсан нь системийн хэмжээгээр өдөр бүр дунджаар 11.1 тэрбум төгрөгийн илүүдэл нөөцтэй байсан гэсэн үг юм.

Монголбанк нь банкуудын заавал байлгах нөөцийн доод хэмжээг сард 2 удаа тогтоон, уг үзүүлэлтийг үндэслэн дараа сарын эхний болон сүүлийн 15 хоногт байлгах өдөр бүрийн дундаж үлдэгдлийг банк бүрээр тогтоон өгч, уг үзүүлэлтийг өдөр бүр хангаж байгаа эсэхээр тухайн банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хянаж байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангаж байгаа нөхцөлд харилцагч, хадгаламж эзэмшигчдийн төлбөр тооцоог хугацаанд нь гүйцэтгэж чадна гэсэн үг юм. 2002 онд банкуудын заавал байлгах нөөц тооцох хувь хэмжээ 14 хувь байлаа.

Тайлант онд банкууд Монголбанк дахь харилцах дансандaa 9.0-14.6 тэрбум төгрөгийн илүүдэл нөөцийг тогтмол байршуулж ирлээ. Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн секторын үйл ажиллагаа тогтворжиж, банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэхийн зэрэгцээ банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ байнга өсөн нэмэгдэж ирсэн бөгөөд тайлант онд энэ байдал хэвээр хадгалагдан, банкуудын илүүдэл нөөцийн сарын дундаж үлдэгдэл 11.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 24.0 хувиар нэмэгджээ.

### *Зээлийн өрийн үлдэгдлийн дээд хязгаар*

Эрсдэл өндөртэй активт хэт их хөрөнгө оруулалт хийж, улмаар төлбөр тооцоо саатуулдаг байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор заавал байлгах нөөц болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдээ биелүүлээгүй, банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтуудыг зөрчих зэргээр үйл ажиллагаа нь хэвийн бус болж болзошгүй арилжааны нэг банкинд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар зээлийн өрийн үлдэгдлийн дээд хязгаарыг улирлаар тогтоон ажилласан бөгөөд тайлант хугацаанд тухайн банк тогтоосон зээлийн өрийн үлдэгдлийн дээд хязгаарыг хэтрүүлээгүй байна.

### Шигтгээ 11. Мөнгөний бодлогын эдийн засагт нөлөөлөх зам

Эдийн засгийн мөнгөний талыг тогтвортой байлгах, бодит эдийн засгийн өсөлтийг дэмжих тааламжтай орчинг бий болгох, улмаар иргэдийн амьжирааны түвшинг дээшлүүлэхэд мөнгөний бодлогын эдийн засагт нөлөөлөх замын талаарх төсөөлөл чухал байдаг. Мөнгөний бодлогын хэрэгслүүд нь банкуудын нөөцийн хэмжээ, банк хоорондын захын хүү, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш зэрэгт нөлөөлнө. Энэ нөлөө нь тодорхой хугацааны дараа мөнгөний нийлүүлэлт, зээл, хадгаламжийн хүүд нөлөөлдөг. Ингэж мөнгөний нийлүүлэлт, хүүнд гарч байгаа өөрчлөлт нь валютын ханштай нийлээд инфляци, бодит эдийн засгийн өсөлтөд нөлөөлнө.

Мөнгөний бодлого бодит эдийн засагт үр ашигтайгаар нөлөөлөх бололцоо нь уг нөлөөлөл ямар сувгаар дамжин өнгөрч байгаагаас ихээхэн хамаарна. Мөнгөний бодлого нь шууд бус хэрэгслүүд дээр тулгуурласан хэв шинжтэй тохиолдолд эхний ээлжинд мөнгөний зах түүний тодорхой хэсэг болох банк хоорондын захад нөлөөлнө. Харин уг нөлөөллийг бодит секторт зөв дамжуулах нь банкуудын шуурхай зохистой ажиллагаанаас шалтгаална. Банкууд ашгаа нэмэгдүүлэх зорилгын үүднээс мөнгөний бодлогын хэрэгслийн өөрчлөлтийг хурдан мэдэрч, өөрийн шийдвэрийг нийцүүлэн удирдаж чадвал уг нөлөөллийг илүү хурдан, үр ашигтайгаар дамжуулна. Ингэж мөнгөний захын өөрчлөлт бодит секторт хурдан, бодлого хэрэгжүүлэгчийн таамаглаж буй хэлбэрээ нөлөөлөхөд банкуудын шийдвэрээс гадна банкуудын уг шийдвэрийг гаргах бизнесийн боломж байгаа эсэх нь шийдвэрлэх нөлөөтэй.

Тэгвэл мөнгөний бодлогыг зах зээлийн механизмд тулгуурлан, өөрөөр хэлбэл шууд бус хэрэгслийн тусламжтай хэрэгжүүлэх нь банкны удирдлагын зохистой шийдвэр гаргах ур чадвар, хурд, мөнгөний захын зохион байгуулалт, банкны харилцагчдын өөрчлөгдөж буй орчинг түргэн мэдэрч хамгийн оновчтой шийдвэрийг гаргах боломж зэрэг олон хүчин зүйлсээс хамаарна. Энэ шаардлагын үүднээс Монголбанк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор санхүүгийн зуучлалыг саад болон өртөг багатай, илүү үр өгөөжтэй болгох үүднээс санхүүгийн зуучлалыг хэрэгжүүлдэг байгууллагуудын найдвартай байдлыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарал тавьдаг.

Ингээд мөнгөний бодлогын нөлөөллийг хүүний, мөнгөний өөрчлөлтийн хүрээнд доорх байдлаар танилцуулж байна.

#### Хүүний нөлөө

ТБҮЦ, репо хэлцлүүдийн дунд банк хоорондын захын хүү өөрчлөгдөж, эсвэл өөрчлөгдөх байсан нөхцөл байдал алга болж болно. Банк хоорондын хүү нь цаашидаа банкуудын активын ашигт нөлөөлснөөр түүний бүтцийг өөрчилж болно. Харин активын бүтцэд өөрчлөлт гарснаар зээлийн хүү, түүнийг дагаад нийт эдийн засгийн хэмжээгээр бусад хүүнүүд, валютын ханш өөрчлөгдөж болно. Валютын ханш нь цаашидаа худалдааны нөхцлийг гэх мэтээр дамжсан өөрчлөлтийг өдөөнө. Онолын хувьд эдийн засгийн мөнгөний тал нь тогтвортсон нийгэмд банкууд, санхүүгийн байгууллагуудын дээрх зохицуулалт тогтмол давтагдаг бол иргэд, байгууллагууд эдгээр өөрчлөлтийг мөнгөний бодлогын хэрэгсэл өөрчлөгдөж эхэлснээс мэдэрч урьдчилан таамаглаж, өөрсдийн сонголтыг хүүнээс хамааралтай хийдэг. Гэхдээ энэ байдал нэлээд сайн хөгжсөн санхүүгийн сектортой, тогтвортой эдийн засагтай нийгэмд ажиглагдана. Тэгэхээр хүүний нөлөө нь санхүүгийн зах зээлийн хөгжлийн хангалттай өндөр түвшин шаарддаг, санхүүгийн байгууллагуудын хурдтай, мэдрэмжтэй ажиллагаанаас хамаардаг нөлөөллийн суваг юм.

Бидний хувьд ТБҮЦ-ны хүү бусаддаа дамжсан нөлөөтэй байна уу гэдгийг сонирхож, нөлөөлөл байгаа эсэхийг Монголбанкны судалгааны ажилд (2001) судалсан бөгөөд ТБҮЦ нь банкуудын зээлийн хүүд маш сул нөлөөлдөг болохыг илрүүлсэн юм.

ТБҮЦ-ны нөлөө сул байгаагаас гадна нөлөөлөл нь тогтвортгүй болохыг ч өгөгдлийг ашиглан тогтоож болно. Өөрөөр хэлбэл ТБҮЦ-ны нөлөө нь банкууд өөрсдийн активын бүтцэд өөрчлөлт оруулах хэмжээний дохио өгөхгүй байгааг илтгэнэ. Нэгэнт банкуудын зүгээс хүүний өөрчлөлтийг мэдрэх, түүнд хариу үйлдэл хийх явдал байхгүй тул үүнээс цааш дамжих нөлөөллийд ч мөн илрэхгүй болох нь ойлгомжтой юм. Үүнийг тайлбарлаж болох гол үндэслэл нь мөнгөний захын зохион байгуулалт хангалттай хэмжээнд хөгжөөгүй, банкуудын хоорондын арилжааны дун нь ТБҮЦ-ны хүүнээс хамаарахуйц хэмжээнд хүрээгүй, хүрсэн ч үүнийг илрүүлэх хангалттай тоон өгөгдлүүд дутмаг байгаа нь судалгааны үр дүнг тааруу гарахад нөлөөлж болох юм.

Ер нь хүүний нөлөөлөл нь өөрөө санхүүгийн салбарын үндсэн захуудын тогтвортжилт, түүний зохион байгуулалт, хөгжлөөс ихээхэн хамаарах бөгөөд хүүний судалгаа нь өөрөө загвараас хэтэрхий хамааралтай байдгийг судлаачид тогтоосон байдаг. Тийм болохоор одоогоор Монголбанк хүүний нөлөөллийг бодлогын шийдвэртээ гол болгон хэрэглэх бололцоо хязгаарлагдмал байна.

### Шигтгээ 11. Мөнгөний бодлогын эдийн засагт нөлөөлөх зам /үргэлжлэл/

#### Мөнгөний нөлөө

Монголбанк мөнгөний хэмжээг нэмэгдүүлснээр банкуудын зээлжүүлэх чадварыг эсвэл Засгийн газрын төлбөрийн чадварыг нэмэгдүүлж нийт эрэлтийг нэмэгдүүлэн эдийн засгийн идэвхжилийг сэргээдэг. Гэхдээ хугацаа өнгөрөх тутам энэ идэвхжил нь үнэ, цалингийн өсөлт зэрэг нэрлэсэн үзүүлэлтуудийг өсгөснөөр эдийн засгийн өсөлтийн ач холбогдлыг алдагдуулдаг. Энэ бол мөнгөний бодлогын мөнгөөр дамжих нөлөөллийн талаар эрдэмтдийн нийтлэг хүлээн зөвшөөрсөн ерөнхий дүгнэлт юм. Ийм учраас мөнгөний нийлүүлэлтийг удирдах нь богино хугацааны эдийн засгийн хэлбэлзлийг удирдах арга болохоос урт хугацаанд эдийн засгийг тогтвортой өсгөх, өсөлтийг дэмжих арга биш юм. Нөгөө талаас үнийн өсөлт нь ард түмний амьжиргааг доройтуулдаг онцгой нөлөөтэй хүчин зүйл учраас мөнгөний өсөлт үнийн өсөлтийг бий болгох нөхцлийг бүрдүүлэхгүй байхыг аливаа төв банк эрмэлзэх шаардлагатай юм. Ингээд мөнгөний нөлөөллийн замыг авч үзье.

Мөнгөний нийлүүлэлт нь мөнгөний бодлогын хэрэгслээр, Монголбанкнаас банкууд эсвэл Засгийн газарт олгосон зээлээр, гадаад валютын арилжаагаар нэмэгдэнэ. Манай эдийн засгийн шилжилтийн үеийн уламжлалын дагуу Монголбанкны алт худалдаж аван мөнгөжүүлэх ажил эрхэлдэг. Алтын арилжаагаар нэмэгдэж буй мөнгөний нийлүүлэлт их том дүнтэй байдаг бөгөөд шууд ахуйн нэгжүүдэд төлөгддөг тул мөнгөний нийлүүлэлтэд банкуудаар дамжихгүй шууд нөлеөлдөг онцлогтой. Манай орны бас нэг онцлог нь долларжилтын нөлөөгөөр бизнесийн байгууллагууд гадаад валютыг төлбөр тооцоондоо ихээр ашигладаг. Гадаад валютын төлбөр хүлээж авдгаас шалтгаалаад банкууд эсвэл компаниуд гадаад валютын зээл гадаадаас аваад тодорхой хугацаанд төлбөр тооцоондоо хэрэглэсээр байвал мөнгөний нийлүүлэлт гадаад валютын харилцах, хадгаламжийн дүнгээр Монголбанкнаас хамаарахгүй нэмэгдсээр байна. Харин Монголбанк гадаад валютын худалдаж авснаар уг өсөлт нь төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ. Монголбанкны худалдаж авсан алт, гадаад валютын хэмжээ мөнгөний нийлүүлэлтийг ихээр нэмэгдүүлж ирсэн.

Монголбанкнаас нэмэгдүүлж буй мөнгө нь эхлээд нөөц мөнгийг, нөөц мөнгө нь цаашдаа мөнгөний нийлүүлэлтийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлдэг. Нөөц мөнгө мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүчийг мөнгөний үржүүлэгч гэж нэрлэдэг. Манай эдийн засгийн хувьд мөнгөний үржүүлэгч нь тогтвортой байдалтай, түүний өөрчлөлтүүдийг бүрэн тайлбарлах боломж муу байна. Мөнгөний үржүүлэгч нь төлбөр тооцооны тогтолцоо, мөнгөний эрэлт зэргээс хамааран өөрчлөгднө. Хэрэв санхүүгийн зах зээлийн үзүүлэлтуудийн харилцан хамаарал нь бодит эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, эрх зүйн орчны болон бусад шалтгааны улмаас тогтвортой байвал мөнгөний үржүүлэгчийн өөрчлөлт тайлбарлахад төвөгтэй болно. Эдгээр өөрчлөлтүүдийг гадаад хүчин зүйлийн нөлөө гэж болох бөгөөд тэдгээр нь төв банк зэрэг макро санхүүгийн удирдлагын зорилгоос хамаардаггүй. Үүний нэг том жишээ нь санхүүгийн зуучлалын захиргаадлын дарамт алга болсон, банкны бүтцийн өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлж банкны хямрлыг амжилттай даван туулсан явдал юм.

Мөнгөний нийлүүлэлт нь мөнгөний тодорхой хугацааны дараа эдийн засгийн идэвхжил, үнийн өөрчлөлтийг бий болгодог тухай дээр дурьдсан билээ. Одоогоор Монголын тохиолдолд ийм нөлөөллийг судлан, тогтвортой загварыг гаргаагүй байна. Монголбанкны судалгааны ажилд “Мөнгөний нийлүүлэлт нь үнийн өсөлтийг бий болгох тогтвортой хамааралтай юу?” гэсэн асуултад хариулахыг оролдсон. Манай улсын бодит эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн хурдац, санхүүгийн зах зээлийн төлөвшил, банкны хямрал, магадгүй статистикийн үзүүлэлтүүдийн чанар, зэргээс шалтгаалан уг хамаарлыг тогтоох боломж хязгаарлагдмал байгааг тогтоосон. Мөнгө эдийн засгийн идэвхжилд нөлөөлж буй эсэхийг судлах асуудал тоон үзүүлэлтүүдийн хязгаарлалтаас шалтгаалан хойшлогдсон хэвээр байна.

Мөнгөний бодлогын нөлөөллийн замуудыг судалсан эрдмийн ажлуудад дурьдагддаг бас нэг суваг нь валютын ханшийн нөлөө юм. Гэхдээ энэ нөлөөллийн талаар манай орны хувьд тун бага судлагдсан сэдэв юм. Валютын ханш нь урт хугацаанд дунджаар тогтмол байх нь долларжилтыг арилгах зэрэг олон сайн үр дүнтэй. Харин богино хугацаанд тогтмол, ялангуяа огт хэлбэлзэхгүй байх нь банкуудыг, эсвэл тэдний харилцагчдыг валютын ханшийн эрсдэлд эмзэг болгох, худалдааны тэнцлийг муутган, эдийн засгийн өрсөлдөөнч шинжийг алдагдуулах муу талтай. Одоо хүртэл үр дагавар нь бүрэн арилаагүй Азиийн санхүүгийн хямралын гол бурууг ханшаа хэт тогтвортой байлгаж, эдийн засгийнхаа өрсөлдөөнч чанарыг золиослосон бодлогод тохиж байна.

\* Судалгааг бүрэн эхээр нь Монголбанкны вэб хуудасны ([www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)) Нийтлэл хэсгээс үзнэ үү

### *Дамжуулан олгосон зээлүүд*

2002 онд олон улсын санхүүгийн байгууллагаас Монголбанкаар дамжуулан зээлдүүлж буй дараахь 2 төслийг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих зорилго бүхий 10.0 сая дойч маркийн дүнтэй төслийн хүрээнд өссөн дүнгээр нийт 4.8 тэрбум төгрөгтэй тэнцэх эх үүсвэрийг Худалдаа хөгжлийн банк, Монгол шуудан банкуудаар дамжуулан дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг секторт олгоод байна. Үүнээс 2002 онд 1.1 тэрбум төгрөгтэй тэнцэх зээлийг олголоо.
2. Азийн хөгжлийн банкны "Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн үйл ажиллагаа 2002 оноос амжилттай хэрэгжиж эхлээд байна. Уг хөтөлбөрийн хүрээнд нийт 4.4 сая ам. долларын зээлийг оролцогч банкуудаар дамжуулан хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зорилгоор олгох юм. Зээлийн үйл ажиллагаа 2002 оны 4 дүгээр улирлаас ихээхэн эрчимжиж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд 2002 онд нийт 1.2 тэрбум төгрөгийн зээлийг Монголбанкнаас Зоос, Монгол шуудан банкуудад олгосон байна.

Түүнчлэн Монголбанк нь Засгийн газартай хамтран "Ажлын байр нэмэгдүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2002 онд нийтдээ 2.4 тэрбум төгрөгтэй тэнцэх жижиг зээлүүдийг төсөлд оролцогч Голомт, Зоос, Эрэл, Тээвэр хөгжлийн банкуудад олгосон байна.

### *Засгийн газрын цэвэр зээл*

2002 оны эцэст Монголбанк болон банкуудын нэгдсэн дүнгээр засгийн газраас авах авлага 30.7 тэрбум төгрөг, засгийн газрын хадгаламж 63.2 тэрбум төгрөг болж, цэвэр зээлийн хэмжээ -32.4 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 25.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Тайлант оны эхэнд байсан засгийн газраас авах Монголбанкны авлага (13.6 тэрбум) бүрэн төлөгдөж дууссан болон Монголбанк дахь улсын төсвийн төгрөгийн харилцах дансны үлдэгдэл өнгөрсөн оныхоос 11.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь засгийн газрын цэвэр зээл буурахад нөлөөлжээ.

### *Засгийн газраас авах Монголбанкны авлага, түүний төлөлт*

2001 оны эцсийн байдлаар засгийн газраас авах Монголбанкны авлага 13.6 тэрбум төгрөг байсан нь 2002 онд дараахь байдлаар төлөгдөж дуусчээ. 2001 оны жилийн цэвэр орлогоос 5.3 тэрбум төгрөг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 638 тоот тушаалын дагуу Монголбанкны дахин үнэлгээний сангаас

7.4 тэрбум төгрөг, Монголбанкнаас үзүүлсэн хүүний урамшууллаар 0.8 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

Засгийн газраас авах Монголбанкны авлага нь банкны бүтцийн өөрчлөлтийн Засгийн газрын энгийн өрийн бичиг (Ард, Даатгал банкийг татан буулгаж тэдгээрийн найдваргүй зээлд гаргасан банкны бүтцийн өөрчлөлтийн засгийн газрын энгийн өрийн бичиг болон банкны хуучин системээс ХААН, ХОТШ банкинд шилжсэн зээлд гаргасан засгийн газрын зээллэг), ХААН банкнаас шилжүүлэн худалдаж авсан засгийн газрын өрийн бичгээс тус тус бүрдэж байв.

Иргэний үнэмлэх хэвлэх компьютер систем, программ хангамжийг худалдан авч сууринуулахад зориулан Их Британийн Де Ла Рье Интернэшнл компаниас Монгол улсын Засгийн газрын авсан 1.7 сая ам. долларын зээлийн төлбөрийн векселийг Монголбанк баталгаажуулсантай холбогдон үүссэн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл 435.2 мянган ам. долларыг Санхүү, эдийн засгийн яам (СЭЗЯ) 2002 онд бүрэн төлж дуусгалаа.

#### *Засгийн газрын хадгаламж*

Засгийн газрын хадгаламж 2002 оны жилийн эцэст 63.2 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 19.5 хувь буюу 10.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт хадгаламжийн 95.4 хувь буюу 60.3 тэрбумыг улсын төсвийн, 4.0 хувь буюу 2.5 тэрбумыг орон нутгийн төсвийн, 0.7 хувь буюу 0.3 тэрбум төгрөгийг төсөвт байгууллагын төсвийн гадуурхи хөрөнгө эзэлж байгаа бөгөөд 33.5 тэрбум төгрөг буюу 53.0 хувь нь Монголбанкинд, үлдэх 29.7 тэрбум төгрөг буюу 47.0 хувь нь арилжааны банкуудад байршиж байна.

Улсын төсвийн хөрөнгийн голлох хэсгийг нийгэм хангамж, тэтгэвэр тэтгэмжийн сан (36.5 хувь), улсын төсвийн төгрөгийн харилцах (25.4 хувийг), улсын төсөвт байгууллагын төгрөгийн харилцах (29.5 хувийг), орон нутгийн төсвийн хөрөнгийн голлох хэсгийг орон нутгийн төсвийн төгрөгийн харилцах (51.5 хувь), орон нутгийн төсөвт байгууллагын төгрөгийн харилцах (46.1 хувь) тус тус эзэлж байв.

#### **5.2. Валютын бодлого, нөөцийн удирдлага**

Тайлант онд Монголбанк улсын гадаад валютын нөөцийг зөв зохистой байршуулах, өсөлтийг хангах, богино хугацаат зээлийн төлбөр болон импортын зохистой түвшинд барихад голлон анхаарч ажиллав.

#### *Гадаад валютын нөөцийн удирдлага*

2002 оны эцсийн байдлаар гадаад валютын цэвэр албан нөөц 225.9 сая ам.

## Хүснэгт 19. Лондонгийн банк хоорондын захын хадгаламжийн хүү (6 сар)

	1999	2000	2001	2002
Ам доллар	5.5	6.6	3.7	1.9
Евро	3	4.6	4.1	3.4
Иен	0.2	0.3	0.2	0.1
Фунт стерлинг	5.6	6.3	5	4.2
Швейцарь франк	1.5	3.3	2.9	1.2

долларт хүрч, өнгөрсөн онтой харьцуулахад 41.2 хувиар нэмэгджээ. Гадаад валютын цэвэр албан нөөц импортын 15.6 долоо хоногийн хэмжээг хангахуйц түвшинд хүрсэн нь Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан зорилтыг (13 долоо хоног) бүрэн хангав.

Гадаад валютын орлогын голлох хэсгийг мөнгөжсөн алт, банкуудаас худалдан авсан гадаад валют, гадаад зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн байна.

Тайлант онд дотоодын 124 алт олборлогч аж ахуйн нэгж болон банкуудаас улсын Эрдэнэсийн санд цэвэр жингээр 10.6 тонн алт худалдан авч, нийт 13 удаагийн ачилтаар 11.2 тонн алт гадаадад цэвэршүүлж, гадаад валютын орлогын 49.0 хувийг бүрдүүлжээ.

Дэлхийн эдийн засгийн уналттай холбоотой зах зээлд хүүний түвшин 2002 оны туршид бага хэвээр үргэлжилсэн хэдий ч гадаад валютын улсын нөөцийг оновчтой байршуулж, шинэ ашигтай санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулснаар зах зээлийн хүүнээс өндөр түвшинд орлого олох боломж бүрдэв. Тайлант онд зарим хөрөнгө оруулалт, тухайлбал үнэт цааснаас 14 хүртэл хувийн хүүний орлого олжээ.

Оны эцсийн байдлаар нийт 21 гадаадын банк, санхүүгийн байгуулагуудад 1-6 сарын хугацаатай хадгаламж болон үнэт цаас байршуулж, хадгаламжийн хуримтлуулсан хүүний орлого 3.2 сая ам. доллар, үнэт цаасны хүүний орлого 2.5 сая ам. доллар байна.

Тайлант онд дэлхийн зах зээлд алт болон голлох гадаад валютуудын ханшийн хэлбэлзэл их байсан хэдий ч зах зээлийн ханшийн төлөв байдалд тогтмол дүн шинжилгээ хийн, цаашдын чиг хандлагыг бодитой төлөвлөж, санхүүгийн деривативуудыг ашигласнаар алтны арилжаанаас 5.5 сая ам. доллар, гадаад валютын арилжаанаас 2.6 сая ам. долларын цэвэр ашигтай ажиллалаа. Мөн дотоодын алт олборлогчдыг дэмжих зорилгоор тэдний хүсэлтийн дагуу алтны форвард болон опцион арилжааг хийв.

Нөөцийн удирдлагын хүрээнд санхүүгийн деривативуудыг ашиглан чөлөөтэй хэлцэл хийх гадаад түншүүдийн тоог нэмэгдүүлэх, харилцагчаас учрах эрсдэлийг бууруулах зорилгоор деривативын арилжааг зохицуулах ерөнхий болон бусад гэрээг шинээр 6 гадаадын харилцагч банктай байгууллаа.

## Хүснэгт 20. Гадаад валютын арилжаа /засгийн газрыг оруулаагүй/

	2001	2002	сая ам доллар	
			Өөрчлөлт дүнгээр	хувиар
Худалдаж авсан	67.9	29.6	-38.3	-56.4
Худалдсан	181.3	112.3	-69.1	-38.1
Банкууд	156.0	97.2	-58.8	-37.7
Алт олборлогч үйлдвэр	25.3	15.1	-10.2	-40.5
Нийт эргэлт	249.2	141.9	-107.4	-43.1
Цэвэр	-113.4	-82.7		

*Валютын ханийн бодлого*

Тайлант онд Төв банкнаас валютын ханийн талаар бизнесийн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэсэн ханийн бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханийн тогтвортой байдлыг хадгалах зорилтыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүллээ.


2002 оны эцсийн байдлаар төгрөгийн ам. доллартай харьцах банк хоорондын захын дундаж ханш 1125 төгрөг болж, өнгөрсөн онтой харьцуулахад 2 хувиар суларсан нь Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан зорилтын (3%) хүрээнд байлаа. Төгрөгийн америк доллартай харьцах ханийн улирлын чанартай хэлбэлзэл багасч, жилийн туршид хэлбэлзэл тогтвортой байв. Оны сүүлийн хагаст Монголбанк банк хоорондын захын дундаж ханшнаас гадна арилжааны ханш зарлах, зах зээлийн ханийн хэлбэлзэлтэй уялдуулан ханш зарлах хугацааны шатлалыг богиносгох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Валютын ханийг зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн дагуу тогтоох, банк хоорондын валютын захын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монголбанк 2002 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс арилжааны ханийг зарлаж эхлэв. Валют худалдан авах ба худалдах ханийн зөрүүг Монголбанкнаас зарласан банк хоорондын захын дундаж ханшнаас (Midpoint rate) нэмэх, хасах 1 төгрөгтэй тэнцүү байхаар тогтоолоо.


2002 онд Монголбанкнаас банкуудтай хийсэн гадаад валютын арилжааны нийт эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 43.1 хувиар буурч, худалдан авсан ба худалдсан гадаад валютын цэвэр дүн 30.7 сая ам доллараар багасчээ.

Тайлант онд валютын дотоодын захын эрэлт нийлүүлэлт харьцангуй тогтвортой байсан бөгөөд банк хоорондын валютын захаар хийгдсэн валютын арилжаанд Монголбанкнаас худалдсан валют 22 хувь, худалдан авсан валют 7 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 36. Гадаад цэвэр албан нөөц



Зураг 37. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Зураг 38. Төгрөгийн бодит ба нэрлэсэн үйлчилж буй ханшийн хөдөлгөөн



### 5.3. Банк санхүүгийн байгууллагын хяналт шалгалт

Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны хүрээ өргөжин, шинэ техник технологи нэвтрэхийн хэрээр банкинд учирч болзошгүй эрсдэлийн төрлүүд нэмэгдэж байна. Монголбанк нь банкны хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахын тулд заавар журмын хэрэгжилтийн хяналтаас эрсдэл дээр тулгуурласан хяналт шалгалтанд чиглэн, учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, тодорхойлох арга хэрэгслийг боловсруулах, банкинд харилцагчдын зүгээс тавих хяналтыг дээшлүүлэхэд чиглэгдсэн хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд банкны үйл ажиллагаанд мөрдөх Монголбанкаас баталсан дүрэм, журмыг олон улсын, ялангуяа Базелийн хяналт шалгалтын хорооноос гаргасан стандартад нийцүүлэх ажил хийгдэж байна.

Монголбанк нь Төв банкны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагчдын банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тэдгээрийн өсөн нэмэгдэж байгаа эрх ашгийг хамгаалахыг гол зорилт болгон ажиллалаа. Цаашид банкны салбар тогтвожиж, үйл ажиллагаа нь хөгжихийн хэрээр банкуудын мөрдөх заавар, журам, хуулийг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байгаагаас олон улсын стандартад (тухайлбал Базелийн хяналт шалгалтын хорооноос тогтоосон стандартууд) нийцүүлэн заавар, зөвлөмж боловсруулахад анхаарал тавин ажиллаж байна. Үүний зэрэгцээ хяналт шалгалтын байгууллага болон дотоод, гадаад аудитын үйл ажиллагааны уялдаа, мөнгө угаах үйлдлийн эсрэг авах арга хэмжээ, урт болон дунд хугацаанд зээл олгоход баримтлах ерөнхий чиглэл, банкны байгууллагын дагаж мөрдвөл зохих зохистой удирдлагын зарчмууд, түүнийг хэрэгжүүлэх талаар заавар, зөвлөмж болон аргачлалуудыг гаргалаа.

#### Өөрийн хөрөнгийн үзүүлэлт

2002 оны эцэст банкны салбарын хэмжээгээр нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 20.0 хувь байгаа нь өмнөх оныхоос 4.6 нэгжээр буурсан хэдий ч Монголбанкаас тогтоосон доод хэмжээнээс 10.0 нэгжээр их байна.

Банкууд татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ харьцангуй өндөр эрсдэлтэйгээр тооцогддог активт буюу зээл болон бусад дотоод, гадаадын банкуудад байршуулах хандлагатай болсон нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт буурах гол нөхцөл болов. Сүүлийн жилүүдэд банкууд зээлдэгчдэд тавих хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зээлийн үйл ажиллагаагаа цөөн тооны найдвартай зээлдэгчдэд төвлөрүүлэх, эрсдэл багатай гэж тооцогдох Төв банк болон Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө байршуулах хандлагаа өөрчилж, аль болох харилцагчдыг татах, ингэснээр зах зээлд тодорхой байр суурь эзлэх зорилгоор эх үүсвэрээ хүүний орлого өндөртэй актив хөрөнгөнд байршуулж байна.

Тайлант онд бүх банкууд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг хангаж ажиллалаа. Өнгөрсөн 1 жилийн хугацаанд зарим банкуудын үзүүлэлт тогтвортой байж, өмнө нь өндөр түвшинд байсан ихэнх банкуудын үзүүлэлт буурах хандлагатай байна. Банкууд уг үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулахад холбогдох журмаар тогтоосон хязгаарлалтын хүрээнд харьцангуй бага, тогтвортой түвшинд хангаж байгаа нь бусдаас хөрөнгө татан төвлөрүүлсэн сул чөлөөтэй хөрөнгөө харьцангуй өндөр эрсдэлтэй буюу хүүний орлого өндөртэй актив хөрөнгөнд байршуулах бодлого барьж байгааг харуулж байна.

#### *Хөрвөх чадварын үзүүлэлт*

Монголбанкнаас банкуудын хөрвөх чадварын байдалд заавал байлгах нөөцийн хувь хэмжээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг үнэлэн хяналт тавиж байна. Сүүлийн 2 жилийн байдлаар банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх онуудынхаас хурдацтайгаар өсч байгаа боловч төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт тогтвортой өндөр түвшинд байна. Уг үзүүлэлт өмнөх оныхоос 2.6 нэгжээр буурч 45.6 хувь байгаа (Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийн доод хэмжээнээс 30.5 нэгжээр их байна) нь банкууд хөрөнгийнхөө багагүй хэсгийг эрсдэл багатай буюу мөнгөн хөрөнгө, Монголбанк болон бусад банк дахь харилцах, хадгаламжид байршуулж байгаатай холбоотой байна. Банкуудын хувьд зээлээс бусад активт тухайлбал, харьцангуй өндөр хүүний орлого бүхий санхүүгийн түрээс, үнэт цаас зэрэг активт хөрөнгөө байршуулах санхүүгийн зах зээл манай оронд хөгжөөгүй, нөгөө талаас банкны боловсон хүчний мэргэшлийн байдал дутмаг зэргээс активын багцыг тараан байршуулах боломж бага хэвээр байна.

#### *Зээлийн үйл ажиллагаа ба зээлийн багцын чанар*

Банкны салбарын хэмжээгээр зээлийн өрийн үлдэгдэл бусад актив хөрөнгөөс хамгийн өндөр хувиар буюу 2002 онд 71.3 хувиар өсч жилийн эцэст 231.4 тэрбум төгрөг болов. Чанаргүй зээл 5.7 тэрбум төгрөг буюу 52.3 хувиар нэмэгдэж, 16.6 тэрбум төгрөг болсон нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.2 хувийг эзэлж өнгөрсөн оныхоос 0.8 нэгжээр буурсан байна. Энэ нь зээлийн эргэн төлөлт сайжирснаас гадна тайлант онд банкуудын зээл олгох үйл ажиллагаа эрчимжин, хэвийн зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой юм. Зээлийн хүүг мөнгөн урсалаар тооцоолж үзвэл тайлант онд 27.1 хувь байгаа нь банкуудын зарласан хүүний жигнэсэн дунджаас (төгрөгийн) 6.3 нэгжээр, өмнөх оныхоос 14.3 нэгжээр буурчээ. Энэ нь банкуудын зарласан хүүнээс бодитоор орж байгаа зээлийн хүүний орлого нь өмнөх оны мөн үеийнхээс их болсон буюу хүүний төлөлт сайжирсныг илэрхийлж байна.

Банкны салбарын чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувийн жин буурч байгаа ч чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өссөн, банкуудын активт эзлэх зээлийн өрийн үлдэгдэл нэмэгдсэн зэргээс шалтгаалж зээлийн эрсдэл нэмэгдэж болзошгүй юм. Иймд банкуудын зээл олгох үйл ажиллагааг чанаржуулах,

зээлдэгч болон тухайн эдийн засгийн салбарын өгөөж, эрсдэлийг үнэлэх талд анхаарч ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Мөн шинэчилсэн Иргэний хуульд зээлийн барьцаа хөрөнгийн талаархи заалт нэг мөр болж чадаагүй, хууль хяналтын байгууллагуудын дунд ойлголтын зөрүү их байгаа зэрэг нь эрсдэлийг нэмэгдүүлж байна. Иймээс Дээд шүүхийн тайлбар гаргах эсвэл уг хуульд нэмэлт өөрчлөлтийг яаралтай оруулах нь зүйтэй юм. Нөгөө талаар, банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдэж, зээлийн өсөлт татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөөс өндөр хурдацтай байгаа нь банкны салбарын санхүүгийн зуучлалын үүрэг гүнзгийрч байгааг харуулж байна.


Монголбанкнаас Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн бөгөөд Дэлхийн банкнаас үзүүлж байгаа техник туслалцааны хүрээнд тус сангийн программ хангамж болон техник, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох үүднээс төслийг хэрэгжүүлэгч байгууллагыг уралдаант шалгаруулалтаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллаж байна. Үүний зэрэгцээ МХБ, Банкны өр барагдуулах алба (БӨБА), Гаалийн өрөнхий газар, Үндэсний татварын өрөнхий газартай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, мэдээлэл харилцан солилцож эхэллээ.

### *Зах зээлийн эрсдэл*

Банкны салбарын хямралын жилүүдэд банкуудын хүндрэлд орж байсан нь эдийн засгийн уналт болон банкуудын удирдлагын чадавхиас хамаарч байсан бол сүүлийн жилүүдэд зах зээлийн эрсдэл нь санхүүгийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, банкны удирдлагын чадвар, боловсон хүчиний мэргэшлийн байдал болон бусад хүчин зүйлсээс ихээхэн шалтгаалах боллоо. Тухайлбал, банкуудын боловсон хүчиний мэргэшил шаардлагатай хэмжээнд хүрээгүй нөхцөлд банкууд санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, шинэ үйл ажиллагааг зохих хяналтгүйгээр эрхлэх зэргээс ихээхэн хэмжээний алдагдал хүлээж болзошгүй юм. Банкуудын зах зээл дэх үнэ, хүүний хэлбэлзлээс хүлээж болзошгүй эрсдэлийн өөрийн хөрөнгөнд эзлэх хувь өмнөх онуудаас багассан боловч болзошгүй алдагдлын хэмжээ өслөө. Банкуудын өрсөлдөөн ихэсч, санхүүгийн бүтээгдэхүүний үнэ харилцагчдыг татах гол хэрэгсэл болж байгаа нь банкуудыг ханш болон хүүний эрсдэлд оруулах гол нөхцөл болж байна. Энэ нь нийт активын хэмжээ өссөн боловч актив пассив хөрөнгийн хүүний зөрүү багассанаас шалтгаалан банкны салбарын активын өгөөж буурсан, өөрийн хөрөнгийн өгөөж өмнөх оныхоос 8.0 нэгжээр бууран 22.9 хувь болсон зэргээс харагдаж байна.

Зах зээлийн эрсдэлийг тухайн санхүүгийн бүтээгдэхүүний үнэд тулгуурлан тооцдог боловч манай нөхцөлд гадаад валютын ханшаас бусад санхүүгийн бүтээгдэхүүний үнэ гажуудалтай, нөгөө талаас санхүүгийн бүтээгдэхүүний үнийг нэгдсэн байдлаар тооцож гаргахад банкуудын мэдээлэл боловсруулан гаргах чадавхи буюу программ хангамж ижил хангалттай түвшинд хүрээгүй байгаагаас банкуудын зах зээлийн эрсдэлийг олон улсын практикт сүүлийн үед

Зураг 39. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт



Зураг 40. Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа



хэрэглэж байгаа аргачлалаар тооцох боломж хязгаарлагдмал байна. Хэдийгээр 2001 онд банкуудад олон улсын банк санхүүгийн холбогдох байгууллагаас гаргасан тодорхой шалгуур хангасан нөхцөлд өөрсдөө гадаад валютын ханшийн эрсдэлээ үнэлэх загвар гаргаж удирдах боломж олгосон боловч уг аргачлалд банкууд шилжээгүйгээс үзэхэд бэлтгэл ажил хараахан хангагдаагүй гэж дүгнэж болохоор байна.

Монголбанкнаас банкуудын гадаад валютын ханшаас хүлээж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад валютын нээлттэй позицид хязгаарлалт тогтоон, хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд төгрөгийн америк доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой байсны зэрэгцээ банкууд ихэнхдээ гадаад валютын нээлттэй урт позицтой байснаас дийлэнх банкууд ханшийн тэгшитгэлээс алдагдал хүлээгээгүй байна. Салбарын хэмжээгээр гадаад валютын нээлттэй позици, нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 2001 онд 12.4 хувь байсан бол 2002 оны эцэст 8.9 хувь болж буурсан нь банкуудын өөрийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байв.

#### *Банкны хувьчлал*

Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд тусгагдсан банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг үргэлжлүүлэх ажлын хүрээнд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкуудын үйл ажиллагааг хэвийн түвшинд хүргэх, улмаар ашигт ажиллагаа болон банкны боловсон хүчин, удирдлагын чадавхи, дотоод бүтцийг сайжруулах зэрэг хувьчлалд бэлтгэх ажлууд хийгдлээ. Тайлант онд Худалдаа хөгжил, ХААН банкуудыг хувьчлах ажлыг зохион байгуулан, Худалдаа хөгжлийн банкны дүрмийн сангийн төрийн эзэмшилийн 76 хувийг Банк Коммерсиал Лугано, Жеральд Металс (Banca Commerciale Lugano, Gerald Metals) консорциумд шилжүүлэв.

ХААН банкны ашигт ажиллагаа дээшилж, үйл ажиллагааны цар хүрээ өргөжин, ялангуяа, хөдөө орон нутагт салбар нэгжээ нэмж нээх, санхүүгийн шинэ төрлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь эрчимжлээ. Иймд тус банкны үйл ажиллагааг цаашид өргөжүүлэн, хэвийн явуулах нөхцөлийг хангах, хувьчлах бодлого барин ажиллаж, Төрийн өмчийн хорооноос хувьчлалын ажлыг зохион байгуулж байна.

#### *Хяналт шалгалтын тогтолцоо*

Монголбанкнаас банкуудад хяналт тавих тогтолцоог олон улсын нийтлэг жишигт хүргэхийн зэрэгцээ банкуудын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдон гарах эрсдэлийг хянах арга барилыг боловсронгуй болгох, банк болон ББСБ-уудын мөрдөн ажиллаж байгаа заавар журмуудыг уян хатан болгох чиглэлд анхаарч ажиллалаа. Ингэснээр Банкны дүрмийн үлгэрчилсэн заавар, Нэгдсэн хяналтын журам, Интернет банкны төлбөр тооцооны журам зэргийг боловсруулан, банкуудад хүргүүлэв.

### Шигтгээ 12. Банкны зээлдэгчдийн дунд явуулсан санал асуулга

Энэ судалгааны ажил нь банкуудын зээлдэгчдийн дунд санал асуулгын хэлбэрээр явуулсан анхны судалгаа бөгөөд зээлдэгчдийн зүгээс банк санхүүгийн салбарын зээлжүүлэлт ямар түвшинд байгааг, банк санхүүгийн байгууллагын зүгээс оруулж буй эх үүсвэр эдийн засгийн аль салбар уруу чиглэж, цаашид ямар хандлагатай байгааг, улмаар Төв банкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд юуг анхаарах хэрэгтэйг харуулахыг зорив. Санал асуулгад тусгагдсан уялдаа бүхий 25 асуултын хариултуудыг нэгтгэн 6 дэд бүлэг болгон, бүлэг тус бүрээр нь дүгнэж гаргалаа.

Манай судалгаанд хамрагдсан 1610 зээлдэгчдийн дийлэнхи нь /63.6% буюу үүнээс 17.7% нь үйлчилгээ, 45.9% нь худалдаа/ худалдаа, үйлчилгээний салбарынх байгаа нь өнөөгийн манай зээлийн олдоц, хугацаа, нөхцлөөс шууд хамааралтай. Зээлийн хүү өндөр, хугацаа богино, нөхцөл нь уян хатан бус байгаа нь өнөөдөр зөвхөн арилжаа наймаа л зээлийг бодитой төлөх эх үүсвэрийг бүрдүүлнэ. Аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, уул уурхай олборлолтын салбарын зээлдэгчид хоёрдугаарт орж байгаа боловч цаашид хөрөнгө оруулалт хийх хэтийн төлөвөөр боловсруулах, бүтээх чиглэл тэргүүлж харин худалдаа үйлчилгээний хувийн жин багасахаар байна. Зээлийн эх үүсвэрийг арилжаанаас үйлдвэрлэл руу чиглүүлэхэд зээлийн хүүний түвшин, хугацаанд гарч буй өөрчлөлтүүд ихээхэн үүрэгтэй. Судалгааны дүнгээс хийж болох дараах ажиглалт, дүгнэлтүүд байна. Үүнд:

- Бизнесийн чиглэлийн хувьд зээлдэгчид маань нэн тэргүүнд алт, ноолуурыг ихэд сонирхдог.
- Цөөн томхон банкны ноёрхлоос шалтгаалан манай эдийн засаг дахь зээлийн нийлүүлэлт нь эрэлтээсээ хоцорсон. Иймээс хүүний өндөр түвшин олигтой буурч өгөхгүй байгаа /хоёрдугаар бүлгийн асуултын хэсгийг үзэх/. Ялангуяа зээлийн хэрэгцээ нь хотынхыг бодвол бага боловч хөдөөд зээлийн нийлүүлэлт хангалтгүй байна.
- Хөдөөгийн санхүүгийн зуучлал 1996-1999 оны хямралын үетэй харьцуулахад илт сэргээж байгаа хэдий ч бичил зээлийн хэрэгцээ ялангуяа хөдөө орон нутагт их байсаар байна. Ялангуяа манай орон шиг бага зах зээлтэй газар жижиг дунд үйлдвэрлэлийг зээлээр хөгжүүлэх эрэлт нь байна.
- Мөн зээлээр хангагдаагүй гэдэг хариултыг гол төлөв УБ хотын дунд жижиг зээлдэгчид хариулсан нь тэдний зээлийн эрэлт их, түүндээ таарсан зээл тэр болгон авч чаддаггүйтэй холбоотой.
- Монголын зээлжүүлэлтийн улирлын шинж чанар сүүлийн жилүүдээс алга болж байна уу гэсэн дүн манай судалгаанаас харагдаж байна.
  
- Зээлдэгчид зээлээ төлөхөд учирдаг эхний хоёр гол бэрхшээлд зээлийн хүү, хугацаа буюу цэвэр банкнаас өөрөөс нь хамааралтай хүчин зүйлсийг онцолсон. Зээлийн өндөр хүү эргээд өөрөө зээлийн эрсдэл болдог байж болох юм.
  
- Татварын ачааллыг зээл эргэж төлөхийн гуравдугаар том бэрхшээлээр зээлдэгчид нэрлэсэн. Түүний зэрэгцээ татвар өндөр байгаа өнөө үед ихэнх зээлдэгчид зээл авч үйлдвэрлэл эрхлэн үндэсний үйлдвэрлэлийг дэмжихийн оронд худалдаа арилжаа эрхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг талтай.
  
- Хөрөнгийн хомсдолын асуудлыг бизнес эрхлэгчид ихэнхдээ банкны зээлээр шийддэг. Харин банкны зээлийн дараа хувь хүмүүс хоорондын зээл ордог нь сонирхолтой. Иймд ББСБ-н хувьд бичил зээлийн зах зээл дээр үйлчлэх орон зайд хангалттай бий гэдэг дүгнэлт эндээс хийгдэхээр байна.
- Банкуудаас зээлдэгчдийг том жижгээр нь ялган гадуурхаг дээрээсээс манай судалгаанаас харагдаж байна.
- Мөн зээлийн үйлчилгээний хувьд зээлийн тоо хэмжээ, хугацаанаас гадна үйлчилгээний чанар, хүртээмжээр өрсөлдөх явдал банкуудад учир дутагдалтай байна.
- Зээлийн хугацааг сунгана гэдэг нь Монголын зээлжүүлэлтийн салшгүй нэг хэсэг болон харагдаж байна.
- Үнэт цаасны зах зээлээс хувьцаа бондын хэлбэрээр эх үүсвэрийн хомсдолоо нөхөх сонирхол бизнэс эрхлэгчдийн дунд байна.
- Монголбанкнаас явуулж буй мөнгөний бодлогын үр дунд инфляцийн түвшин жилийн 8 орчим хувьд тогтвортжуулж, цаашид буурах хандлагатай байгаа энэ нөхцөлд арилжааны банкууд зээлийн хүүний бодлогоо эргэж харах шаардлагатай байна. Зээл олгох хүү өндөр байснаар зээлийг буцааж төлөх эрсдэлийг ихээр нэмэгдүүлж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх биш бууруулах бодлого явуулж байна.
- Зээлийг богино хугацаатай олгож байгаатай холбоотойгоор зээлдэгчдийн ихэнх хувь нь түргэн эргэлттэй худалдаа үйлчилгээний зориулалтаар зээл авч ашиглаж байна. Харин үйлдвэрлэл явуулж буй болон явуулах сонирхолтой зээлдэгчдэд зээлийн авах боломж мүү, авсан цөөн зээлдэгчид их өндөр эрсдэл гаргахаар байна.

\* Судалгааг бүрэн эхээр нь Монголбанкны вэб хуудасны ([www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)) Нийтлэл хэсгээс үзнэ үү

Сүүлийн жилүүдэд Монголбанк нь банк болон ББСБ-уудад тавих олон улсад нийтлэг шинж бүхий бүтэцтэйгээр хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж байгаа нь үр дүнгээ өгч байна. Олон Улсын Валютын Сан (ОУВС) 2002 оны 11 дүгээр сард Монголбанкны Хяналт шалгалтын газрын үйл ажиллагааг Базэлын хорооноос гаргасан хяналт шалгалтын үндсэн 25 зарчмын хэрэгжилтэнд үнэлгээ өгч хөгжиж байгаа орнуудтай харьцуулахад хангалттай биелүүлж байна гэж дүгнэлээ.

Монголбанкнаас банкуудад мөрдүүлж байгаа журмуудын хоорондын давхардлыг арилгах, Банкны тухай хуульд заасан үйл ажиллагааг эрхлэх боломжийг өргөжүүлэх, хяналтыг хөнгөвчлөх үүднээс зарим үйл ажиллагаа эрхлэхэд тусгай журмын дагуу олон тооны баримт бичиг бүрдүүлэн зөвшөөрөл олгож байсныг өөрчлөн банкуудын үйл ажиллагаа болон бусад аливаа зөвшөөрөл авахтай холбогдсон харилцааг нэг журмаар шийдвэрлэх боллоо. Уг журамд орсон гол өөрчлөлт нь "Банкинд гадаад төлбөр тооцоо эрхлэх зөвшөөрөл олгох журам"-ыг хүчингүй болгож, үүнтэй холбогдох нэмэлт, өөрчлөлтүүдийг "Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-д оруулснаар банкууд гадаад төлбөр тооцооны энгийн үйл ажиллагааг байгуулагдсан үеэсээ эхэлж эрхлэн явуулах боломжтой болжээ.

Банкуудын эрсдэлийн дийлэнх хувийг эзлэх зээлийн эрсдэл, зээлийн хүүгээс хүлээж болзошгүй алдагдлыг бууруулах зорилгоор "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д ОУВС-ийн зөвлөмжийн дагуу өөрчлөлт орууллаа. Хугацаа хэтэрсэн зээлд байгуулах сангийн хувь хэмжээг нэмэгдүүлэн, банкууд дахь Засгийн газрын богино хугацаатай үнэт цаасанд эрсдэлийн сан байгуулахгүй байх, шаардлагатай гэж үзвэл хянан шалгачг тухайн зээлд байгуулах эрсдэлийн санг нэмэгдүүлэн байгуулах боломжийг олгов.

Цаашид банкуудын санхүүгийн тогтвортой байдлыг өнөөгийн хүрсэн түвшнээс бууруулахгүй байх, банкны санхүү төлбөрийн чадварт нөлөөлж болзошгүй эрсдэлүүдийг хаах зорилгоор мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх олон улсын хорооноос гаргасан "Мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх олон улсын стандарт"-ыг манай орны нөхцөл байдалд тохируулан "Мөнгө угаах үйл ажиллагааны эсрэг тэмцэхэд банк санхүүгийн байгууллагын анхаарах асуудлын тухай зөвлөмж"-ийг гаргалаа. Хууль бус үйл ажиллагааны орлогыг банк, санхүүгийн салбараар дамжуулан цэвэршүүлснээр санхүүгийн салбарын тогтвортой эерэг хөгжлийг сааруулах, өрсөлдөөний бодит шинж чанарыг алдагдуулах, бусад хууль бус үйл ажиллагаа буюу авилгалыг хөхүүлэн дэмжиж нийгмийн ёс зүй, түүний хөгжих эрүүл орчныг үгүй хийх гол нөхцөл болдог мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх ажлыг цаашид үргэлжлүүлэн хийх болно.

Банкуудын үр ашигтай, тогтвортой ажиллах гол үндэс нь зохистой удирдлагын зарчмуудыг хэрхэн хэрэгжүүлж байгаагаас голчлон шалтгаалах болсныг бусад орнуудын туршлага харуулж байна. Байгууллагын удирдлага, түүний төлөөлөн удирдах зөвлөл, хувь нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын хоорондын

харилцааны цогц болох зохистой удирдлагын зарчмыг Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага, Базэлын Хяналт шалгалтын хорооноос гаргасан аргачлалын дагуу өөрийн орны нөхцөлд нийцүүлэн гаргалаа.

#### *Газар дээрх шалгалт*

Тайлант онд үйл ажиллагаа явуулж байгаа 16 банкинд иж бүрэн, 3 банкинд хэсэгчилсэн, 4 ББСБ-д иж бүрэн, бүх ББСБ-д дүрмийн сангийн бүрдлийн хэсэгчилсэн шалгалтыг хийж, шалгалтын дүнг Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, биелэлтэд нь хяналт тавьж, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тооцон ажиллалаа.

Өмнөх онуудад газар дээрх шалгалтаар банкны төлбөрийн чадвар, активын багцын чанар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцох, активын эрсдэлийн сангийн хүрэлцээг тооцох, нягтлан бодох бүртгэлийн тэнцлийг судалж банкны бодит ашиг, алдагдлыг тооцон тодорхойлох зэрэг үйл ажиллагааг явуулав. Банкуудын нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хангалттай түвшинд хүрээгүй, аудитын байгууллагуудын үйл ажиллагаа шаардлага хангахгүй байгаа болон шинээр банкууд байгуулагдан үйл ажиллагаа нь жигдрээгүйгээс банкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг нарийвчлан шалгах шаардлага зүй ёсоор гарч байлаа.

Тайланд онд банкны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг банкуудын эрсдэлээ тооцоолох, удирдах, эрсдэлээс сэргийлэх чадварыг үнэлж дүгнэхэд чиглүүлж, банкуудын дотоод хяналтын тогтолцоо, зохистой удирдлагын зарчмуудын хэрэгжилтэнд голлон анхаарч ажиллав.

Хянан шалгагч нарт хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулахад манай орны нөхцөлд баримталж ажиллах заавар, аргачлал дутмаг байдгийг арилгах үүднээс олон улсын санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр Хянан шалгагчийн гарын авлагыг боловсруулан бэлэн болгов. Энэхүү гарын авлагыг Монголбанкны хянан шалгагч нараас гадна банкны дотоод хяналт, аудитын байгууллага, их дээд сургуулийн багш оюутнууд ашиглах өргөн боломжтой юм.

#### *Зайнаас хийх хяналт*

Банкнаас ирүүлсэн тайлан тэнцэл, бусад мэдээлэл, тэдгээрийн динамик болон ашигт ажиллагаа, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтүүд дээр тулгуурлан үйл ажиллагаанд нь зайнаас хяналт тавьж, банкуудын санхүү төлбөрийн чадварын байдлыг дүгнэн, төлбөрийн чадварын хүндрэлд орсон банкуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу цаг алдалгүй арга хэмжээ авч ажиллалаа.

2002 онд 16 банк, 66 ББСБ-ын сар, улирлын санхүүгийн тайлан тэнцэл, бусад

мэдээлэлд үндэслэн тогтмол судалгаа шинжилгээ хийж, зохистой харьцааны үзүүлэлтийг хэрхэн мөрдөж байгаа байдалд дүгнэлт гарган, холбогдох газар хэлтсүүдэд танилцуулах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав.

Шударга өрсөлдөөнийг дэмжих, банкны үйл ажиллагаанд хувь нийлүүлэгч, харилцагчдын зүгээс тавих хяналтыг дээшлүүлэх, тэдгээрээс хөрөнгөө банкинд байршуулахдаа зөв сонголт хийхэд мэдээллийн нээлттэй байдлыг бий болгох үүднээс банкуудын 2002 оны улирлын (жилийн) тайлангийн үзүүлэлт аудитын байгууллагаар хянацсан тайлангийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэх, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэгдэж буй хураангуй тайлангийн үзүүлэлтийн үнэн зөв эсэхэд тогтмол хяналт тавьж байна.

#### **5.4. Бүртгэл тооцоо, мэдээллийн технологи**

##### *Нягтлан бодох бүртгэл*

Олон улсын nyaгтлан бодох бүртгэлийн стандартыг Монголбанкны системд нийцүүлэх үүднээс "Монголбанкны nyaгтлан бодох бүртгэлийн журам"-д хэд хэдэн шинэлэг өөрчлөлтүүдийг боловсруулж оруулсан. Үүнд:

- Монголбанкны тэнцлийн актив пассивд бүртгэлтэй байгаа бүх мөнгөжсөн үнэт металлыг хуучин тогтмол нэг бүртгэлийн үнээр үнэлж бүртгэлд тусгадаг байсныг өөрчилж бүх мөнгөжсөн үнэт металлын дансдын үлдэгдлийг унцад шилжүүлж бүртгэн, Монголбанкаас зарласан гадаад валютын ханш өөрчлөгдхөд тэнцлийн актив, пассивд бүртгэлтэй бүх дансны үлдэгдэл дахин үнэлгээ хийж, үнэлгээний зөрүүг орлого зарлагын дансаар бүртгэх болов. Үүнийг Бүртгэл тооцоо мэдээллийн технологийн газрын Судалгааны алба болон мэдээллийн технологийн хэлтэс хамран боловсруулж программ хангамжийн хүрээнд хийж эхлээд байна.
- Санхүүгийн деривативуудыг тайлангийн тэнцлийн гадуур бүртгэдэг байсан бол тэнцлийн дотуур бүртгэх том өөрчлөлт орууллаа. Стандартын дагуу банк гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай болон бусадтай гадаад валютын арилжааны хэлцэл хийсэн бол ирээдүйд тодорхой үүрэг хүлээж байгаа гэдэг үүднээс хэлцэл хийсэн тухай бүр тэнцэлд өглөг, авлага үүсгэж бүртгэхээр тусгаж долоо хоног бүр деривативыг зах зээлийн үнэлгээгээр (fair value) үнэлж, үсэх ханшийн зөрүүг орлого, зарлагаар бүртгэж байхаар журамд оруулаад хэрэгжиж байна.
- Тэнцлийн гадуурхи бүртгэлд өөрчлөлт оруулахын зэрэгцээ тэнцлийн гадуурхи дансдын бүртгэлийн модулийг бүрэн өөрчилж, тэнцлийн гадуурхи бүх төрлийн тайланг программ хангажийн хүрээнд системийн нэгтгэл хийх, тэнцлийн гадуур бүртгэлтэй бүх хөрөнгийг зах зээлийн үнэлгээгээр үнэлэн төгрөгөөр бүртгэх, тэнцлийн гадуурхи бүх тайлан мэдээ, дансны

төлөвлөгөөг Монгол англи хэл дээр авах боломжтой болсон нь маш дэвшилттэй үзүүлэлт юм.

#### *Банк хоорондын төлбөр тооцоо*

Тухайн улсын эдийн засгийн өсөлтийг илэрхийлэх чухал үзүүлэлт бол ДНБ-ий эргэлт байдаг. Энэ үзүүлэлт нь Монголбанкаар дамжин банк хоорондын төлбөр тооцоонд оролцож буй нийт төлбөрийн дүng ДНБ-д харьцуулсан харьцаа юм. Θөрөөр хэлбэл, ДНБ-ий эргэлт нь тухайн улсын бодит эдийн засаг дахь нийт мөнгө ямар хурдацтайгаар, бэлэн бус хэлбэрээр банк хооронд шилжиж буйг илэрхийлнэ.

Сүүлийн 3 жилийн сар бүрийн банк хоорондын төлбөр тооцоонд оролцсон нийт гүйлгээний дүng авч үзвэл 2001 онд өмнөх оныхоос 52.9 хувиар, 2002 оныг 2001 онтой харьцуулахад 37.0 хувиар өссөн байна. Банк хоорондын тооцоогоор хийгдэх гүйлгээ нь нийт дүngээрээ жилээс жилд өссөөр байгаа бөгөөд 2002 оны дунд үед гарсан огцом өөрчлөлт нь банк, санхүүгийн системд гарсан зарчмын шинэ өөрчлөлт болох Төрийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа эхэлсэнтэй холбоотой юм.

ДНБ-ий эргэлт нь 2000 онд 1.07, 2001 онд 1.53, 2002 онд 1.94 байгаа нь иргэдийн банкинд итгэх итгэл сайжирч, банкаар хийгдэх гүйлгээ эрс нэмэгдэж буйг илтгэж байна.

Банк хоорондын төлбөр тооцоонд оролцогчдын мэдээллийн системд хандах ажлын байрны нууцлал, хамгаалалтыг сайжруулах зорилгоор Банк хоорондын цахим сүлжээний хэрэглэгчийн ажлын байрны аюулгүй байдлын журмыг батлан гаргалаа. Энэ дагуу банк хоорондын төлбөр тооцоонд оролцогчид нь Монголбанкны шаардлагыг хангах ажлын байраар хангагдах, Монголбанкны мэдээллийн системд өгөгдсөн эрхийн дагуу хандах боллоо.

#### *Мэдээллийн технологи*

Монгол улс дахь банкны системд орчин үеийн шинэ техник, технологи нэвтэрч буй нь банкны мэдээллийн технологийг бодлогын хүрээнд бэхжүүлэх, мэдээллийн нууцлал хамгаалалтыг сайжруулах шаардлагыг бий болгож байна. Иймээс Монголбанкаас мэдээллийн технологийн нууцлалыг сайжруулах, тавих хяналт болон шаардлагыг өндөржүүлэх үүднээс "Монголбанкны компьютерийн систем, мэдээллийн технологийн нууцын тухай журам"-ыг батлан мөрдүүлж эхэллээ. Тус журам нь зөвхөн Монголбанкны хэмжээнд хэрэглэгдээд зогсохгүй бусад банк, банк бус санхүүгийн байгууллагуудад үлгэрчилсэн загвар болон хэрэглэгдэнэ. Журмын хүрээнд банк, санхүүгийн байгууллагууд мөрдвөл зохих мэдээллийн технологи болон компьютерийн системийн нууцлалын удирдамжийг боловсрууллаа.

Банкны мэдээллийн нэгдсэн сан, техник болон программ хангамжийг болзошгүй аюул тохиолдсон үед бүрэн бүтэн байдалыг нь хангах зорилгоор онцгой байдалд ажиллах ажлын төлөвлөгөөг боловсрууллаа.

Монголбанк Азийн хөгжлийн банкны тусlamжтайгаар банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлэв. Уг төслийн хүрээнд ХААН, Худалдаа хөгжил, Эрэл, Монгол шуудан банкуудад олон улсын стандартад нийцсэн, банкны иж бүрэн программ хангамжийг суурилууллаа. Үүний зэрэгцээ, Монгол улсад анх удаа банкны үйлчилгээнд орон зайнаас хамааралгүйгээр явагдах зарчмын өөрчлөлт гарч, бодит цагийн онлайн (online) горимд шилжин ажиллах болов. ХААН банк өөрийн 30 гаруй салбарыг сансрын холбооны төхөөрөмжөөр (VSAT) тоноглон бүх салбаруудтайгаа бодит цагийн горимд холбогдон ажиллах туршилтыг амжилттай хийж нэвтрүүллээ. Мөн Эрэл банк Дархан Уул аймаг дахь салбартайгаа, Голомт банк Улаанбаатар хот дахь 6 дугаар тооцооны төвтэйгээ бодит цагийн горимд ажиллах боллоо.

Банкууд 2002 онд мэдээлэл, холбооны технологийн орчин үеийн дэвшилтэт технологуудыг амжилттай нэвтрүүлэн интернэт-банк, телефон-банк зэрэг шинэ үйлчилгээг үйл ажиллагаандaa нэвтрүүлж эхлээд байна.

Тайлант онд Голомт банк нь олон улсын Виза (Visa) картыг, Зоос банк нь Мастер карт (MasterCard)-ыг үйлчилгээндээ нэвтрүүлж бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүд нь иргэдийн хэрэглээнд бодитоор нэвтэрч эхэллээ.

Монголбанк 2002 оны эхнээс СЭЗЯ-тай хамтран Төрийн нэгдсэн сангийн үйл ажиллагаанд "ТЭГ" үлдэгдлийн зарчим болон төвлөрсөн төлбөр тооцооны системүүдийг туршин, төвлөрсөн төлбөрийн системийг амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр Төрийн нэгдсэн сан нь банк хоорондын төлбөр тооцоонд банкуудын нэгэн адилаар оролцох болж, төсөвт байгууллагуудын гүйлгээг түргэн шуурхай гүйцэтгэх болжээ.


Энэ оноос эхлэн Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр Банкны төлбөр тооцооны системийг боловсронгуй болгох төслийг эхэллээ. Тус төслийн хүрээнд Төв банкны нягтлан бодох бүртгэлийн систем дэх төлбөр тооцооны системийг их ба бага дүнтэйгээр нь ялгаварлан бие даасан 2 систем болгон өөрчлөх, банкуудын гаргаж буй төлбөрийн картыг нэгдсэн стандартад оруулж банк хооронд картын тооцоог гүйцэтгэх болно. Энэ зорилгоор Монгол улсад мөрдөгдөх цахим төлбөр тооцоо, цахим худалдааны зэрэг хуулийн төслийг боловсруулж хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх болно.

## 5.5. Бусад үйл ажиллагаа

### *Удирдлага зохион байгуулалт*

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2003 онд баримтлах үндсэн чиглэлийн


Зураг 41. Банк хоорондын төлбөр тооцоо



Зураг 42. Дотоодын нийт бүтээгдэхүүний эргэлт



Зураг 43. Зохион байгуулагдсан сургалт болон бусад арга хэмжээ



зорилтыг хангахын тулд "Төв банкны бие даасан байдлыг бэхжүүлэх, Монголбанкны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгах хүрээнд Монголбанкаас төрийн мөнгөний бодлогыг боловсруулах тогтолцоог боловсронгуй болгоно" гэсэн 2.7 дахь заалтын дагуу газрын бүтэц зохион байгуулалтад зарим өөрчлөлтийг оруулав.

Тайлант оны эцсийн байдлаар Монголбанк 6 газар, 9 хэлтэс, 7 алба, 1 тусгай тасаг, орон нутгийн 19 салбар, 1 төлөөлөгчийн газарт нийт 302 хүн ажиллаж байгаагийн 208 нь төв Монголбанкинд ажиллаж байна.

Төв Монголбанкинд 2002 оны эцсийн байдлаар эдийн засгийн ухааны докторын зэрэгтэй 2 (гадаадад хамгаалсан 1, дотоодод хамгаалсан 1), Их Британи, АНУ, Япон, Австрали болон Монголд эдийн засгийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан 30 (гадаадад 19, дотоодод 11) ажилтнууд ажиллаж байна.

Боловсон хүчиний бодлого нь ажилтнуудын мэргэжлийн ур чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх болон нийгмийн баталгааг (орон сууц, унааны хөнгөлөлт, эрүүл мэнд, соёл олон нийтийн арга хэмжээ) хангахад түлхүү анхаарч ирлээ.

Тус банкны төвийн нийт ажиллагсдын 49 хувь нь 21-35 насны, 29 хувь нь 36-45 насны 17.3 хувь нь 46-55 насны, 9.1 хувь нь 55-аас дээш насны боловсон хүчин байгаа бөгөөд тэдгээр ажилтнуудыг гадаад, дотоодын сургалт, семинарт системтэй хамруулснаар оюуны хөрөнгө оруулалтыг байнга хийж, боловсон хүчиний чадавхийг дээшлүүлж байна.

#### *Дотоод аудит*

Тайлант онд Монголбанкны дотоод аудитын үйл ажиллагааг дотоод аудитын олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор Монголбанкны үйл ажиллагаанд байгаа болон учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, хэмжих, үнэлэх, хянах, удирдах замаар түүнийг бууруулах, арилгахад чиглэгдсэн "Монголбанкны Дотоод аудитын дүрэм"-ийг шинээр боловсруулан гаргалаа.

Энэ нь дотоод аудитыг мэргэжлийн түвшинд явуулах чадвар бүхий ажилтны шалгуур үзүүлэлтийг тогтоон, улмаар аудит бүрийг төлөвлөж, хийх ажлын цар хүрээг тодорхойлон аудитын арга, хэлбэр, тайлагнах нөхцөл зэргийг тусгасан, эрсдэлд үндэслэсэн аудитыг явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн юм.

Түүнчлэн ОУВС-гаас дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулахад өгсөн зөвлөмжийн дагуу олон улсын аудитын жишигт нийцүүлэн дотоод аудитын урт хугацааны (2002-2006 он) хөтөлбөрийг эрсдэлийн түвшинг тодорхойлох замаар боловсруулан, аудитыг нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих болон газар дээр шалгалт хийх гэсэн 2 чиглэлээр хийж ирлээ.

Тайлант онд "Монголбанкны дотоод аудитын дүрэм", хянан шалгагчдын гарын авлага болон дээрх хөтөлбөрийн дагуу аудитыг эрсдэл ихтэй газарт голлон чиглүүлэн Монголбанкны 6 газар, орон нутаг дахь 19 салбар, 1 төлөөлөгчийн газарт ээлжит, гэнэтийн, хэсэгчилсэн болон мэдээлэл, санал, гомдлын мөрөөр нийт 40 удаа шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг цаг тухайд нь авч ирлээ.

Мөн Монголбанкны газар, хэлтэс, албадаас мэдээ, мэдээллийг тухай бүр, орон нутаг дахь салбараас үйл ажиллагааных нь тайланг улирал бүр авч, дүгнэлт хийн зайнаас хяналт тавьж ажиллав.

Түүнчлэн Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Монголбанкны орон нутаг дахь салбар, төлөөлөгчийн газрын байршил, бүтцийг боловсронгуй болгох үүднээс холбогдох тооцоо, судалгаа хийн нэгтгэж, санал боловсруулан Монголбанкны удирдлагад танилцуулаад байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2002 онд баримтлах үндсэн чиглэлд тусгагдсан "Монголбанкны төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэчлэлийг эрчимжүүлэх ажлыг зарим газар, хэлтэс, албадын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн турших" ажлын хүрээнд төлөвлөгөө боловсруулж, улмаар турших нэгжийг сонгон, тэдний бүтээгдэхүүн, өртөг тодорхойлох ажлыг зохион байгуулахад хамтарч оролцов.

Тайлант онд Монголбанкны 2001 оны санхүүгийн тайланд "Эрнест энд Янг Монгол Аудит" компаниар аудит хийлгэн баталгаажуулах ажлыг зохион байгуулж, зөвлөмжийн дагуу холбогдох газар, хэлтэстэй хамтран ажиллав.

#### *Бэлэн мөнгөний хангамт*

2002 онд Монголбанкаас мөнгөн тэмдэгтийн холбогдолтой дараахь үйл ажиллагааг эрхлэн явуулав. Үүнд:

10000-тын дэвсгэртийг шинээр Германы Гийзеке Дэврийнт (Giesecke & Devrient) пүүст захиалж хийлгэн 2002 оны 3 дугаар сараас гүйлгээнд гаргаж эхлэв. 10, 20-тын дэвсгэртийг Английн Дe La Ru (De La Ru) пүүст дахин нэмж хэвлүүлэн, 2002 оны 6 дугаар сараас гүйлгээнд гаргалаа.

Гүйлгээн дэх дэвсгэртийн чанар амархан мууддаг учир дээрх шинээр нэмж захиалсан дэвсгэртүүдийг хир, бохирдолтоос хамгаалах тусгай бодисоор бэхжүүлж, хэд хэдэн нууцлалын онцлог, хийцийг нэмж оруулсан юм. Тухайлбал, шинэ 10000-тын дэвсгэртэд нууцлалын хамгийн сүүлийн үеийн технологи болох голограм хийцийг оруулж тухайн дэвсгэртийн хамгаалалтыг сайжрууллаа. 2002 онд 5000-тын дэвсгэртийг нэмж хэвлүүлэх гэрээг тендерийн үндсэн дээр Германы пүүстэй байгууллаа.

Түүнчлэн, аймаг орон нутгийг салбар банкуудаараа дамжуулж эдийн засгийг бэлэн мөнгө буюу хэрэгцээт дэвсгэртүүдээр хангах, муудсан мөнгийг татаж устгах, давтан тоолж, хянах ажиллагааг тогтмол явуулж ирлээ.

Тайлант онд Монголбанк 51 тэрбум төгрөгийн муудсан мөнгийг гүйлгээнээс татан авч устгасан бөгөөд 66 тэрбум төгрөгийн шинэ дэвсгэргийг гүйлгээнд гаргасан байна. Зоосон төгрөгийн эргэлт нэлээд удаан /гүйлгээнд гаргасан хэмжээ бага/ байсан бөгөөд энэ нь зоосыг хэрэглэх орчин бүрдээгүйтэй холбоотой юм.

Том дэвсгэрт нийт гүйлгээн дэх бэлэн мөнгөний ихэнх хувийг, жижиг болон дунд дэвсгэрт багахувийг эзэлж байгаа нь бэлэн бусаар их хэмжээний төлбөр тооцоо хийгдэж байгаатай холбоотой юм.

#### *Монголбанкны дэргэдэх Сургалтын төв*

Монголбанкны дэргэдэх Банкны Сургалтын төв (БСТ) нь 2002 онд сургалт, семинарыг тогтмол явуулж ирсэн бөгөөд сургалтын чанар, өгөөжийг дээшлүүлэх, улмаар сургалтын цар хүрээг өргөжүүлэхэд анхаарлаа чиглүүлэн ажиллалаа. Банкуудын саналыг үндэслэн 2002 оны сургалтын хөтөлбөр болон төлөвлөгөөг хамтран боловсруулж, уг хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулан явуулсны үр дүнд банкуудын сургалтад хамрагдах идэвх дээшилсэн ба тайлангийн хугацаанд 36 сэдэв бүхий 38 удаагийн сургалтад нийт 801 хүн хамрагдсан байна. Тайлант онд тус төвөөс зохион байгуулагдсан дотоод, гадаад сургалт болон бусад үйл ажиллагаанд Монголбанк болон арилжааны банкуудаас давхардсан тоогоор нийтдээ 1113 хүн хамрагдан оролцсон байна.

Банкны ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2002 онд банк санхүүгийн англи хэлний дамжааг 3 удаа зохион байгуулж нийт 42 хүн оролцсоноос 31 хүн амжилттай төгсөв. 2003 онд англи хэлний дамжааг үргэлжлүүлэн зохион байгуулах ба банкуудын хүсэлтийн дагуу банкны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны дамжааг хичээллүүлэхээр бэлтгэл ажлаа хангаад байна. БСТ нь 2002 онд Боловсролын улсын хяналтын газрын аттестатчлалд 100 хувийн амжилт үзүүлж цаашид сургалт явуулах эрхээ баталгаажууллаа.

Тайлант онд гадаад сургалтад банкуудаас 49 хүн хамрагдан оролцов. 2002 оны 2 дугаар сард Швед улсын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА)-ийн 2 шинжээч томилогдон ирж өнгөрсөн хугацаанд ОУХА-аас хэрэгжүүлж буй Монголын банкуудын ажилтнуудыг сургах төслийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөв. Мөн ОУХА-н удирдах хүмүүс 9 дүгээр сард ирж, төсөл амжилттай хэрэгжсэнийг тэмдэглээд, цаашид төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр харилцан тохиролцоод байна. Үүнээс гадна 2003 оноос Монголын банкуудын ажилтнуудыг сургах 250 мянган америк долларын өртөг бүхий төслийг хамтран хэрэгжүүлэхээр Европын Сэргээн босголт, Хөгжлийн банктай урьдчилсан байдлаар тохиролцлоо.

Банкуудын үйл ажиллагааг сурталчилах, банкны ажилтнуудын мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг олон нийтэд таниулах, ажилтнуудын хооронд ажлын арга туршилага, мэдээллийг харилцан солицдох, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, банкны ажилтнуудын ажиллах идэвх санаачлагыг дээшлүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж явууллаа.

#### *Гадаад хамтын ажиллагаа*

Тайлант онд Монголбанк олон улсын банк, санхүүгийн байгуулагуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх чиглэлийг барьж ажиллав.

Монголбанк гадаад харилцаагаа өргөжүүлж, гадаадын олон банктай харилцагчийн үйл ажиллагаа явуулах боллоо. Гадаад үйл ажиллагааг идэвхтэй явуулах үүднээс санхүүгийн зах зээлийн том төвүүдийн нэг болох Лондон хотноо Монголбанкны төлөөлөгчийн газрыг нээв. (Хаяг:Лондон дахь Монголбанкны төлөөлөгчийн газар, Монголын элчин сайдын яам, 8 Kessington Court, London W8 5DL, tel:0044-7799641868)

Монголбанк олон улсад нэр хүнд бүхий Стандарт энд Пүүрс (Standard&Poor's) байгууллагаар Монгол улсын зэрэглэлийг тогтоолгох ажилд Засгийн газартай хамтран ажиллав.

Зүүн өмнөд Азийн төв банкны холбооны Ерөнхийлөгчдийн 37 дугаар уулзалтыг 2002 онд анх удаа Улаанбаатар хотод зохион байгуулж, "Даяарчлалын орчны санхүү, эдийн засгийн хөгжлийг дэмжих" сэдвээр хэлэлцүүлэг явуулав. Түүнчлэн Зүүн өмнөд Азийн төв банкны холбооны экспертуудийн уулзалт, Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Олон улсын Эдийн засгийн хамтын ажиллагааны банкны ээлжит хурлуудын бэлтгэл ажлыг хангаж, Улаанбаатар хотод амжилттай зохион байгууллаа.

Монголбанк мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг олон улсын үйл ажиллагаанд идэвхтэй оролцов. 2002 онд Монгол улс Ази номхон далайн орнуудын мөнгө угаахтай тэмцэх холбоонд ажиглагчаар элслээ.

Банк санхүүгийн үйл ажиллагааг олон улсын түвшинд сурталчилах зорилгоор Лондонгийн олон улсын (LITV) телевиз, Интернэйшнл Пресс Сервис (International Press Service), Томсон Финанс Паблишин Ази Пасифик (Thomson Financial Publishing Asia Pacific), Сентрал Банкин Журнал (Central Banking Journal), Евробизнес (Eurobusiness), АНУ Түдэй (USA Today) зэрэг олон улсад нэр хүнд бүхий сэтгүүл, мэдээллийн агентлагуудад ярилцлага өгөх, мэдээлэл бэлтгэж хэвлүүлэх, Зүүн өмнөд Азийн төв банкуудын холбооны дэргэдэх сургалт судалгааны төвөөс гаргадаг сэтгүүлд Монголбанкны үйл ажиллагааны талаархи мэдээллийг тогтмол нийтлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулав.

## 6. БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛ

Тайлант онд Монголбанк банкны тогтолцооны тогтвортой байдлыг бэхжүүлэх, банкны хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилтоо үргэлжлүүлэх бодлогыг тууштай баримтлан ажиллалаа.

Монголбанк эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хүрээнд батлан гаргасан Иргэний хуулийн шинэчлэлд идэвхтэй оролцож, түүнд банкны хууль тогтоомжийн үндсийг дорвitoй тусгуулах талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар энэ салбарын хууль тогтоомжийн цаашдын хөгжилд өргөн боломжийг нээж өглөө. Түүнчлэн энэ хуульд банкны хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэлийг барьж ажиллав.

### Нэг. Иргэний хуулийн хүрээнд

2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилж эхэлсэн Иргэний хуульд банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын хувьд, онцгой чухал үүрэг бүхий дараахь бүлэг, дэд бүлэг, зүйл, хэсэг, заалт оржээ:

- 1.1. Хуулийн Мөнгөн төлбөрийн үүрэг (16 дугаар бүлгийн 2 дугаар дэд бүлэг), Санхүүгийн түрээсийн гэрээ (26 дугаар бүлэг), Төлбөр тооцоо (44 дүгээр бүлгийн 1 дүгээр дэд хэсэг), Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох ажиллагаа (2 дугаар дэд бүлэг), Мөнгөн хадгаламж (3 дугаар дэд бүлэг), Банкны баталгаа (4 дүгээр дэд бүлэг)-ны талаархи эрх зүйн үндсэн ойлголт,
- 1.2. Монголын хууль тогтоомжид урьд байгаагүй санхүүгийн түрээс (312), опцион (269), франчайз (333-338)-ийн гэрээ, аккредитив (450), инкасс (450)-ын төлбөр тооцоо болон банкны баталгаа (457), үүргийн гүйцэтгэлийг хангах нэгэн арга болох фидуциар (253), шаардах эрхээ шилжүүлэх (123), өр шилжих (124),
- 1.3. Өмнө үйлчилж байсан Иргэний хуулиар ББСБ-д зөвхөн зээлийн үйл ажиллагааг эрхлэхийг зөвшөөрдөг байсан бол түүнээс гадна банкны үйл ажиллагааны уламжлалт хэлбэр болох төлбөр тооцоо (445), мөнгөн хадгаламж (454)-ийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд гэсэн ойлголтыг шинээр оруулснаар эдгээр харилцаанд оролцогчдын хүрээг өргөтгөн, санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөнийг хөхүүлэхэд түлхэц болсон гэж үзэж байна.
- 1.4. Зээлийн гэрээнд талууд харилцан тохиролцсон бол зээлийн барьцааны зүйлийг зээлийн гэрээний хугацаа дуусмагц, захиран зарцуулах эрхтэй (453.2.) байхаар тусгасан нь 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн Монгол Улсын хуулиар орсон нэмэлт, өөрчлөлтийг баталгаажуулав.

- 1.5. Төлбөр тооцоо, мөнгөн хадгаламж, банкны зээлийн үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулах тухай заалтыг оруулав. (445.8; 451.3; 454.7)

**Хоёр. Иргэний хуульд банкны тухай хууль тогтоомжийг  
нийцүүлэх ажлын хүрээнд**

- 2.1. Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "батлан даалт", 16 дугаар зүйлийн 1,2,3 дахь хэсэг, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн 2 дахь заалтын "батлан даалтын" гэсний урд "баталгаа," гэж тус тус нэмж, 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь өгүүлбэрийг "Банк татан буулгах, түүнтэй холбогдон үүсэх нэхэмжлэлийн шаардлагыг хангахад Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасныг баримтална" гэж өөрчилж, мөн хуулийн 45 дугаар зүйлийг хүчингүй болгов.
- 2.2. Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2002.7.4), Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль (2002.7.4)-аар эдгээр хуулийн Иргэний хуулийн ишлэл бүхий зүйл, хэсэг, заалтын дугаар болон "Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль"-ийн нэрийг "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль" болгон тус тус өөрчилжээ.

**Гурав. Банк, банк бус санхүүгийн үйл ажиллагааны  
тухай хууль тогтоомжийн хүрээнд**

- 3.1. Банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад "энэ заалт нь хууль тогтоомжид заасан хугацаанд татварын өрөө барагдуулаагүй татвар төлөгчийн харилцагч банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөөс татварын өрийг үл маргах журмаар гаргуулахад хамаарахгүй" гэсэн өгүүлбэрийг Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль (2002.5.2)-иар нэмжээ.
- 3.2. Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь заалт буюу банк газрын зах зээлд ажиллахыг хориглож байсан заалтыг хүчингүй болголоо.
- 3.3. Эрдэнэсийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2002.12.5)-иар хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалтад нэмэлт оруулж үнэт металлыг зөвхөн гадаадад төдийгүй дотоодод ч цэвэршүүлэх эрх зүйн орчныг бий болгов. Үүнээс гадна, найруулгын зарим өөрчлөлт оруулав.
- 3.4. 2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль батлагдав. Сүүлийн жилүүдэд олноор байгууллагдах болсон банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн байдлыг

тодорхой болгох, энэ төрлийн тусгай зөвшөөрлийн процедурыг хүнд сурталгүй, энгийн болгох, банкны үйлчилгээний төрлийг хөдөө орон нутагт шуурхай хүргэх, санхүүгийн зах зээлд тэдний эзлэх байр суурийг зөв тодорхойлоход онцгой ач холбогдолтой болов.

Энэ хуульд зээл олгох, санхүүгийн түрээс, факторинг, төлбөрийн баталгаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын болон итгэлцлийн үйлчилгээ, гадаад валютын арилжаа, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг ажил үйлчилгээг банк бус санхүүгийн үйл ажиллагаа гэж тодорхойлж, бусдаас харилцах, хадгаламж хэлбэрээр эх үүсвэр татахгүйгээр, дурдсан үйлчилгээг эрхлэх этгээдэд Монголбанк зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, заавал мөрдөж ажиллах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоож байхаар хуульчилжээ.

Энэ хуультай уялдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны төрөлд "банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх" гэсэн заалт нэмжээ.

3.5. Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль (2002.12.12)-иар Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг зохицуулсан Зургадугаар бүлэг нэмэв. Энэ бүлэгт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд тавих шаардлага, өөрийн хөрөнгийн бүтцийг тодорхойлж, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд мөрдөх зохистой харьцааны үзүүлэлт, эрсдэлийн сангийн доод хэмжээг тодорхойлох журмыг Төв банк тогтоож байхаар оруулсан байна.

#### **Дөрөв. Банкинд хамаарах бусад хууль тогтоомж**

4.1. Газрын тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр) батлагдсан нь иргэдийн газар эзэмших эрх, түүний хэрэгжих нөхцөлийг баталгаажуулах, газрыг аж ахуйн эргэлтэд оруулах сонирхлыг нэмэгдүүлэх, газрыг зохистой ашиглах, хамгаалах эдийн засгийн эрх зүйн орчинг бий болгох, зах зээлийн харилцааг бэхжүүлэх дорвитой алхам болов.

4.2. Хүн амын орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль (2002 оны 12 дугаар сарын 5-ны өдөр)-иар хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Гадаад валютаар олсон орлогыг тооцохдоо уг валютыг банкинд худалдах буюу Монголбанкнаас тогтоосон ханшаар төгрөгт шилжүүлнэ" гэснийг "Гадаад валютаар олсон орлогыг төгрөгт шилжүүлэхдээ уг валютыг банкинд худалдах тухайн өдрийн Монголбанкнаас тогтоосон ханшийг үндэслэнэ" гэж өөрчилжээ. Мөн

хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "2003" гэснийг "2005" болгон өөрчилснөөр, хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, зээлийн болон хадгаламжийн хүүгийн орлогод албан татвар үл ногдуулах заалтын үйлчлэх хугацааг сунгалаа.

- 4.3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр)-иар иргэн, хуулийн этгээдээс захиргааны актыг хууль бус гэж үзэн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шийдвэрлэх талаарх харилцааг зохицуулах болов. Энэ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал шийдвэр, улсын байцаагч нарын тавьсан актын хариуцлагыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.
- 4.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2002 оны 12 дугаар сарын 12-ны өдөр) батлагджээ.

Энэ хуулиар үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргах, бүртгэх, хадгалах, худалдах, арилжих, түүгээр гэрчлэгдсэн өмчлөх эрхийг шилжүүлэх, үнэт цаасны талаарх мэдээллийг хөрөнгө оруулагчдад хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг зохицуулахаар тусгажээ.

Банкинд үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг Үнэт цаасны хороо Монголбанктай зөвшилцөн шийдвэрлэж байх (20.3.), Үнэт цаасны хорооны гишүүдэд Монголбанкны Ерөнхийлөгч нэг нэр дэвшигүүлэх эрхтэй (32.1.) байхаар хуульчлав.

#### **Тав. Монголбанкнаас гаргасан эрх зүйн актын тухай**

2002 онд Монголбанк 24 журам, заавар, аргачлал гаргаж, тэдгээр журам зааварт нэмэлт, өөрчлөлт оруулав.

Тайлант онд Монголбанкны эрх зүйн актыг боловсронгуй болгох чиглэлээр банкны хяналт шалгалт, төлбөр тооцоо гүйцэтгэх, валютын зохицуулалтын асуудалд түлхүү анхаарал тавьж ирлээ.

## 7. МОНГОЛБАНКНЫ БОДЛОГО БА ТЕХНИКИЙН ШИНЖ ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУРААНГУЙ

сар	өдөр	тушаал	нэр	агуулга
2	1	58	Зөвшөөрөл олгох тухай	Монгол пасифик ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
2	1	59	Зөвшөөрөл олгох тухай	Тодсанаа ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
2	6	71	Журам батлах тухай	Монголбанкны улсын байцаагчийн эрх зүйн байдлын тухай журам-аар Монголбанкны улсын байцаагчийн эрх олгох, улсын байцаагчийн бүрэн эрх, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, тэдгээрт ногдуулах арга хэмжээ зэрэг харилцааг зохицуулахаар тусгажээ.
2	7	74	Салбар байгуулах зөвшөөрөл олгох тухай	Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт ХААН банкны салбар байгуулах зөвшөөрөл олгосон.
2	12	84	Дотоодын банкуудтай валютын арилжааны хэлцэл, хадгаламжийн гэрээ байгуулах тухай журам-ыг батлах тухай	Монголбанкнаас дотоодын банкуудтай гадаад валютын арилжааны хэлцэл хийх, валютын хадгаламж харилцан байгуулах гэрээ байгуулах талаарх харилцааг энэ журмаар зохицуулна.
2	12	87	Салбар байгуулах зөвшөөрөл олгох тухай	Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын нутагт Зоос банкны салбар нээх зөвшөөрөл олгосон.
2	25	90	Зөвшөөрөл олгох тухай	Дархан-цалам ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
2	25	91	Зөвшөөрөл олгох тухай	Гурван бар кредит ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
2	26	98	Зөвшөөрөл олгох тухай	Бат энд инвест ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
2	26	99	Зөвшөөрөл олгох тухай	Их жас ХХК-д ББСБ байгуулж, зээл олгох, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
3	8	117	Зөвшөөрөл олгох тухай	Евро-бат ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
3	14	127	Зөвшөөрөл олгох тухай	Актив инвест ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
3	19	133	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Төв банкны үнэт цаасны журам-ын 2.2, 2.3, 3.2, 3.4, 3.9, 3.10, 3.13, 3.18 заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, ТБҮЦ-ны төлөгдөх хугацаа дуустал үлдэж буй хоногт тооцогдсон хямдруулалтын хувь хэмжээг тооцох томъёог өөрчилж, 3.19 заалт нэмж оруулав.
3	19	135	Зөвшөөрөл олгох тухай	Монгол лизинг ХХК-д ББСБ байгуулж, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
3	27	147	Зөвшөөрөл олгох тухай	Хануй сан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
4	10	178	Салбар байгуулах зөвшөөрөл олгох тухай	Дархан-Уул аймагт Голомт банкны салбар байгуулах зөвшөөрөл олгосон.
4	11	181	Зөвшөөрөл олгох тухай	Даймонд Калла ХХК-д ББСБ байгуулж, зээл олгох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
4	17	188	Нэмэлт зөвшөөрөл олгох тухай	Мон-Арвиссан ХХК-д гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
4	18	192	Зөвшөөрөл олгох тухай	Ассетс инвест ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.

4	18	193	Зөвшөөрөл олгох тухай	Эйч Кей Би кредит ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
4	19	195	Зөвшөөрөл олгох тухай	Альфа кредит ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
4	23	198	Зөвшөөрөл олгох тухай	Кредит солюшн ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
4	24	201/55	Журам батлах тухай	Монголбанкны зээлийн мэдээллийн санд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс мэдээлэл өгөх журам-ыг баталснаар банк, ББСБ-ын зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор тэдгээрийн зээлдэгч, батлан даалт гаргуулагч, аккредитив нээлгэгч иргэний талаархи мэдээллийг ИБМУТ-өөс Монголбанкинд өгөх асуудлыг зохицуулах болов.
5	6	210	Зөвшөөрөл олгох тухай	Нью Ази ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	6	212	Зөвшөөрөл олгох тухай	Монголтраст финком ХХК-д ББСБ байгуулж, факторингийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгожээ.
5	6	220	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журамын 4.2, 6.4 хэсэг, 6.5 дахь хэсгийн 8 дахь заалт, 6.1 хэсэг, 6.3 дахь хэсгийн 4 дэх заалтад нэмэлт, өөрчлөлт орууулж, журмын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсэг болон 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийг хүчингүй болгов.
5	9	229	Зөвшөөрөл олгох тухай	Фин-инвест ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	9	230	Зөвшөөрөл олгох тухай	Хишиг их сан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	10	231	Интер банкинд гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн зөвшөөрөл олгох тухай	Тус банкинд гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн зөвшөөрөл олгов.
5	16	246	Зөвшөөрөл олгох тухай	Төгс эдлэл ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	16	247	Зөвшөөрөл олгох тухай	Интер финанс ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
5	16	248	Зөвшөөрөл олгох тухай	Зуун функт ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	17	249	Зөвшөөрөл олгох тухай	Төгс бүрэн ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	17	252	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Улсын байцаагчийн эрх зүйн байдлын тухай журамын 5, 6 дахь хэсэг болон “Шалгалтын ажлын тайлан”, “Улсын байцаагчийн үрэгдсэн хэвлэмэл хуудас, тэмдгийн тухай мэдээ”-г энэ журмын 2, 3 дугаар хавсралт болгон баталжээ.
5	31	266	Зөвшөөрөл олгох тухай	Дэвж сан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
5	31	267	Зөвшөөрөл олгох тухай	Чинбаа инвест ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
5	31	268	Зөвшөөрөл олгох тухай	Энх сар инвест ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.

6	5	277	Зөвшөөрөл олгох тухай	АБТС ХХК-д ББСБ байгуулж, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
6	5	278	Зөвшөөрөл олгох тухай	Инвест кредит ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн, бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
6	5	279	Капитрон банкинд зарим үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай	Тус банкинд Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд батлан даалт гаргах, үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн, санхүүгийн түрээсийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосон.
6	13	294	Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн түр журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Журмын В Актив гэсэн хэсгийн В-3 “Гадаад тооцооны бүртгэл” бүлгийн 3.5 “Гадаад валютын ханшийн тэгшигтгэл” хэсэг, В Актив гэсэн хэсгийн В-2 “Үнэт металл” бүлгийн 2.2.7 “Үнэт металлын дахин үнэлгээ” хэсэг, С Пассив гэсэн хэсгийн С-6 “Өөрийн хөрөнгө” бүлгийн 6.2.4 “дахин үнэлгээний сангууд” хэсэгт өөрчлөлт оруулав.
6	20	301	Зөвшөөрөл олгох тухай	Күйк Финанс ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
6	28	309	Зөвшөөрөл олгох тухай	Богд хааны ордон музей-д валют солих цэгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
7	1	314	Зөвшөөрөл олгох тухай	Сан стандарт ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
7	8	337	Нэмэлт зөвшөөрөл олгох тухай	Инвесском ХХК-д мөнгөн гүйвуулгын ажил, үйлчилгээ, гадаад валют бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдан авах, худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
7	8	339	Зөвшөөрөл олгох тухай	Итгэл сан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
7	18	357	Зөвшөөрөл олгох тухай	Буянт Ухаа сан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
7	18	359	Зөвшөөрөл олгох тухай	Талын Монгол капитал ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
8	12	383	Зөвшөөрөл олгох тухай	Ас-Өөдөө ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
8	19	392	Монголбанкны Нягтлан бодох бүртгэлийн журам-ыг хэсэгчлэн батлах тухай	Монголбанкны Ерөнхийлögчийн 1998.5.25-ны 202 тоот тушаалаар батлагдсан “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн түр журам”-ын В-3 “Үнэт металл” болон В-3 “Гадаад тооцооны бүртгэл” бүлгийг нэгтгэж “гадаад тооцооны бүртгэл” гэж 1998.11.15-ны өдрийн 451 тоот тушаалаар батлагдсан “Монголбанк ны тэнцлийн гадуурхи дансны төлөвлөгөө”-г шинэчлэн батлав.
9	24	456	Зөвшөөрөл олгох тухай	Кредит лизинг ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
9	25	463	Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн түр журамд өөрчлөлт оруулах тухай	“Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн түр журамд өөрчлөлт оруулах тухай” Журмын Гадаад тооцооны бүртгэл” бүлгийн В-2.4.3 “Гадаад валютын своп арилжаа” дэд бүлэг, “В-2.4.4 “Гадаад валютын форвард арилжаа” дэд бүлэг, В-2.4.5 “Гадаад валютын опшин арилжаа” дэд бүлгээс холбогдох хасалт хийсэн.

10	2	477/292	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам-ын I бүлгийн 1 дэх хэсэг, II бүлгийн 15 дахь хэсэг, III бүлгийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт, III бүлгийн 7 дахь хэсгийг өөрчилж IV бүлгийн 3 дахь хэсэг, IV бүлгийн 4 дэх хэсэгт нэмэлт оруулав.
10	2	479	Олон улсын банк хоорондын санхүүгийн цахилгаан сүлжээгээр төлбөр тооцоо хийх журам- батлах тухай	Энэхүү журмаар Монголбанкаас олон улсын банк хоорондын санхүүгийн цахилгаан сүлжээнд холбогдон ашиглаж байгаа компьютер бусад тоног төхөөрөмж, тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангах, сүлжээнд мэдээлэл оруулах, хянах, зөвшөөрөл олгох, хүлээн авах, дамжуулах мэдээлэлтэй ажиллах үйл ажиллагааны дараалал, программ хангамж болон мэдээллийн нуушлал, аюулгүй байдлыг хангах, ажилтнуудын эрх үүрэг, хариуцлагыг тогтоохтой холбогdon үүсэх харилцааг зохицуулах болно.
10	3	480	ББСБ-ын зөвшөөрлийг хүчингүй болгох тухай	Эйч Кей Би кредит ББСБ-ын зөвшөөрлийг хүчингүй болгосон.
10	7	486	Эрэл банкинд үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах зөвшөөрөл олгох тухай	Банкинд зөвшөөрөл нэмж олгосон.
10	28	512	Хас банкинд зарим үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай	Тус банкинд гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн зөвшөөрөл олгосон.
11	1	522	Зөвшөөрөл олгох тухай	Өрнөх инвест сан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
11	8	531	Зөвшөөрөл олгох тухай	Ти энд Ди финанс ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон.
11	8	535	Зөвшөөрөл олгох тухай	Жавхлант Алдархаан ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
11	25	566	Журам батлах тухай	Банк, ББСБ-д нэгдсэн шалгалт хийх үйл ажиллагааг зохицуулах журам батлагдсанаар банк, ББСБ-ас Банкны тухай хууль тогтоомж, тэдгээрийн үйл ажиллагаандaa мөрдөх эрх зүйн баримтын хэрэгжилтийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн анхан шатны баримтад үндэслэн банк, ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээр нь нэгдсэн шалгалт хийх үйл ажиллагааг зохицуулах болов.
12	13	594	Банк хоорондын цахим сүлжээний хэрэглэгчийн ажлын байрны аюулгүй байдлын журам батлах тухай	Энэхүү журмын зорилго нь “Төв банк (Монголбанк)-ны тухай” хуулийн 20 дугаар зүйлд заасан банк хоорондын төлбөр тооцоог түргэн шуурхай, үнэн зөв, найдвартай явуулах, банк хоорондын цахим сүлжээний аюулгүй байдлыг хангахад оршино.
12	19	600	Аргачлал батлах тухай	Банкны байгууллагуудад Зохистой удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлэх аргачлал” батлан гаргав. Банк нь ААН, байгууллага, иргэдийг шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрээр хангаж, тэдгээрт санхүүгийн үндсэн үйлчилгээ үзүүлэх мөн түүнчлэн төлбөр тооцооны системд оролцох боломжоор хангадгаараа нийт эдийн засагт чухал үүрэгтэй тул банкны байгууллагуудад зохистой удирдлагын зарчмуудыг хэрэгжүүлэх асуудал нэн чухал байгааг харгалzan энэхүү аргачлалыг баталжээ.
12	24	612	Үлгэрчилсэн загвар батлах тухай	Банкны дүрмийн үлгэрчилсэн загварыг батлан гаргав.

12	25	617	Зөвшөөрөл олгох тухай	Номин карт ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
12	25	618	Зөвшөөрөл олгох тухай	Хатан сүлд ХХК-д ББСБ байгуулж, зээл, гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
12	25	619	Зөвшөөрөл олгох тухай	Туул кредит ХХК-д ББСБ байгуулж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгов.
12	30	629	Журам шинэчлэн батлах тухай	Монголбанкны кассын ажиллагааны журам болон “Монголбанкны бэлэн мөнгө тоолох, хянах заавар”-ыг батлав. Монголбанкны банкны тухай хууль тогтоомжийн дагуу банк, иргэд, хуулийн этгээдийн бэлэн мөнгөний харилцааг зохицуулах, бэлэн мөнгөний гүйлгээг явуулах, мөнгөн тэмдэгтийг хүлээн авах, хүлээлгэн өгөх, бүртгэх, хадгалах ажиллагааг явуулахад “Монголбанкны кассын ажиллагааны журам”-ыг мөрдөнө. Монголбанк нь банк, хуулийн этгээд, иргэдээс цүнх, шуудай, боодлоор хүлээн авсан бэлэн мөнгөний чанар, тоо, ширхэг, дүнг баталгаажуулах зорилгоор ширхэгчлэн тоолж, шалган, хяналт тавихад “Монголбанкны бэлэн мөнгө тоолох, хянах заавар”-ыг мөрдөнө.
12	31	633	Журамд өөрчлөлт оруулах тухай	Дотоодын банкуудтай валютын арилжааны хэлцэл, хадгаламжийн тухай журмын 4.6 дахь заалтад өөрчлөлт оруулсан.



## АУДИТОРЫН ТАЙЛАН

### Монголбанкинд /Төв банк/-нд

Бид Монголбанкны санхүүгийн тайланда аудит хийлээ.

#### Захирлуудын зөвлөл болон аудиторуудын хүлээх үүрэг

Монголбанкны Захирлуудын Зөвлөл нь санхүүгийн тайлан бэлтгэх үүргийг хүлээнэ. Бидний хүлээх үүрэг хариуцлагын хувьд хийсэн аудит, бэлтгэсэн санхүүгийн тайлангийнхаа үндсэн дээр бие даасан үзэл бодлоо илэрхийлэх явдал юм.

Монголбанкны санхүүгийн тайлан нь Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Захирлуудын Зөвлөл нь Монголбанкны 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан, мөн энэ хугацааны ашиг алдагдлыг үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Монголбанкны Захирлуудын Зөвлөл нь тодруулга 3, 4-т дурьдсан шаардлагыг хангасан санхүүгийн тайлан болон Монголбанкны санхүүгийн байдлыг ямар ч үед үнэн зөвөөр тусгасан нягтлан бodoх бүртгэл хөтөлсөн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй. Түүнчлэн Монголбанкны активын хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, хөрөнгийн дутагдал, шамшигдал болон бусад хэвийн бус үйл ажиллагааг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зохистой алхмуудыг авч хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

Монголбанкны Захирлуудын Зөвлөл нь Төв банкны санхүүгийн тайланг бэлтгэн гаргахдаа үнэн зөв тооцоо, дүн шинжилгээгээр баталгаажсан зүй зохистой нягтлан бodoх бүртгэлийн бодлого баримталсныг баталж байна. Монголбанкны санхүүгийн тайланг бэлтгэхэд хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн стандартуудыг баримталсан бөгөөд эдгээр стандартууд нь энэхүү санхүүгийн тайлангийн тодотголуудад дурьдсан бүртгэлийн үндэс болсон.

## Дүгнэлт гаргах үндэслэл

Бид аудитыг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын хуулийн хүрээнд Олон Улсын Аудитын стандартын дагуу хийсэн болно. Аудит нь санхүүгийн тайландаа тусгасан тоон үзүүлэлт, мэдээлийн нотолгоог түүврийн аргаар хийсэн шалгалтуудыг багтаанаа. Түүнчлэн санхүүгийн тайлангаа бэлтгэх явцад аудит нь Захирлуудын Зөвлөлөөс гаргасан чухал тооцоолол, дүн шинжилгээнд өгсөн үнэлэлт болон бүртгэлийн бодлого нь Монголбанкны нөхцөл байдалд нийцэж, тогтвортой, бүрэн хэмжээгээр хэрэгжиж байгаа эсэхэд өгсөн үнэлэлтийг багтаасан болно.

Бид аудитыг санхүүгийн тайландаа алваа алдаа дутагдал, бусад хэвийн бус үйл ажиллагаанаас шалтгаалсан буруу ташаа зүйл байхгүй гэдэгт итгэлтэй байх үүднээс бүх шаардлагатай тайлбар, мэдээлийг авч, төлөвлөн гүйцэтгэлээ. Дүгнэлтийг бүрдүүлэхдээ тодотгол 3, 4-т тусгагдсан үндэслэл дээр тулгуурласан санхүүгийн тайландаа бүх мэдээллийг хангалттай толилуулсан гэдгийг бид үнэлсэн болно.

## Дүгнэлт

Бидний дүгнэлтээр 3-аас 32 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайлан нь Монголбанкны 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн хөрөнгийн урсгалын тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлж, бүх талаар үнэн зөв толилуулсан байна.



2003 оны 4 дүгээр сарын 3

Улаанбаатар

Монгол улс

## МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

### МОНГОЛБАНКНЫ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЙЛАН

(2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	Тодотгол	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
ХҮҮ болон түүнтэй адилтгах орлого	<b>5</b>	<b>7,541</b>	7,957
ХҮҮгийн зардал болон түүнтэй адилтгах шимтгэл	<b>6</b>	<b>(5,313)</b>	(4,320)
 <b>Цэвэр хүүгийн орлого</b>		<b>2,228</b>	3,637
Мөнгөжсөн алтны арилжаанаас олсон цэвэр ашиг		<b>11,507</b>	4,022
Гадаад валютын арилжаанаас олсон цэвэр ашиг		<b>12,822</b>	1,951
Үйл ажиллагааны бусад орлого		<b>345</b>	424
Онцгой орлого		-	9,959
 <b>Хүүгийн бус цэвэр орлого</b>		<b>24,674</b>	16,356
 <b>Нийт орлого</b>		<b>26,902</b>	19,993
Нөөцийн сангийн хөдөлгөөн	<b>7</b>	<b>2</b>	29
Захиргааны зардал	<b>8</b>	<b>(2,828)</b>	(2,206)
Үйл ажиллагааны бусад зардал	<b>9</b>	<b>(2,314)</b>	(3,862)
 <b>Жилийн ашиг</b>		<b>21,762</b>	13,954

Хавсралт тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)****ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ**

(2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

	Тодотгол	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
<b>АКТИВ</b>	<b>10</b>	<b>13,771</b>	8,067
Бэлэн мөнгө	11	<b>63,010</b>	67,828
Мөнгөжсөн алт, үнэт металл			
Гадаадын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	12	<b>51,321</b>	23,812
Гадаадын санхүүгийн байгууллагуудад			
байршуулсан хадгаламж, хөрөнгө	13	<b>253,855</b>	211,745
Дотоодын санхүүгийн байгууллагуудад			
байршуулсан хөрөнгө, олгосон урьдчилгаа	14	<b>8,326</b>	7,217
Засгийн газрын үнэт цаас	15	-	13,570
Санхүү, эдийн засгийн яаманд олгосон урьдчилгаа	16	<b>39,807</b>	38,314
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	17	<b>165</b>	165
Бусад актив	18	<b>1,100</b>	116
Үндсэн хөрөнгө	19	<b>13,524</b>	12,280
<b>НИЙТ АКТИВ</b>		<b>444,879</b>	383,114
<b>ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө		<b>134,643</b>	119,206
Төв банкны үнэт цаас	20	<b>60,810</b>	50,000
Гадаад пассив	21	<b>130,704</b>	129,345
Санхүү, эдийн засгийн яамны хадгаламж	22	<b>19,091</b>	13,306
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	23	<b>44,155</b>	26,581
Бусад пассив	24	<b>20,767</b>	7,654
<b>НИЙТ ПАССИВ</b>		<b>410,170</b>	346,092
<b>ДҮРМИЙН БОЛОН НӨӨЦИЙН САН</b>			
Дүрмийн сан	25	<b>5,000</b>	1,000
Нөөцийн сан	26	<b>29,709</b>	36,022
<b>НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>34,709</b>	37,022
<b>НИЙТ ПАССИВ БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ</b>		<b>444,879</b>	383,114

Хавсралт тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

### МОНГОЛ ХӨРӨНГИЙН ООРЧЛОЛТИЙН ТАЙЛАН

(2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	Дүрмийн Сан	Хувьарилгаагүй Ашиг сая төгрөг	Ерөнхий Нөөцийн Сан	Дахин Үнэлгээний Сан	Гадаад Валютын Дахин Үнэлгээний Сан	Нийт сая төгрөг
Тодотгоу	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг	сая төгрөг
2001 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар						
Тухайн жилийн ашиг	1,000	3,154	1,750	10,395	10,876	27,175
Ерөнхий нөөцийн санд шилжүүлсэн	-	13,954	-	-	-	13,954
Улсын төсөвт шилжүүлсэн	-	(1,654)	1,654	-	-	-
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	-	(2,500)	-	-	-	(2,500)
Дахин үнэлгээний ашиг/алдагдал	-	(3,000)	-	-	-	(3,000)
	-	-	-	1,844	(451)	1,393
	<b>1,000</b>	<b>9,954</b>	<b>3,404</b>	<b>12,239</b>	<b>10,425</b>	<b>37,022</b>
2001 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар						
Тухайн жилийн ашиг	-	21,762	-	-	-	21,762
Дүрмийн санд шилжүүлсэн	4,000	(4,000)	-	-	-	-
Ерөнхий нөөцийн санд шилжүүлсэн	-	-	14,194	(14,194)	-	-
Улсын төсөвт шилжүүлсэн	-	(10,954)	(7,423)	-	-	(18,377)
Нийгмийн хөгжлийн санд шилжүүлсэн	-	(3,000)	-	-	-	(3,000)
Худалдах боломжтой санхүүгийн хөрөнгийн	-	-	-	-	-	-
нөөцдөд шилжүүлсэн болдит бус ашиг	(7,134)	-	7,134	-	-	-
Худалдах боломжтой санхүүгийн хөрөнгийн цэвэр	-	-	(6,781)	-	-	(6,781)
алдагдал	-	-	-	-	-	3,769
Ханшийн тэгшитгэлийн зөрүү	-	-	-	-	3,769	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний цэвэр ашиг	-	-	314	-	-	314
	<b>5,000</b>	<b>6,628</b>	<b>3,404</b>	<b>19,677</b>	<b>19,677</b>	<b>34,709</b>

Хавсралт тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлантгийн салшгүй хэсэг болно.

**МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)****МӨНГӨН ХӨРӨНГИЙН УРСГАЛЫН ТАЙЛАН**

(2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	Тодотгол	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ХӨРӨНГИЙН УРСГАЛ</b>			
Тухайн жилийн ашиг	<b>21,762</b>	13,954	
Тохируулга:			
Нөөцөд байршуулсан худалдах боломжит санхүүгийн хөрөнгийн цэвэр бодит ашиг/ алдагдал	(2,698)	1,393	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний орлого	(605)	-	
Үндсэн хөрөнгийн хасалт	<b>681</b>	-	
Үндсэн хөрөнгийн хасалтын алдагдал	1	46	
Элэгдэл	<b>503</b>	308	
<b>Эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн өмнөх үеийн үйл ажиллагааны ашиг</b>	<b>19,644</b>	15,701	
Активын өсөлт/бууралт:			
Мөнгөжсөн алт, үнэт металл	<b>4,818</b>	(36,235)	
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө	(42,110)	(7,199)	
Гадаадын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	(27,509)	24,017	
Дотоодын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, олгосон урьдчилгаа	(1,109)	(4,236)	
Засгийн газрын үнэт цаас	<b>13,570</b>	(3,697)	
Санхүү, эдийн засгийн яаманд олгосон урьдчилгаа	(1,493)	(14,756)	
Аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл	(14)	(151)	
Бусад актив	<b>(970)</b>	12	
Пассивын өсөлт/бууралт:			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	<b>15,437</b>	11,812	
Төв банкны үнэт цаас	<b>10,810</b>	28,900	
Гадаад пассив	<b>1,359</b>	(3,721)	
Санхүү, эдийн засгийн яамны хадгаламж	<b>5,785</b>	(4,630)	
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	<b>17,574</b>	1,043	
Бусад пассив	<b>13,113</b>	4,365	
<b>Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн хөрөнгө</b>	<b>28,905</b>	11,225	

**МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)**

**МӨНГӨН ХӨРӨНГИЙН УРСГАЛЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**

(2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн)

	Тодотгол	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
<b>Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн хөрөнгө</b>		<b>28,905</b>	11,225
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ОРСОН МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>			
Засгийн газарт шилжүүлсэн		<b>(18,377)</b>	(2,500)
Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан		<b>(3,000)</b>	(3,000)
Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн хөрөнгө		<b>(21,377)</b>	(5,500)
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ОРСОН МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>			
Үндсэн хөрөнгийн хасагдуулгын орлого		<b>2</b>	-
Үндсэн хөрөнгө худалдан авалт		<b>(1,826)</b>	(1,676)
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн хөрөнгө</b>		<b>(1,824)</b>	(1,676)
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт		<b>5,704</b>	4,049
Өмнөх жилийн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө		<b>8,067</b>	4,018
Тайлант үсийн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	<b>28</b>	<b>13,771</b>	8,067

Хавсралт тодотголууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДОТГОЛ - 2002 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

#### 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Монголбанк нь Монгол Улсын Засгийн Газрын 1924 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн тогтоолоор Монгол Улсын Төв Банк болон байгуулагдсан ба Монгол Улсын Төв Банкны хаяг нь: Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 9.

Монголбанкны 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг Улсын Их Хурлын нэрийн өмнөөс Монголбанкны Ерөнхийлөгчид 2003 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр гардуулсан болно.

#### 2. ҮНДСЭН УЙЛ АЖИЛЛАГАА

Монголбанкны хүлээх үндсэн үүргийг Төв банк (Монголбанк)-ны тухай хуулиар зохицуулна.

Монголбанк нь үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг бөгөөд үнэт цаас арилжих, санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татан авах зэргээр хүүгийн түвшинг зохицуулж, банкны төлбөрийн чадварыг сайжруулах замаар банкны системд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч ирсэн байна.

Монголбанк нь Монгол улсын нэрийн өмнөөс төгрөг, гадаад валютын хоорондын харилцааг зохицуулдаг. Иймээс Монголбанк нь улсын алт болон гадаад валютын нөөцийг эзэмшиж, зохицуулдаг. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Монголбанк нь бусад орны төв болон арилжааны банкуудад гадаад валютын хадгаламж байршуулж, гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаас, своп болон форвардын зах зээл дээр арилжаа хийдэг.

Монголбанк нь Монгол улсын мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах онцгой эрх эдэлнэ.

#### 3. ТАЙЛАН ГАРГАХАД БАРИМТАЛСАН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Монголбанкны санхүүгийн тайлангууд нь Монголбанкны үйл ажиллагааг үнэн зөв бодитоор үзүүлэх, ашиг алдагдал, мөнгөн хөрөнгийн урсгал болон нийт олсон ашиг, алдагдал нь дор тайлбарласныг эс тооцвол төв банкинд мөрдөгдөх Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн болно.

Монголбанк нь өөрийн үндсэн үүргийн дагуу мөнгөний болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэн санхүүгийн системийг бүхэлд нь итгэл алдах байдлаас урьдчилан сэргийлэх үүдиээс хүндрэлд орсон санхүүгийн байгууллагуудад "Эцсийн зээлдүүлэгч"-ийн үүргийг гүйцэтгэж байна. Зарим тохиолдолд банкинд итгэх итгэлийг алдахгүйн тулд банкны системд бий болсон хямралт байдал сайжирсан нөхцөлд л Монголбанкны үзүүлсэн дэмжлэгийг нийтэлж байна.

### 3. ТАЙЛАН ГАРГАХАД БАРИМТАЛСАН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ (Үргэлжлэл)

Тиймээс, иймэрхүү үйл ажиллагааны санхүүгийн үр дагавар нь тухайн жилийн санхүүгийн тайланд тусдаг боловч эдгээр санхүүгийн тайлангуудад туслалцаа үзүүлсэн эсэхийг дэлгэрэнгүй тодорхойлоогүй болно. Гэхдээ Төв банк нь энэхүү ажиллагааг нууцлах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд мэдээллийг нийтэд дэлгэн үзүүлнэ.

Иймд Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартын дагуу Монголбанкны санхүүгийн тайланд ашиг алдагдлын тайлан, ялангуяа хүүний орлого, зарлага болон муу, эргэлзээтэй зээлийн сан, тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн ургалын тайлан, санхүүгийн тайлангийн тодотголыг дэлгэрэнгүйгээр үзүүлээгүй болно.

Монголбанк нь 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Нягтлан бodoх бүртгэлийн олон улсын "Санхүүгийн хэрэгсэл: Бүртгэх болон Хэмжих" 39 дүгээр стандартыг мөрдөж эхэлсэн болно. Энэхүү стандартын дагуу нягтлан бodoх бүртгэлийн түр журамд дараахь өөрчлөлтийг тусгасан болно. Үүнд:

- 2002 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар Монголбанкны эзэмшиж байсан хөрөнгө оруулалтын үнэт цаасыг НББОУ-ын 39 дүгээр стандартын дагуу бодит үнэлгээгээр нь бүртгэж эхэлсэн. Санхүүгийн хөрөнгийн бодит үнэлгээнд орсон өөрчлөлтийг тухайн хугацааны цэвэр ашиг болон алдагдалд бүртгэж байна. Гэхдээ Монголбанк нь Монгол Улсын Төв Банкны тухай хуулийн 37 дугаар зүйлийн, 3 дахь хэсэгт заасны дагуу худалдах боломжтой санхүүгийн хэрэгслийн бодит бус ашиг/алдагдлыг дахин үнэлгээний санд шилжүүлж байна. Өмнө нь хөрөнгө оруулалтын үнэт цаасыг бүртгэхдээ өртгөөс үнэлгээний бууралтыг хассан дүнгээр бүртгэж байсан. Харьцуулсан дүнг гаргаагүй болно.
- Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ түүхэн өртгийн зарчимд үндэслэсэн ба зарим активыг дахин үнэлсэн дүнгээр тусгасан. Санхүүгийн тайланд ашигласан мөнгөн тэмдэгт нь Монгол төгрөг бөгөөд түүнийг сая төгрөгөөр илэрхийлэв.
- Монголбанк нь гадаадад салбаргүй, бүхий л үйл ажиллагаагаа Монгол улсад явуулдаг хуулийн этгээд юм. Харин Монголбанк нь Англи улсын Лондон хотод төлөөлөгчийн газартай. Тиймээс тус тайландаа бизнесийн болон газар зүйн байршлын хувьд цаашдын шинжилгээ хийх шаардлагагүй.

### 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

#### (а). Хүүгийн орлого, зарлага

Хүүгийн орлого, зарлагыг хуримтлуулж тооцох зарчимд үндэслэн бүртгэсэн.

#### (б) Гадаад валют

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөжсөн актив, пассивыг тайлан тэнцэлд тухайн өдрийн ханшаар хөрвүүлж төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютаар илэрхийлэгдсэн актив, пассивыг долоо хоног бүр дахин үнэлэх нь банкны баримталж буй бодлогоор зохицуулагдах бөгөөд ханшийн тэгштгэлийн зөрүүг нөөцийн сан буюу дахин үнэлгээний санд тусгана.

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

### (б) Гадаад валют (Үргэлжлэл)

Тооцоонд ашигласан гол валютын ханш:

	2002	2001
Ам. доллар	1,125.00	1,102.00
Зээлжих тусгай эрх (ЗТЭ)	1,519.20	1,382.40

ЗТЭ - нь Олон Улсын Валютын Сангийн нягтлан бодох бүртгэлийн тооцоонд хэрэглэгддэг валютын нэгж юм.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөжсөн бус актив, пассив нь өртгөөрөө болон дахин үнэлсэн мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн болно. Тухайн актив, пассив болон актив пассивыг дахин үнэлснийг тухайн үеийн ханшаар бүртгэнэ.

Орлого, зарлагын гүйлгээг тухайн өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлэн тооцсон болно. Гадаад валютын форвард хэлцлүүд нь долоо хоног тутам зах зээлийн ханшаар бүртгэгддэг.

### (в) Зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан

ЗТУБАХСанг ерөнхий болон онцлог хүчин зүйлсийг харгалзан байгуулдаг. Банкны удирдлага нь ЗТУБАХСанг байгуулахдаа зээлдэгчийн санхүүгийн байдал, зээлийн барьцаат хөрөнгийн үнэлгээ, баталгаа, тухайн салбарын байдал, эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал болон өмнөх туршлагуудыг харгалзан үздэг. Тухайн жилд байгуулсан ЗТУБАХСанг тухайн ашиг алдагдлын данснаас байгуулна. (Эргэн төлсөн дүнг хассан байдлаар)

### (г) Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон бэлэн мөнгөнд үнийн өөрчлөлтийн эрсдэл багатайгаар түргэн хөрвөх богино хугацаат хөрөнгө болон бусад санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж, хөрөнгө юм.

### (д) Хөрөнгө оруулалт

Бүх хөрөнгө оруулалтыг тухайн хөрөнгө оруулалттай холбоотой гарсан зардлыг оролцуулан бодит үнэлгээг тооцож, өртгөөр нь анх бүртгэдэг.

Анх бүртгэсний дараа арилжаалахаар байршуулсан болон худалдах боломжтой гэж ангилагдсан хөрөнгө оруулалтыг бодит үнэлгээгээр нь бүртгэдэг. Арилжааны зориулалттай хөрөнгө оруулалтын ашиг алдагдлыг орлого, зарлагад бүртгэнэ. Худалдах боломжтой хөрөнгө оруулалтын ашиг/ алдагдлыг өөрийн хөрөнгийн тусгай дансанд бүртгэдэг бөгөөд тухайн хөрөнгийг худалдах, цуглуулах, хасах тохиолдолд энэхүү хуримтлагдсан ашиг/алдагдлыг орлого, зарлагад тусгадаг.

Хугацааг нь дуустал байршуулсан бонд гэх мэтийн бусад урт хугацаат хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан элэгдүүлсэн өртгөөр нь үнэлж бүртгэдэг. Элэгдүүлсэн өртгийг тооцоходоо

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

### (д) Хөрөнгө оруулалт (Үргэлжлэл)

тухайн хугацааны турш дахь хямдруулалт болон урамшууллыг авч үзнэ. Элэгдүүлсэн өртгөөр нь бүртгэсэн хөрөнгө оруулалтын ашиг/алдагдлыг түүнийг тэнцлээс хасах үед эсвэл элэгдэл тооцох үеэр орлого зарлагад бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгийн худалдан авалтыг хэлцлийн өдрөөр бүртгэдэг, өөрөөр хэлбэл хөрөнгийг худалж авахаар үүрэг хүлээсэн өдөр. Худалдсан санхүүгийн хөрөнгийг төлбөр хийх өдрөөр бүртгэдэг, өөрөөр хэлбэл хөрөнгийг харилцагчид хүргэсэн өдөр. Худалдсан болон худалдаж авсан санхүүгийн хөрөнгийг тухайн зах зээлийн зохицуулалтаар тодорхой цаг хугацаанд нь хүргэнэ.

### (е) Санхүүгийн хэрэгсэл

Монголбанк нь гадаад валютын арилжаа, хүүний своп зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг гадаад валютын ханшийн өөрчлөлт болон хүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор ашигладаг бөгөөд эдгээр санхүүгийн хэрэгслүүдийг бодит үнэлгээгээр нь үнэлж бүртгэдэг.

Гадаад валютын форвард арилжааны бодит үнэлгээг тооцохдоо ижил хугацаатай арилжааны форвард ханшийг ашигладаг. Хүүний свопын бодит үнэлгээг тооцохдоо ижил төстэй санхүүгийн хэрэгслүүдийн зах зээлийн үнэлгээг авч үздэг.

Эрсдлээс хамгаалах санхүүгийн хэрэгслийг бүртгэх зорилгоор тэдгээрийг актив, пассивын бодит үнэлгээний өөрчлөлт болон мөнгөн хөрөнгийн урсгалын өөрчлөлтийн эрсдлээс хамгаалах гэж хоёр ангилдаг.

Бодит үнэлгээний эрсдлээс хамгаалахтай холбоотойгоор (хүүний своп), санхүүгийн хэрэгслийг бодит үнэлгээгээр үнэлэхэд үүсэх ханшийн зөрүүг орлого/зарлагад шууд тусгадаг. Эрсдлээс хамгаалах санхүүгийн хэрэгслийн ашиг/алдагдлаар бүртгэлийн дунд тохируулга хийж орлого/зарлагад бүртгэдэг. Хүүний орлоготой эрсдлээс хамгаалах санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн дунд тохируулга хийхдээ цэвэр ашиг/алдагдалд хугацааг нь дуустал бүрэн элэгдүүлдэг.

Санхүүгийн хэрэгслээр (гадаад валютын форвард арилжаа) хүлээх үүргээс үүсэх эрсдлээс хамгаалах санхүүгийн хэрэгслийн арилжааны ашиг/алдаглын үр дүнтэй хэсгийг өөрийн хөрөнгөд бүртгэж, үр дүнгүй хэсгийг орлого/зарлагад бүртгэнэ.

Эрсдлээс хамгаалах санхүүгийн арилжаа биелэгдсэн үед түүнийг актив буюу пассивт бүртгэнэ. Түүнтэй холбогдолтойгоор гарсан, өмнө өөрийн хөрөнгөнд бүртгэсэн ашиг/алдагдал нь тухайн хэрэгслийн актив буюу пассив дахь бүртгэлийн дун буюу анх худалдан авсан зардалд шингэдэг.

Мөнгөн хөрөнгийн урсгалын өөрчлөлтийн эрсдэлээс хамгаалах бусад хэрэгслийн хувьд, тухайн арилжаа биелсэн үед өөрийн хөрөнгөд бүртгэсэн ашиг/алдагдлыг орлого/зарлагад шилжүүлэн бүртгэдэг.

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

### (e) Санхүүгийн хэрэгсэл (Үргэлжлэл)

Эрсдлээс хамгаалах шаардлагагүй гэж үзсэн санхүүгийн хэрэгслийн хувьд, бодит үнэлгээний өөрчлөлтөөс үүсэх ашиг/алдагдлыг тухайн хугацааны цэвэр ашиг/алдагдалд шууд бүртгэдэг.

Хамгаалах хэрэгслийн хугацаа дууссан эсвэл түүнийг худалдсан, цуцалсан эсвэл биелэгдсэн, эсвэл цаашид хамгаалах шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд түүнийг бүртгэх үйл ажиллагааг зогсоодог. Тэгэхдээ эрсдлээс хамгаалах хэрэгслийн хуримтлагдсан ашиг/алдагдлыг ирээдүйд гүйлгээ гарах хүртэл нь өөрийн хөрөнгөд бүртгэдэг. Хэрэв тухайн арилжаа биелэгүй бол өөрийн хөрөнгөд бүртгэсэн хуримтлагдсан ашиг/алдагдлыг тухайн хугацааны цэвэр ашиг/алдагдалд шилжүүлдэг.

### (ж) Үнэт металл

Мөнгөжсөн алтыг дахин үнэлснээр үлдэгдэл тэнцэлд тусгадаг бөгөөд дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Захирлуудын зүгээс дахин үнэлгээг тогтоохдоо мөнгөжсөн алтны зах зээлийн үнэ, түүний хандлага, төгрөгийн худалдан авах чадвар, төгрөгийн ханшийн өсөлт, бууралт, мөнгөжсөн алтны жигнэсэн дундаж өртөг зэргийг харгалздаг. Дахин үнэлгээний ашиг, алдагдлыг нөөцийн санд шууд тусгана. Ихэвчлэн мөнгөжөөгүй алт болон бусад үнэт металлууд жигнэсэн дундаж өртгөөрөө тайланд тусгагдсан. Зарим зоос, түүх соёлын үнэт зүйлсүүд 1995 онд дахин үнэлэгдсэн өртгөөрөө тусгагдсан болно. Алт, үнэт металлын арилжааны ашиг, алдагдлыг шууд орлогод тусгадаг.

### (ж) Үндсэн хөрөнгө

Монголбанкны үндсэн хөрөнгө нь өртгөөрөө буюу дахин үнэлгээний дүнгээс хуримтлагдсан элэгдлийг хассан дүнгээр тооцогддог. 2002 он хүртэлх хугацаанд 1994 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн Засгийн газрын 8 тоот тогтоолоор тогтоосон хувийг үндэслэж тухайн үндсэн хөрөнгийн ашиглагдахаар тооцсон хугацааны туршид элэгдлийг шулуун шугамын аргаар тооцдог байжээ. 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс барилга байшин, тавилга тоног төхөөрөмж болон компьютерийн элэгдлийг тооцох хувь хэмжээг доорх байдлаар өөрчилсөн байна.

2002 онд Монголбанк нь барилга байшигaa дахин үнэлж, дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүнг нөөцийн санд оруулан тусгасан байна. Дахин үнэлгээг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар хийлгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хувь хэмжээ:

Байшин, барилга	2.4% - 6.0%
Тавилга, тоног төхөөрөмж,	10.0% - 12.5%
Компьютер	12.5% - 20.0%
Тээврийн хэрэгсэл	12.5% - 16.7%
Баригдаж буй байшин, барилгад элэгдэл тооцдоггүй. Эдгээр активын элэгдлийг ашиглалтанд орж эхэлсэн үеэс тооцож эхлэх болно.	

## 4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД (Үргэлжлэл)

### (з) Татвар

Монголбанк нь Монгол улсын Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн дагуу орлогын татвараас чөлөөлөгднө.

#### (и) Таамаглал, тооцоо

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу Захирлууд нь санхүүгийн тайланг таамаглал тооцоон дээр үндэслэж хийх бөгөөд энэ нь актив пассивын дүн, эрсдэлтэй актив пассив, мөн орлого зарлагын дүнд нөлөөлж болох юм. Бодит дүн нь тооцоо, таамаглалаас зөрүүтэй байж болно.

#### (й) Тэтгэвэр, тэтгэмж, бусад олговрууд

Монгол улсад үйлчилж буй Төрийн тэтгэврийн системээс гадуур ажилтнууддаа тэтгэвэр, тэтгэмж олгох гэрээ хэлцэл Монголбанкинд байхгүй болно. Төрийн тэтгэврийн системийн дагуу ажилтнуудад төлж буй цалин хөлсний дүнгээс тодорхой хувиар шимтгэл тооцож төлдөг ба ажилтнуудад цалин олгосон үеийн ашиг алдагдлын тайланд уг шимтгэлийн зардлыг тусгадаг. Түүнчлэн Монголбанкинд хуримтлуулж тооцдог бусад төрлийн тэтгэвэр, тэтгэмж байхгүй болно.

## 5. ХҮҮГИЙН БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Гадаадын санхүүгийн байгууллагуудад		
байршуулсан хадгаламж, хөрөнгө	6,589	7,197
Дотоодын санхүүгийн байгууллагуудад байршуулсан		
хөрөнгө болон олгосон урьдчилгаа	91	87
Санхүү эдийн застийн яаманд (СЭЗЯ)		
олгосон зээл болон урьдчилгаа	861	673
	<b>7,541</b>	<b>7,957</b>

## 6. ХҮҮГИЙН ЗАРДАЛ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авсан зээл	105	403
Дотоодын санхүүгийн байгууллагуудын хадгаламж	179	446
Монголбанкны үнэт цаас	3,741	2,857
Бусад хүүгийн зардал	1,288	614
	<b>5,313</b>	<b>4,320</b>

## 7. БОЛЗОШГҮЙ АЛДАГДЛЫН НӨӨЦИЙН САН

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Тухайн жилд байгуулсан болзошгүй алдагдлын нөөцийн сан	-	25
Хасалт	(2)	(54)
	<hr/>	<hr/>
	(2)	(29)

## 8. ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Цалин болон ажилтнуудын урамшуулал	650	570
Харилцаа, холбоо	331	318
Ашиглалтын зардал	266	232
Тээврийн болон томилолтын зардал	179	170
Харуул хамгаалалт	199	131
Элэгдэл	503	308
Бусад	700	477
	<hr/>	<hr/>
	2,828	2,206

### Тайлант хугацаанд Монголбанкинд ажиллаж буй ажилтнуудын тоо:

	2002	2001
Ерөнхийлөгч болон захирлууд	17	15
Захиргааны ажилтнууд	83	112
Үйлчилгээний ажилтнууд	108	68
Салбар	94	91
	<hr/>	<hr/>
	302	286

## 9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Мөнгөн тэмдэгтийн зардал	2,169	3,789
Бусад	145	73
	<hr/>	<hr/>
	2,314	3,862

## 10. БЭЛЭН МӨНГӨ

	2002	2001
	сая төгрөг	сая төгрөг
Төгрөг	<b>26</b>	25
Гадаад валют	<b>13,745</b>	8,042
	<b>13,771</b>	8,067

## 11. МӨНГӨЖСӨН АЛТ БОЛОН БУСАД ҮНЭТ МЕТАЛЛ

	2002	2001
	сая төгрөг	сая төгрөг
Мөнгөжсөн алт	<b>56,019</b>	55,249
Мөнгөжөөгүй алт	<b>3,900</b>	9,756
Зоос, түүх соёлын үнэт зүйлс	<b>2,893</b>	2,573
Бусад үнэт металл	<b>198</b>	250
	<b>63,010</b>	67,828

Мөнгөжсөн алтны зах зээлийн үнэлгээ нь жилийн эцсээр 56,019 сая төгрөг болно. (2001: 56,554 сая)

## 12. ГАДААДЫН ҮНЭТ ЦААСАНД ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2002	2001
	сая төгрөг	сая төгрөг
Өрийн бичиг	<b>37,596</b>	9,927
АНУ-ын Засгийн газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	<b>13,725</b>	13,885
	<b>51,321</b>	23,812

Үнэт цаас худалдан авах, худалдах гэрээний хүрээнд 12,2 сая ам.доллараар АНУ-ын Засгийн Газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийсэн байна. (2001: 12,6 сая ам. доллар)

## 13. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХАДГАЛАМЖ, ХӨРӨНГӨ

	2002	2001
	сая төгрөг	сая төгрөг
Харилцах данс	<b>1,956</b>	2,250
Богино хугацааны хугацаатай хадгаламж	<b>179,035</b>	137,505
Олон улсын валютын санд ноогдох ЗТЭ	<b>71,401</b>	70,483
Дэлхийн Банк	<b>1,448</b>	1,497
Бусад	<b>15</b>	10
	<b>253,855</b>	211,745

Богино хугацааны хугацаатай хадгаламж нь 30 хүртэлх хоногийн хугацаатай бөгөөд жилийн 1.20%

- 6.00% хүйтэй (2001: 1.58% -5.89%). Бүх богино хугацааны хуацаатай хадгаламж нь ам.доллараар илэрхийлэгдсэн бөгөөд жилийн дундаж хүү нь 1.5% байна (2001: 1.9%).

### **13. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХАДГАЛАМЖ, ХӨРӨНГӨ (Үргэлжлэл)**

Монголбанкинд байршуулсан Зээлжих тусгай эрх нь ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө болох 47.0 сая 3ТЭ буюу 71 тэрбум төгрөг болно. Энэ дүн нь харгалзах пассиваас хасагдах (тодотгол 21-г үзнэ үү) бөгөөд түүнд хүү тооцдоггүй.

### **14. ДОТООДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ БОЛОН ОЛГОСОН УРЬДЧИЛГАА**

	2002	2001
	сая төгрөг	сая төгрөг
Богино хугацааны хугацаат хадгаламж	-	2,219
Дахин санхүүжилтын зээл	<b>130</b>	130
Төгрөгийн зээл	<b>3,631</b>	1,890
Валютын зээл	<b>4,277</b>	3,108
Бусад авлага	<b>3,486</b>	3,068
Нийт хадгаламж болон олгосон урьдчилгаа	<b>11,524</b>	10,415
Хасах нь: Болзошгүй алдагдлын нөөцийн сан	<b>(3,198)</b>	(3,198)
	<b>8,326</b>	7,217

Дахин санхүүжилтын зээлийг дотоодын банкуудад олгосон бөгөөд өнөөдрийн байдлаар эдгээр банкууд төлбөрийн чадваргүй байгаа болно. Энэ зээлд нөөцийн санг 130 сая төгрөгөөр бүрэн байгуулсан байна.

Гадаад валютын зээлийг дотоодын арилжааны хоёр банкинд олгосон бөгөөд Монголын аж ахуйн нэгжүүдэд дамжуулан олгосон байна. Энэ нь Германы застгийн газраас жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулан олгосон зээл юм. (Тодотгол 21-г үзнэ үү)

Бусад авлага нь Монголбанкны төлбөрийн чадваргүй дотоодын банкуудын нэрийн өмнөөс төлсөн 3.2 сая ам. долларын баталгааны төлбөрийг мөн багтаасан болно. Монголбанк нь энэ дүнд 2,8 сая ам.долларын болзошгүй алдагдлын санг байгуулсан байна. Монголбанк нь үлдэгдэл дунд болзошгүй алдагдлын санг нэмж байгуулах шаардлагагүй гэж үзсэн байна.

Болзошгүй алдагдлын сангийн хөдөлгөөн нь дараах байдалтай байна. Үүнд:

	2002	2001
	сая төгрөг	сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл	<b>3,198</b>	4,864
Тайлант жилд байгуулсан (Эргэн төлөгдсөнийг хасаад)	-	25
Хасагдсан сан	-	(1,691)
12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	<b>3,198</b>	3,198

## 15. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Засгийн газрын бонд	-	13,570
Хасах нь: үнэлгээний бууралтанд байгуулсан сан	-	-
	<u>-</u>	<u>13,570</u>

Үнэлгээний бууралтанд байгуулсан сангийн хөдөлгөөн

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл	-	9,806
Тухайн жилд байгуулсан сан	-	-
Хасагдсан сан	-	(9,806)
12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	<u>-</u>	<u>-</u>

## 16. САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯМАНД ОЛГОСОН УРЬДЧИЛГАА

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Ядуурлыг бууруулах, өсөлтийг хангах хөтөлбөрийн зээл	<b>39,807</b>	38,314

Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах хөтөлбөрийн (хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр) хүрээнд нийт олгосон зээлийн СЭЗЯ-ны хариуцах хэсгийг оны эцсийн байдлаар харуулсан болно. Мөн энэ зээл нь Гадаад валютын пассив нэрээр тэнцлийн пассивт бүртгэгдсэн болно. (Тодотгол 21-г үзнэ үү)

## 17. КОМПАНИУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Дотоодын компаниудад олгосон зээл	<b>86</b>	868
Бусад зээл	<b>165</b>	165
	<b>1,032</b>	1,033
Хасах нь: Болзошгүй алдагдлын сан	<b>(867)</b>	(868)
	<b>165</b>	165

Дотоодын компанид олгосон зээл нь Монголбанк санхүүгийн бус байгууллагуудад зээл олгохыг хориглосон журам гарахаас өмнөх зээлд хамааралтай юм. Монголбанк нь эдийн засгийг сайжруулах зорилгоор дотоодын компаниудад энэ зээлийг олгож байсан. Эдгээр зээлүүд нь эргэж төлөгдөөгүй бөгөөд эдгээр зээлд болзошгүй алдагдлын санг бүрэн байгуулжээ.

## 17. КОМПАНИУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (Үргэлжлэл)

Бусад зээл нь Нэгдсэн Үндэстний хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд дотоодын санхүүгийн байгууллагуудад олгосон зээл бөгөөд түүний хүүний авлага болох 14,0 сая төгрөг (2001: 14.0 сая) энд багтсан болно. Энэхүү зээлийг Монголбанк банк бус санхүүгийн байгууллагууд болон Монголын эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор дамжуулан олгож байгаа болно. Энэ дүнгээр холбогдох пассивт байршиж байгаа. (Тодотгол 21-г үзнэ үү)

Болзошгүй алдагдлын сангийн хөдөлгөөн нь дараахь байдалтай байна. Үүнд:

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
1 дүгээр сарын 1-ний өдрийн үлдэгдэл	<b>868</b>	903
Эргэн төлөгдсөн	<b>(1)</b>	(35)
12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл	<b>867</b>	868

## 18. БУСАД АКТИВ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Үүсмэл санхүүгийн хэрэгсэлүүд	<b>922</b>	-
Бусад	<b>178</b>	116
	<b>1,100</b>	116

Үүсмэл санхүүгийн хэрэгсэлүүд 357,000 төгрөгийн бодит үнэлгээтэй мөнгөжсөн алтны форвард болон 921,960,000 төгрөгийн бодит үнэлгээтэй опшин хэлцлийн цэвэр позици багтсан болно. 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бүх нээлттэй позици нь тухайн харилцагчтайгаа хугацаандаа хаагдсан байна.

Бусад актив нь ажилтнуудад олгосон урьдчилгаа, материал болон бичиг хэргийн хэрэгслээс бүрдэж байна.

Монголбанк нь 1999 онд гадаадын санхүүгийн байгууллагатай своп гэрээ хийсэн ба гэрээний хугацаа нь 2004 онд дуусна. Энэ гэрээний дагуу Монголбанк нь 32,000 унци мөнгөжсөн алтыг 8.2 сая ам.доллараар арилжсан бөгөөд гэрээнд заасан хугацаа дуусах үед энэ алтыг гэрээний үнээр буцаан худалдан авах үүрэг хүлээсэн. Монголбанк нь харилцагч этгээддээ ханшийн зөрүүг нөхөх зорилгоор алтны унциар илэрхийлэгдсэн хүүг жил тутам төлдөг болно. Монголбанкны зүгээс энэ гэрээг хүчингүй болгох эрхгүй. Монголбанкны энэхүү гэрээнээс хүлээх ашиг, алдагдал нь ам. доллар болон алтны хүүгийн ханшийн зөрүүнээс шалтгаална. Монголбанк нь энэ арилжаанаас үлэмж хэмжээний алдагдал хүлээнэ гэж үзэхгүй байна.

## 19. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

сая төгрөг	Байшин барилга		Тавилга тоног төхөөрөмж		Компьютер		Тээврийн хэрэгсэл		Баригдаж буй барилга		Нийт	
	2002	2001	2002	2001	2002	2001	2002	2001	2002	2001	2002	2001
<b>Оны эхний Үлдэгдэл, хууримтлагдан</b>												
Элэгдлийг хассан дүн	<b>10,124</b>	10,171	<b>303</b>	301	<b>466</b>	295	<b>220</b>	191	<b>1,167</b>	-	<b>12,280</b>	10,958
Нэмэгдсэн хөрөнгө	<b>99</b>	88	<b>98</b>	47	<b>91</b>	270	<b>177</b>	104	<b>1,361</b>	1,167	<b>1,826</b>	1,676
Хасагдсан хөрөнгө	(307)	(8)	(6)	(3)	-	(8)	(8)	(27)	(363)	-	(684)	(46)
Дахин үнэлгээ	<b>605</b>	-	-	-	-	-	-	-	-	-	<b>605</b>	-
Элэгдэл	(250)	(127)	(48)	(42)	(142)	(91)	(63)	(48)	-	-	(503)	(308)
<b>Оны эцсийн Үлдэгдэл, хууримтлагдан</b>												
Элэгдлийг хассан дүн	<b>10,271</b>	10,124	<b>347</b>	303	<b>415</b>	466	<b>326</b>	220	<b>2,165</b>	1,167	<b>13,524</b>	12,280
<b>Үндсэн хөрөнгө</b>												
Өргөг	<b>10,784</b>	10,396	<b>537</b>	454	<b>798</b>	732	<b>554</b>	390	<b>2,165</b>	1,167	<b>14,838</b>	13,139
Хууримтлагдан элэгдэл	(513)	(272)	(190)	(151)	(383)	(266)	(228)	(170)	-	-	(1,314)	(859)
Бүртгэлийн цэвэр дүн	<b>10,271</b>	10,124	<b>347</b>	303	<b>415</b>	466	<b>326</b>	220	<b>2,165</b>	1,167	<b>13,524</b>	12,280

Монголбанк нь 2002 онд мэргэжлийн үнэлгээний байгууллагаар барилгыг дахин үнэлүүлж, дахин үнэлгээний зөryүү 605 сая төгрөгөөр (2001: тэг) барилгын өртгийг нэмэгдүүлсэн байна.

## 20. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Төв банкны үнэт цаас нь Монголбанкнаас дотоодын санхүүгийн байгууллагуудад гаргасан үнэт цаас. Үнэт цаасны хугацаа нь нэг долоо хоногоос гурван сар бөгөөд жилийн хүү нь 12% - 14,5% байна.(2001: 7% - 15%)

## 21. ГАДААД ВАЛЮТЫН ПАССИВ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Олон улсын валютын сан(ОУВС)		
- ЯБӨХХ-ийн зээл	<b>47,609</b>	51,528
- ЗТЭ-ийн хувь хандивтай холбогдуулан гаргасан үнэт цаас	<b>71,401</b>	70,483
Гадаадын Засгийн газар болон олон улсын		
байгууллагуудаас авсан зээл	<b>9,703</b>	5,586
Дэлхийн Банк ба ОУХАгентлагт оруулсан хувь хөрөнгө	<b>1,840</b>	1,597
Олон улсын байгууллагуудад оруулсан хувь хөрөнгө	<b>151</b>	151
	<b>130,704</b>	129,345

Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах хөтөлбөрийн (хуучин нэрээр Бүтцийн өөрчлөлтийг дэмжих хөтөлбөр) хүрээнд ОУВС-аас олгосон зээл нь 10 жилийн хугацаатай, жилийн 0.5% хүүтэй, хөтөлбөрийн сүүлийн 5 жилийн туршид жил бүр тогтмол хэмжээтэйгээр төлөгдөх бөгөөд Монголбанкны төлбөр 2003 онд дусна. Энэ зээл нь ЗТЭ-ээр илэрхийлэгддэг.

Гадаадын Засгийн газар болон Олон улсын байгууллагуудын олгосон зээлд жижиг, дунд аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор Германы Засгийн Газраас 1995 онд олгосон зээл орж байгаа юм. Зээл нь 40 жилийн хугацаатай, жилийн 1% хүүтэй. Үндсэн зээлийн эргэн төлөлт нь 2005 онд эхэлнэ. (Тодотгол 14-г үзнэ үү)

Олон улсын байгууллагуудын хувь хөрөнгө нь банк бус санхүүгийн байгууллагуудыг хөгжүүлэх зорилгоор Нэгдсэн Үндэсний Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон туслалцаа юм. Энэхүү эх үүсвэрийг жижиг зээлээр дамжуулан орлого багатай хүмүүст олгож байна. (Тодотгол 17-г үзнэ үү)

ЗТЭ-ийн хувь хандивтай холбогдуулан гаргасан үнэт цаасны эсрэг данс нь активт байршдаг бөгөөд хүү бодогддоггүй. (Тодотгол 13-г үзнэ үү)

## 22. САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ ХАДГАЛАМЖ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Улсын төсвийн данс	<b>19,091</b>	13,306

СЭЗЯ-ны хадгаламж нь СЭЗЯ-ны нэрийн өмнөөс Монголбанкны татан төвлөрүүлсэн хөрөнгө бөгөөд эдгээр дансадад хүү тооцдоггүй, анхны шаардлагаар төлбөр нь гүйцэтгэгддэг.

## 23. ДОТООДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАДГАЛАМЖ

Эдгээр хадгаламжууд нь дотоодын санхүүгийн байгууллагуудаас байршуулсан харилцах дансанд хамааралтай бөгөөд Монголбанкинд байршуулсан банкуудын заавал байлгах нөөц орно. Банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгөнд тодорхой хувиар тооцож заавал байлгах нөөцийг тогтоодог бөгөөд 2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилд хүү тооцоогүй байна. (2001 онд жилийн хүү 4,8%-12.6%)

## 24. БУСАД ПАССИВ

Бусад пассивт засгийн газрын бусад байгууллагуудын Монголбанкинд байршуулсан нийт 14.49 тэрбум төгрөг /2001 онд 3.62 тэрбум/ бүхий дансууд орно. Түүнчлэн бусад пассивт 5.38 тэрбум /2001 онд 2.91 тэрбум/ төгрөг бүхий нийгмийн хөгжлийн сангийн данс орно. Энэ сан нь ажилтнуудын нийгмийн хангамжинд зориулагдсан болно.

## 25. ДҮРМИЙН САН

Монголбанк нь 100 хувийн Төрийн өмч болно. Дүрмийн сан нь Банкны өөрийн хөрөнгө юм. 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс Банкны дүрмийн санг 5 тэрбум төгрөгт хүргэж нэмэгдүүлэхээр хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Энэ нь хуваарилагдаагүй ашгаас өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар хийгдсэн болно

## 26. НӨӨЦИЙН САНГУУД

Нөөцийн сангүүд нь Ерөнхий Нөөцийн Сан, Дахин Үнэлгээний Сан болон Гадаад Валютын Дахин Үнэлгээний Сангүүдаас бүрдэнэ.

Монгол Улсын Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу Төв банкны жилийн цэвэр ашгийн 40-өөс доошгүй хувийг ерөнхий нөөцийн санд хуваарилж, үлдэх хэсгийг Улсын төсөвт шилжүүлдэг. Харин 2002 онд Засгийн газар нь 5,0 тэрбум төгрөгийг Улсын Төсөвт шилжүүлэх шийдвэр гаргаснаас Монголбанк Ерөнхий нөөцийн санд хөрөнгө хуваарилаагүй байна.(Тодотгол 27-г үзнэ үү)

Дахин үнэлгээний санд худалдах боломжтой санхүүгийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг бүртгэдэг. Гадаад валютын дахин үнэлгээний санг дахин үнэлгээний санд нэгтгэснээр цаашид хэрэглэхээ больсон байна.

## 27. УЛСЫН ТӨСӨВТ ШИЛЖҮҮЛСЭН НЬ

Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Монголбанк нь өнгөрсөн оны хуваарилагдаагүй ашгаас 5.95 тэрбум төгрөгийг, тухайн жилийн ашгаас 5.0 тэрбум төгрөгийг Улсын Төсөвт шилжүүлсэн байна. Түүнчлэн Санхүү Эдийн Засгийн Яамны хүсэлтээр Монголбанк нь 7.4 тэрбум төгрөгийг Дахин үнэлгээний сангаас Улсын Төсөвт шилжүүлсэн байна.

## 28. БЭЛЭН МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛГАХ ХӨРӨНГӨ

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь тайлан тэнцэлд дараах байдлаар илэрхийлэгдэнэ:		
Бэлэн мөнгө	13,771	8,067

## 29. САНХҮҮГИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БОЛОН БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

### a) Гадаад валютын арилжаагаар хүлээсэн үүрэг, деривативууд

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Мөнгөжсөн алтны фьючерс арилжаа	-	38,779
Гадаад валютын фьючерс арилжаа	-	57,694
	<b>96,473</b>	

Монголбанк нь 2002 онд НББОУ 39 дүгээр стандартыг мөрдөж эхэлснээр мөнгөжсөн алтны болон гадаад валютын фьючерс арилжааны цэвэр позициг тайлан тэнцэлд бүртгэдэг болсон.(Тодотгол 27-г үзнэ үү)

### б) Баталгаанууд

	2002 сая төгрөг	2001 сая төгрөг
Гаргасан баталгаа	-	480

2001 оны гаргасан баталгаа нь Засгийн газраас гуравдагч этгээдэд гаргасан өрийн бичигтэй холбоотойгоор Монголбанкнаас гаргасан 435 мянган ам.долларын баталгаа юм. Иймэрхүү баталгааг 2002 онд Засгийн газраас гаргаагүй болно.

### в) Хууль зүй

Банкны ердийн үйл ажиллагааны явцад Монголбанкны эсрэг өдүүлсэн зарга нэхэмжлэл гарч болох боловч түүний үр дүнд хүлээж болзошгүй үүрэг их хэмжээтэйгээр байхгүй гэж Монголбанкны Захирлуудын Зөвлөл үзэж байна.

### г) Түрээсийн үүрэг

2002 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкинд түрээсийн гэрээгээр хүлээсэн үүрэг байхгүй болно.

## 29. САНХҮҮГИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ БОЛОН БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС (ҮРГЭЛЖЛЭЛ)

### д) Хөрөнгийн үүрэг

Монголбанкны Захирлуудын Зөвлөл нь төв байрны ойролцоо шинээр барилга барихад зориулж ойролцоогоор 2,4 тэрбум төгрөгийг зарцуулахаар 2001 оны 7 дугаар сарын 20-ны өдөр шийдвэрлэсэн. Энэ дүнг 2,88 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Тайлан гаргах өдрийн байдлаар энэ хөрөнгийн 60% буюу ойролцоогоор 1,5 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.

## 30. ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

Монголбанкны үйл ажиллагаанд зах зээлийн, зээлийн, хүүгийн, төлбөрийн чадварын, үйл ажиллагааны, нэр хүндийн зэрэг эрсдлүүд байдаг бөгөөд Монголбанкны Захирлуудын Зөвлөлөөс эдгээр эрсдлийг удирдаж, холбогдох журам, заавар, шийдвэрийг гаргаж байна.

Гадаад валютын улсын нөөцийг удирдахад тулгардаг зээлийн, зах зээлийн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын, үйл ажиллагааны эрсдлүүдэд тулхүү анхаарч, эдгээрийг тодорхойлж, эрсдлийг хянах, зайлсхийх, бууруулах, тодорхой түвшинд зохицуулан хянах арга хэмжээнүүдийг "Гадаад валютын нөөцийн удирдлагын журам"-д тусгасан. Үүнд:

### (а) Зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор:

- Нөөцийг хамгийн эрсдэл багатай, найдвартай активт байршуулах талаар ихээхэн анхаарсан. Тухайлбал, нөөцийг АНУ, Япон, ХБНГУ, Англи, Швейцари улсын Төв банк дахь харилцах данс, AAA болон AA зэрэглэлтэй арилжааны банкууд дахь хадгаламж, ийм орнуудын Засгийн газрын үнэт цаас, олон улсын болон бүс нутгийн санхүүгийн байгууллагын үнэт цаас зэрэгт байршуулахаар заасан.
- Нөөцийн зарим хэсгийг уламжлалт харилцаатай арай доод зэрэглэлийн улс орон, банкинд активыг байршуулж байна. Ийм нөхцөлд тухайн тохиолдол бүрийг тусгайлан авч үзэж, холбогдох тооцоо судалгаа хийн асуудлыг Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж шийдвэрлүүлж байна.
- Мөн нөөцийн активыг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох лимитийг улирал бүр батлуулж байна.

### (б) Зах зээлийн эрсдлийг тодорхой түвшинд байлгаж, хянан зохицуулж байх үүднээс:

- Нөөцийн активын ерөнхий бүтцийг жилээр;
- Алт болон гадаад валютын нийт нээлттэй позицийн лимитийг улирлаар;
- Санхүүгийн хэрэгсэл тус бүрээр нээлттэй позицийн лимитийг улирлаар;
- Дилер тус бүрийн стоп-лосс лимитийг улирлаар тус тус батлуулан мөрдөж байна.

## 30. ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО (Үргэлжлэл)

### (в) Гадаад нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдлийг удирдах зорилгоор:

- харилцах дансны үлдэгдэл, касс дахь бэлэн валютын доод хэмжээ;
- тодорхой хугацаагаар байршуулах активын доод, дээд хэмжээг тус тус тогтоосон;
- активын тодорхой хэсгийг долоо хоног тутам эргэлтэд орж байхаар зааж үйл ажиллагаандаа баримталж байна.

### (г) Гадаад нөөцийн үйл ажиллагааны эрсдлийг удирдах зорилгоор:

- арилжааны хэсэг, арын албыг салган өөр өөр газарт харьялуулан ажиллуулдаг;
- гадаад арилжаанд оролцогч бүх этгээд, хэсэг тус бүрийн хийж гүйцэтгэх ажил үүргийг тодорхой зааж, зааварт тусган мөрдүүлсэн;
- нээлттэй позицийн лимит, стоп-лосс лимитийг дилер тус бүрт валют, хэрэгсэл тус бүрээр улирал бүр хуваарилан баталдаг;

Мөн хэлцэл, гүйлгээ хийхэд давхар болон хөндлөнгийн хяналт байх зарчим, мэдээ тайлан өөр өөрийн эх үүсвэрээс удирдлагад шууд очиж байх журам тогтоосон болно.

Монголбанк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу Засгийн газар болон банкинд зээл олгодог.

